



ХӨДӨЛМӨРИЙН
ЯАМ



Монгол Улсын Хөдөлмөрийн яамны харьяа
Хөдөлмөрийн судалгааны институт

ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА

Тайланг хянасан:

М.Чимэддорж, Хөдөлмөрийн судалгааны институтын захирал

Хэвлэлд бэлтгэсэн:

Ц.Баярмаа, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгаа, шинжилгээний секторын эрхлэгч

Мэдээллийг боловсруулсан:

Эрдэм шинжилгээний ажилтан

Д.Алтангэрэл, Н.Жаргалсайхан, Г.Мягмардулам, Н.Насантогтох, А.Дэлгэрсайхан

Хэвлэсэн тоо: 300 хувь

Цаасны хэмжээ: В5

"Мөнхийн Үсэг" ХХК-д хэвлэв

Улаанбаатар 2013 он

ГАРЧИГ

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ОРШИЛ	6
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ	7
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА	13
1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	13
1.2 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ	13
1.3 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ	14
1.4 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ	16
1.5 СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	16
БҮЛЭГ 2. 2011 ОНД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧИЙН БҮТЭЦ БОЛОН СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН	17
2.1 ТӨГСӨГЧИЙН ХҮН-АМ ЗҮЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	17
2.2 ТӨГСӨГЧИЙН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖЛИЙН ТАРХАЛТ	19
2.3 ТӨГСӨГЧИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ	21
БҮЛЭГ 3. ТӨГСӨГЧИЙН СУРГУУЛЬ, МЭРГЭЖЛИЙН ТАЛААРХ ҮНЭЛЭМЖ	28
3.1 СУРГУУЛЬ, МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН ШАЛТГААН, СЭТГЭЛ ХАНАМЖ	28
3.2 ДАХИН СУРАЛЦАГСАД	33
БҮЛЭГ 4. ТӨГСӨГЧИЙН СУРАЛЦАХ ХУГАЦААНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	37
4.1 ТӨГСӨГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, МЭРГЭЖЛИЙН НИЙЦЭЛ	37
4.2 АЖИЛД ОРОХ ҮЙЛ ЯВЦ, БЭРХШЭЭЛ	40
4.3 ТӨГСӨГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОО	45
БҮЛЭГ 5. ТӨГСӨГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	47
5.1 ӨНӨӨГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ	47
5.2 ТӨГСӨГЧИЙН АЖЛЫН ТУРШЛАГЫН БАЙДАЛ	49
5.3 ТӨГСӨГЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ, ОНЦЛОГ	52
БҮЛЭГ 6. ТӨГСӨГЧИЙН АЖИЛ ХАЙХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨГӨӨ	70
6.1 АЖИЛ ХАЙХ ЗОРИЛГО, ШАЛТГААН	70
6.2 АЖИЛ ХАЙХ ХЭЛБЭР, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ	75
ДҮГНЭЛТ	81
ХАВСРАЛТЫН ХҮСНЭГТ	85

ХҮСНЭГТ, ЗҮРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын туршлага	8
Зураг 2. ИДС төгсөгчийн ажлын туршлага /салбар, ажил мэргэжлээр/	9
Зураг 3. МСҮТ төгсөгчийн ажлын туршлага /салбар, ажил мэргэжлээр/	9
Зураг 4. Төгсөгчдийн хүн ам зүйн зарим үзүүлэлт	18
Зураг 5. Өнгөрсөн 3 сарын хугацаанд эцэг, эхээсээ авсан дэмжлэг	19
Зураг 6. ИДС төгсөгчдийн мэргэжлийн тархаалт/сургуулийн өмчийн хэлбэрээр/	20
Зураг 7. МСҮТ төгсөгчдийн мэргэжлийн тархаалт/сургуулийн өмчийн хэлбэрээр/	21
Зураг 8. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал /бүсээр/	22
Зураг 9. Төгсөгчдийн судалгааны мэдээлэл цуглуулах хугацааны өмнөх 7 хоногт ажил хийгээгүй шалтгаан	26
Зураг 10. Төгссөн сургуулийг сонгон суралцсан шалтгаан	28
Зураг 11. Төгссөн сургуулийн сонгон суралцсан шалтгаан /сургуулийн төрлөөр/	29
Зураг 12. Төгсөгчдийн мэргэжил сонголтын шалтгаан	30
Зураг 13. Төгсөгчдийн мэргэжил сонголтын шалтгаан /сургуулийн төрлөөр/	31
Зураг 14. Дахин суралцагсдын сургалтын төрөл /сургуулийн төрлөөр/	33
Зураг 15. Дахин суралцаж буй шалтгаан	34
Зураг 16. Одоо суралцаж буй болон өмнө эзэмшсэн мэргэжлийн нийцлийн түвшин /сургуулийн төрлөөр/	35
Зураг 17. Адил мэргэжлийг сонгон суралцаагүй шалтгаан /сургуулийн төрлөөр/	36
Зураг 18. Суралцах хугацаанд ажил хийсэн шалтгаан	38
Зураг 19. Суралцах хугацаанд ажил хийсэн шалтгаан /сургуулийн төрлөөр/	38
Зураг 20. Суралцах хугацааны ажлын туршлага болон мэргэжлийн нийцэл /сургуулийн төрлөөр/	39
Зураг 21. Ажлын байрны мэдээллийн эх сурвалж /сургуулийн төрлөөр/	42
Зураг 22. Ажил хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаанд тулгардаг бэрхшээл	43
Зураг 23. Ажил хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаанд тулгардаг бэрхшээл /сургуулийн төрлөөр/	44
Зураг 26. Ажлын байртай байсан ч ажил хийгээгүй шалтгаан /сургуулийн төрлөөр/	47
Зураг 27. Ажил хийгээгүй төгсөгчдийн ажил хайгаагүй шалтгаан /сургуулийн төрлөөр/	48
Зураг 28. Төгсөгчдийн ажлын туршлагын байдал /сургуулийн төрлөөр/	49
Зураг 29. Ажлын туршлагатай төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	53
Зураг 30. Ажлын туршлагатай төгсөгчдийн ААНБ-ын ажилтны тоо /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	54
Зураг 31. Ажлын туршлагатай төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн статус /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	55
Зураг 32. Цалин хөлстэй ажилтны хөдөлмөрийн гэрээтэй, гэрээгүй байдлын бүтэц /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	56
Зураг 33. Ажлын туршлагатай төгсөгчдийн ажил олгогч байгууллагын хэлбэр	57
Зураг 34. Төгсөгчдийн ажил хайх байдал /сургуулийн төрлөөр/	70
Зураг 35. Төгсөгчдийн ажил хайж буй зорилго /сургуулийн төрлөөр/	71
Зураг 36. Ажил хайгчийн ажлаа солих шалтгаан /сургуулийн төрлөөр/	76
Зураг 37. Ажил хайх хэлбэр /сургуулийн төрлөөр/	75

Зураг 38. Төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө	76
Зураг 39. Төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө /сургуулийн төрлөөр/	77
Зураг 40. Ажил хайх хичээл, зүтгэлийн төрөл	78
Хүснэгт 1. Эх олонлогийн ерөнхий мэдээлэл	14
Хүснэгт 2. Түүврийн хэмжээг тодорхойлсон байдал	15
Хүснэгт 3. Түүврийн хэмжээг хуваарилсан байдал	15
Хүснэгт 4. Хүн ам зүйн ерөнхий төлөв байдал /төгсөгчдийн хүйс, нас, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал/	17
Хүснэгт 5. ИДС төгсөгчдийн судалгааны мэдээлэл цуглуулах хугацааны өмнөх 7 хоногийн хөдөлмөр эрхлэлтийн байдал /мэргэжлийн чиглэлээр/	23
Хүснэгт 6. МСҮТ төгсөгчдийн судалгааны мэдээлэл цуглуулах хугацааны өмнөх 7 хоногийн хөдөлмөр эрхлэлтийн байдал /мэргэжлийн салбараар/	25
Хүснэгт 7. Төгссөн сургуулийн талаарх төгсөгчдийн сэтгэл ханамж /сургуулийн төрөл болон өмчийн хэлбэр тус бүрээр/	32
Хүснэгт 8. Ажилд орох хүсэлт гаргахад анхаардаг хүчин зүйл /сургуулийн төрлөөр/	40
Хүснэгт 9. Хөдөлмөрт бэлтгэх, сургалт хөтөлбөрт хамрагдсан байдал /сургуулийн төрлөөр/	45
Хүснэгт 10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны оролцоо /сургуулийн төрлөөр/	46
Хүснэгт 11. Төгсөгчдийн ажилд ортол зарцуулах хугацаа /хүйс, сургуулийн байршлаар/	51
Хүснэгт 12. Ажлын туршлагатай төгсөгчдийн ажлын байрны нөхцөл /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	59
Хүснэгт 13. Ажлын байрны сэтгэл ханамж /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	59
Хүснэгт 14. Боловсролын түвшин, ажил үүргийн нийцтэй байдал /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	60
Хүснэгт 15. Ажил үүргийн шаардлага, ур чадварын нийцтэй байдал /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	61
Хүснэгт 16. Ажлын байран дахь ур чадварын хомсдол /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	62
Хүснэгт 17. Ажлын байранд дасан зохицоход тулгардаг бэрхшээл /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	64
Хүснэгт 18. Ажлын байранд ороход нөлөөлдөг хүчин зүйл /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/	65
Хүснэгт 19. Ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдал /сургуулийн төрлөөр/	67
Хүснэгт 20. ИДС төгсөгчдийн ажил хайх үйл явцын мэдээлэл	72
Хүснэгт 21. МСҮТ төгсөгчдийн ажил хайх үйл явц	73
Хүснэгт 22. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээлэл	80
Хавсралтын хүснэгт 1. Суралцах хугацааны ажлын туршлага, мэргэжлийн нийцэл /мэргэжлийн чиглэл, сургуулийн төрөл тус бүрээр/	85
Хавсралтын хүснэгт 2. Ажилд ороход анхаардаг хүчин зүйл /сургуулийн төрөл, мэргэжлийн чиглэл тус бүрээр/	86
Хавсралтын хүснэгт 3. Төгсөгчдийн мэргэжил, ажилладаг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын харьцуулсан мэдээлэл /сургуулийн төрлөөр/	88
Хавсралтын хүснэгт 4. Төгсөгчдийн ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдал /мэргэжлийн чиглэл тус бүрээр/	90
Хавсралт хүснэгт 5. Төгсөгчдийн мэргэжил, ажилладаг ажил мэргэжлийн харьцуулалт /мэргэжлийн чиглэл, ажил мэргэжлийн дэд бүлэг тус бүрээр/	92

ОРШИЛ

Шинээр байгуулагдсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 60-аас дээш хувь нь хүн амыг ажилтай, орлоготой болгоход чиглэж байгаатай холбоотойгоор төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажил хийгдэж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ нийгмийн тодорхой зорилтот бүлгүүдэд чиглэсэн хэлбэрээр зохион байгуулагдахаар хууль эрхзүйн орчны зохицуулалт хийгдсэн. Тиймээс эдгээр зорилтот бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийн багц асуудлыг судлан тодорхойлсон төрөлжсөн судалгаануудыг гүйцэтгэх хэрэгцээ байгаа ба ялангуяа хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн талын томоохон бүлэг болох мэргэжлийн сургалтын байгууллага төгсөгчдийн судалгааг нэн даруй хийх нь чухал ач холбогдолтой юм. Энэхүү багц судалгааны хүрээнд нэн түрүү хөндөн судлах шаардлагатай дараах асуудлууд байдаг. Үүнд:

- Сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон түүний зөрүүгийн тухай олонтоо ярих болсон. Зах зээлд бэлэн байгаа ажлын байрны шаардлагад сургалтын байгууллагаас нийлүүлэгдэж байгаа шинэ мэргэжилтэй ажилтнууд нийцэж чадаж байгаа тухай асуудал нь үүнтэй холбоотой нэгэн багц судлагдахуун юм.
- Манай улсын нийт ажилгүйчүүдийн дунд хөдөлмөрийн бүтээмж хамгийн өндөртэй залуус буюу 15-35 насныхны эзлэх хувь өндөр байдаг. Ялангуяа мэргэжилтэй, боловсролтой ч эдийн засгийн үйл ажиллагаанд оролцдоггүй залуус цөөнгүй байдаг нь судалгаа, мэдээллээр гардаг. Тиймээс залуусын ажилгүйдэл дэх шинээр сургууль төгсөгчдийн эзлэх хэмжээ, учир шалтгааныг тодорхойлох нь нэн чухал юм.

Сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа хийгддэггүй, салбарын яам, сургалтын байгууллагаас зарлаж байгаа статистик мэдээлэл нь өөрөө эргэлзээтэй бөгөөд баталгаатай мэдээлэл байж чаддаггүй. Иймээс төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг бүтэц, төлөв байдал, онцлог, хүндрэл бэрхшээл зэрэг олон талаас нь цогцоор судлах хэрэгцээ байгаа учраас Хөдөлмөрийн судалгааны институт нь анх удаа улсын хэмжээнд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гүйцэтгэлээ.

Бид судалгааны арга зүй, ялангуяа түүврийн арга зүйд олон улсад өргөн хэрэглэгддэг шинжлэх ухааны аргазүйг ашигласан бөгөөд, мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл явцын олон шатат хяналтын аргыг хэрэглэсэн учраас судалгааны үр дүн нь итгэж болох мэдээлэл болж чадсан гэж үзэж байгаа юм.

Та бүхэн судалгааны үр дүнгийн мэдээлэлтэй танилцан, үйл ажиллагаандаа ашиглаж, санал бодлоо солилцож, үнэтэй санал зөвлөмж ирүүлж хамтран ажиллахыг хүсье.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Манай улсад хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдал, хэтийн чиг хандлагыг тодорхойлох судалгаа шинжилгээний ажил төдийлөн хөгжөөгүй, сүүлийн жилүүдэд зарим төсөл, хөтөлбөрийн хүрээнд цөөн тооны судалгаанууд хийгдэж, энэ төрлийн судалгааны ажлын тоо, чанарт ахиц дэвшил гарч байгаа билээ. Хийгдэж буй судалгаанууд ихэвчлэн ажиллах хүчний эрэлттэй холбогдож байгаа ба, тэрхүү эрэлтийг хангах ажиллах хүчний нийлүүлэлтийг судалсан, ялангуяа сургалтын байгууллагын нийлүүлэлтийн талаарх дэлгэрэнгүй судалгаа, мэдээлэл тун хомс байдаг.

Хөдөлмөрийн судалгааны институт нь “Дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагыг 2011 онд төгссөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түүвэр судалгаа”-г анх удаа улсын хэмжээнд хийж гүйцэтгэлээ.

Судалгааны үндсэн зорилго нь төгсөгчдийн мэргэжил, ур чадварын хөгжил болон хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг судалж дүн шинжилгээ хийх замаар боловсрол болон хөдөлмөрийн зах зээл хоорондын зүй тогтолт холбоог харуулсан мэдээллийг бий болгох, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн үр ашигтай бодлого боловсруулахад ашиглах суурь мэдээллээр хэрэглэгчдийг хангахад оршиж байгаа юм. Судалгааны хүрээнд сонирхон судалсан асуудал нь өргөн хүрээг хамарсан учраас хураангуйд үндсэн зорилттой шууд холбоотой үр дүнгүүдийн талаар түлхүү танилцуулна. Төгсөгчдийн хүн ам зүйн төлөв байдал, ахуй амьдрал, гэр бүлийн байдал, сургууль, мэргэжил сонголтын шалтгаан, сэтгэл ханамж, суралцах болон төгссөний дараах хугацааны хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны онцлог, хүндрэл бэрхшээл, эдийн засгийн үйл ажиллагааны оролцооны богино хугацааны төлөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

чиглэлээр хэрэгжиж буй арга хэмжээний талаарх ойлголт, оролцооны талаар тайлангийн үндсэн мэдээллийн хэсгээс дэлгэрүүлэн үзэх боломжтой.

2010-2011 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ИДС болон МСҮТ-ийг нийт 54,5 мянган залуус төгссөн статистик байдаг. Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн чиглэлийг гол шалгуур болгон пропорциональ магадлалт, энгийн санамсаргүй түүврийн аргыг ашиглан 1495 төгсөгч /ИДС төгсөгч 982 болон МСҮТ төгсөгч 513/-ийг сонгон судалсан. Мэдээлэл цуглуулалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, эхний үе шатанд түүвэрт сонгогдсон төгсөгчтэй холбоо барих хаягыг тодорхойлох зорилгоор сургууль, анги даасан багштай уулзах, 2 дугаар үе шатанд зорилтот бүлэгтэй холбоо тогтоон байгаа байршилд нь очиж судалгаанд хамруулсан. Судалгааны үр дүнг ИДС-ийг 2011 оны хавар бакалавраар төгсөгч болон нийт МСҮТ төгсөгчдөд тархаасан ба нийт төгсөгчийн тоо 45,0 мянга болж байгаа юм.

Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн дундаж нас 24, 71.8 хувь буюу 32,3 мянга нь гэрлээгүй, 57.0 хувь буюу 25,9 мянга нь бакалавр, 40.0 хувь буюу 18,1 мянга нь мэргэжлийн боловсролтой, өрхийн гишүүдийн дундаж тоо 3.9, судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд 60.7 хувь буюу 27,4 мянга нь эцэг эхтэйгээ хамт амьдардаг, 53.9 хувь буюу 24,3 мянган төгсөгчийн өрхийн сарын дундаж орлого 501,0 мянгаас 1,0 сая төгрөг, төгсөгчид эцэг эхээсээ ахуй хангамж, эдийн засгийн хувьд хараат байдалтай, ялангуяа хүнсний дэмжлэг түлхүү авдаг зэрэг хүн ам зүйн болоод амьдралын төлөв байдлын онцлогийг харуулсан.


Судалгаанд төгсөгчдийн мэргэжлийн мэдээллийг боловсролын салбарт 2010 оноос хойш мөрдөж буй дээд боловсролын мэргэжлийн 22 чиглэл, мэргэжлийн

боловсролын 11 салбар, мэргэжлийн түвшинд нэгтгэн авч үзсэн ба, мэргэжлийн хувьд ИДС төгсөгчдөөс бизнес удирдлага, багш боловсрол судлалын мэргэжилтэн, МСҮТ төгсөгчдөөс барилга, авто зам,

барилгын материал үйлдвэрлэлийн салбарын мэргэжилтэй ажилтнууд бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад хамгийн олноор хамрагдсан.

Зураг 1. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажлын туршлага

Хэмжих нэгж: тоо




Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судлах явцад сургуульд суралцах хугацааны хөдөлмөр эрхлэлт, өнөөгийн хөдөлмөр эрхлэлт, олон ажлын туршлагатай төгсөгч, ажлын туршлага багатай буюу нэг л ажил хийж байгаа төгсөгч, ажлын туршлагагүй буюу огт ажил хийж байгаагүй төгсөгч зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон хэв шинжүүдийг харуулсан бүлгүүд торхойлогдож байгаа юм.

Мэдээлэл цуглуулах хугацааны өмнөх 7 хоногийн байдлаар төгсөгчдийн өнөөгийн хөдөлмөр эрхлэлтийг судалж үзэхэд нийт төгсөгчдийн 63.4 хувьтай тэнцэх 28,6 мянга нь ажил хийдэг, үлдсэн 36.6 хувь буюу 16,5 мянга нь ажил хийгээгүй, эмэгтэйчүүдийн хувийн жин аль аль бүлэгт нь эрэгтэйчүүдээс илүү байсан. Бүс нутгийн байршлаар улсын хэмжээнд зүүн бүсийн төгсөгчдийн

хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр буюу нийт төгсөгчдийн 77.2 хувь нь ажил хийдэг, түүний дараа Улаанбаатрын төгсөгчдийн 68.7 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа нь тодорхойлогдсон. Харин баруун бүсэд шинээр сургууль төгсөгчдөд ажил эрхлэхэд хүндрэл бэрхшээлүүд байгааг энэ бүсийн нийт төгсөгчдийн 38.0 хувь нь л хөдөлмөр эрхэлдэг гэсэн судалгааны үр дүнгээс харж болохоор байгаа юм.

ИДС төгсөгчдийн 75.3 хувь нь буюу 3/4 -аас дээш хэсэг нь судалгааны хугацаанд ажил хийж байсан бол нийт төгсөгчдийн 80.0-аас дээш хувь нь хөдөлмөр эрхэлдэг, барилга-архитектур, тээвэр, нийгэм-эдийн засаг, цэрэг цагдаа, аюулгүй байдал, анагаах ухаан, мэдээлэл-сэтгүүл зүй, математик статистик нь хамгийн өндөр хөдөлмөр эрхлэлттэй мэргэжлийн чиглэлүүд байна.


Зураг 2. ИДС төгсөгчийн ажлын туршлага /салбар, ажил мэргэжлээр/



МСҮТ төгсөгчдийн 43.4 хувь нь ажил хийдэг хэмээн судлагдсан нь анхаарал татахуйц үр дүнгийн нэг байлаа. Мэргэжлийн боловсролын салбараас бэлтгэж байгаа мэргэжлүүдээс 50-аас дээш хувь нь ажил эрхэлж байгаа буюу хамгийн өндөр хөдөлмөр эрхлэлттэй нь соёл урлаг, ойн аж ахуй, мод боловсруулалтын

салбарын мэргэжлүүд байна. Ажил эрхлэгчдийн тоо цөөн байгаа анхаарал хандуулах шаардлагатай мэргэжлүүдэд дээд боловсролын салбарын хүмүүнлэгийн ухааны мэргэжилтэн, мэргэжлийн боловсролын салбараас байгаль-хамгаалал аялал жуулчлал болон холбооны салбарын мэргэжлүүдийг нэрлэж болох юм.

Зураг 3. МСҮТ төгсөгчийн ажлын туршлага /салбар, ажил мэргэжлээр/



Хөдөлмөр эрхлэлтийн нөгөө талыг илэрхийлж буй ажил хийгээгүй хэсгийн ажилгүйдлийн шалтгаан олон төрөл байна. Хамгийн нийтлэг шалтгаан нь хүүхэд, өндөр настан асрах, ажлын байр хүлээх, сургуульд сурахад ээлтгэх зэрэг хувийн амьдралтай холбоотой шалтгаанууд давамгайлжээ.

Хөдөлмөрийн насны залуусын эдийн засгийн идэвхгүй байдлын үндсэн шалтгааны нэг нь сургуульд суралцах асуудал байдаг. Тэгвэл төгссөнөөс хойшхи 15 сарын дараах байдлаар нийт төгсөгчдийн 16.5 хувьтай тэнцэх 7,5 мянга нь дахин суралцдаг болох нь судлагдсан. Энэхүү дахин суралцагсад МСҮТ төгсөгчдийн хувийн жин өндөр, тэдний олонх нь буюу 61.9 хувь нь ИДС-д бакалавраар суралцагсад байжээ. Дахин суралцахад нөлөөлсөн хамгийн чухал хүчин зүйлс нь мэргэжил, боловсрол дээшлүүлэх болон сонирхсон ажилдаа орох хүсэл зэрэг байгаа юм. Мөн дахин суралцагсдын 36.6 хувь нь өмнө нь эзэмшсэн мэргэжлээс огт өөр мэргэжлээр суралцагсад байгаа ба, тэд өөр мэргэжлээр суралцаж буйгаа ихэвчлэн мэргэжлээ солих хүсэл, өмнөх мэргэжлээр өсөн хөгжих боломж бага байсан, ажилд ороход хүндрэлтэй байсан зэрэг нөхцөл байдалтай холбон тайлбарласан байгааг анхаарахад илүүдэхгүй юм.

Судалгаанд хамрагдсан нийт төгсөгчдийн ажлын туршлагатай холбоотой судалгааны үр дүнгээс танилцуулая. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд таатай хэлбэр гэж хэлж болох тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг илэрхийлэх төгсөхөөс өмнө болон хойшхи хугацаанд нэг л ажлын байрыг хадгалж байгаа төгсөгчид нь 24,1 мянга буюу 53.4 хувийг эзэлж байна. Харин нийт төгсөгчдийн 24.5 хувь буюу 11,0 мянга нь огт ажил хийж байгаагүй, өөрөөр хэлбэл ажлын туршлагагүй, 16.7 хувь буюу 7,5 мянга гаруй нь хэд хэдэн ажил хийж байсан олон ажлын туршлагатай талаарх судалгааны үр дүн нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ялангуяа тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгцээний ач холбогдлыг сануулжээ.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлох судалгаануудын үндсэн зорилго нь шинээр мэргэжил, ажлын байр сонгох гэж байгаа төгсөгчид, ажил хайгчдад зах зээлийн бодит байдалд нийцсэн сонголт хийхэд чиглүүлэх мэдээллээр хангахад оршдог. Энэ асуудалтай холбоотойгоор Монголын залуус мэргэжил сонголт, ажлын байр эрэлхийлэх үйл ажиллагаанд ямар хүчин зүйлийг чухалчлан үздэг болохыг судалж үзсэн. Төгсөгчдийн сургууль болон мэргэжил сонголтын үндсэн шалтгаанууд нь ижил төсөөтэй байжээ. Өөрөөр хэлбэл өөрийн сонирхол, сурлагын голч дүн, элсэлтийн шалгалтын оноо, эцэг, эх, багш нарын санал зэрэг нь мэргэжил болон сургууль сонгох гэж байгаа хүүхэд залууст хамгийн хүчтэй нөлөөлдөг нь тодорхойлогдсон.

Дээр дурьдсан төгсөгчдийн ажлын туршлагын мэдээллээс үзэхэд нийт төгсөгчдийн 75.5 хувь буюу 34,0 мянга нь ажил хийж үзсэн бол, цаашид ажлын туршлагатай төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын талаар дэлгэрүүлэн авч үзэх болно.

Ажлын байранд ортол зарцуулдаг хугацааг төгсөхөөс өмнө болон төгссөний дараах хугацааны интервалиар ангилан судалсан. Нийт төгсөгчдийн 9.3 хувь буюу 3,2 мянга нь сургууль төгсөхөөс өмнө ажилд орсон, үлдсэн 90.7 хувь нь төгссөнөөс хойшхи хугацаанд, төгссөнөөс хойш 13 сарын дараа хамгийн олон буюу 34.5 хувь нь ажилтай болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд нийт ажлын туршлагатай төгсөгчид дараах онцлогуудыг харуулж байгаа юм.

Ажлын байрны хэлбэрийн тухайд 86.7 хувь нь байнгын ажлын байранд харьяалагддаг, 51.0 хувь буюу 17,4 мянга нь 11-100 ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажилладаг, 95.6 хувь нь цалин хөлстэй ажилтны статустай ба тэдний 80.1 хувь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад, 45.9 хувь буюу 15,6 мянга нь дотоодын хөрөнгө оруулалттай компанид, 25.8 хувь

буюу 8,8 мянга нь төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагад ажилладаг нь хамгийн өндөр хамралттай хэлбэрүүд болж байна.

Хөдөлмөрийн нөхцлийг тодруулан судлахад нийт төгсөгчдийн 7 хоногийн дундаж ажлын өдөр 5.5, ажлын цаг нь 47.2, нэмэлт ажлын цаг нь 12.6, сарын дундаж цалин, орлогын хэмжээ нь 505,2 мянган төгрөг, сарын дундаж ажлын өдөр 23.6, сарын дундаж амралтын өдөр нь 7.0 байдаг нь тогтоогдсон. Мөн түүнчлэн ажлын байрны ажил, амралтын цаг болон байгууллагын нэр хүндэд илүү өндөр сэтгэл ханамжтай байдаг бол, байгууллагын хүний нөөцийн менежментийн бодлогод илүү сэтгэл дундуур байдгаа илэрхийлсэн.

Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг болон боловсролын түвшний нийцтэй байдалд төгсөгчид илүү эерэг хандлагатай байгаа ба нийт төгсөгчдийн 67.2 хувь буюу 22,9 мянга нь боловсрол, ажил үүргийн үл нийцэлтэй холбоотой хүндрэл бэрхшээл тулгардаггүй талаар мэдээллэсэн. Мөн ажил үүрэг болон эзэмшсэн ур чадварын нийцтэй байдлыг үнэлүүлж үзэхэд 73.0 хувь нь тохиромжтой байдаг, 8.2 хувь нь ажил үүргийн шаардлага ур чадвараас өндөр, 18.9 хувь нь доогуур байдаг гэсэн байна.

Ажлын байранд хамгийн ихээр тулгардаг ур чадварын хомсдолуудаас нэрлэвэл багаар ажиллах чадвар /нийт төгсөгчдийн 14.7 хувь нэрлэсэн/, мэдээллийн технологийн ашиглах /14.3 хувь/, харилцааны ур чадвар, соёлч боловсон байдал /14.1 хувь/ болон гадаад хэлний мэдлэг /13.5 хувь/ зэрэг байна.

Хөдөлмөр эрхлэлтийн бүтцийг судлахдаа эдийн засгийн үйл ажиллагааны салбарын талаар авч үзсэн. Сургууль төгсөгчид олон салбаруудад тархан ажиллахаас илүүтэйгээр цөөн хэдэн тооны, ялангуяа эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн салбаруудад олноороо ажилладаг байна. Тухайлбал уул уурхайн салбарт нийт төгсөгчдийн 68.4 хувь буюу 23,3 мянга, хөдөө аж ахуйн салбарт 10.8 хувь буюу 3,7 мянга, боловсролын салбарт 5.2 хувь буюу 1,8 мянга, худалдааны салбарт 3.0 хувь буюу 1,1 мянга, төрийн удирдлага

батлан хамгаалах салбарт 2.2 хувь буюу 0,8 мянган төгсөгчид ажиллаж байгаа нь бусад салбартай харьцуулахад илүү олон байгаа юм.

Төгсөгчдийн ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг нь эзэмшсэн мэргэжилтэй нь хэр нийцдэг талаар судлахын сацуу мэргэжлээрээ ажилладаг байдлыг тандан үзсэн.

Нийт судалгаанд хамрагдагсдын 51.3 хувь буюу 18,3 мянга нь ажил үүрэг нь мэргэжилтэй тохирдог, маш сайн тохирдог гэж хариулснаас үзэхэд энэ хэмжээний төгсөгчид мэргэжлийн дагуух ажил эрхэлдэг гэж үзэж болох талтай. Харин 24.3 хувь нь ажил үүрэг болон мэргэжил нь тохирдоггүй, огт тохирдоггүй гэж үнэлсэн байгаа эдгээр төгсөгчид мэргэжлийн бус ажил хийдэг бүлэг болох нь тодорхойлогдож байна. Дээд боловсролын салбарт бэлтгэдэг урлаг, мэдээлэл-сэтгүүл зүй, компьютер болон анагаах ухааны мэргэжилтнүүдийн мэргэжлийн дагуух хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр байгаа бол, нийгмийн халамж, хангамж, тээвэр, хууль эрхзүй, хүмүүнлэгийн ухаан, байгаль хамгааллын мэргэжилтнүүд мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт хамгийн ихтэй мэргэжлүүд болох нь тогтоогдсон.

Мэргэжлийн боловсролын салбарт соёл урлаг, барилга авто зам, барилгын материал үйлдвэрлэл, аж үйлдвэрийн салбарын мэргэжилтэй ажилтнууд эзэмшсэн мэргэжлээр ажиллах байдал бусад мэргэжилтэй харьцуулахад их байгаа бол, холбоо, ойн аж ахуй, мод боловсруулалт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон байгаль хамгаалал аялал жуулчлалын чиглэлээр мэргэжил эзэмшсэн төгсөгчид мэргэжлийн бус ажил эрхэлж байгаа нь нийтлэг хэлбэр болжээ.

Ойрын нэг жилийн хугацааны төгсөгчдийн зорилго нь ажлаа үргэлжлүүлэн хийх, ажлаа өөрчлөх, дотоодын сургуульд суралцах гэсэн төлөвлөгөөнүүдэд төвлөрч байна. Нийт төгсөгчдийн 17.5 хувь буюу 7,9 мянга нь судалгааны үеэр ажил хайж байсан ба, тэдний 64.0 хувь нь ажил олж хийх,

үлдсэн 36.0 хувь эрхэлж буй ажлаа өөрчлөх бодолтой байгаа талаар мэдээллэсэн. Ажлаа өөрчлөхөд нөлөөлөгч нь хөдөлмөрийн хөлсний үнэлгээ /нийт ажлаа өөрчлөх төлөвлөгөөтэй төгсөгчдөд эзлэх хувийн жин 52.9 хувь/, ажлын ирээдүйгүй байдал /9.4 хувь/ болон хувиараа бизнес эрхлэх төлөвлөгөө /9.8 хувь/ зэрэг байгаа юм. Ажил хайж буй хэсгийн хувьд ихэвчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан зарын дагуу, танил талын холбоогоор дамжуулан ажил хайх хэлбэрийг сонгодог бол 17.5 хувь нь хөдөлмөр зуучлалын байгууллагын үйлчилгээг авдаг нь тодорхойлогдсон. Мөн түүнчлэн ажил хайгчдын 22.6 хувь нь ажил хайх бодолтой байгаа ч ямар нэг хичээл зүтгэл гаргаагүй байна.

Судалгааны төгсгөлд төгсөгчдөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр

хэрэгжүүлж буй үйлчилгээ, арга хэмжээтэй холбоотой ойлголт мэдээлэл, оролцооны талаар тодруулсан. Хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаа, бүртгэл мэдээллийн тогтолцоо, мэдээлэл дамжуулах, хүртэх хэлбэрүүд, хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ, мэргэжлийн сургалттай холбоотой үндсэн 7 багц арга хэмжээний талаарх төгсөгчдийн ойлголт, мэдээллийг судлан үзэхэд 15.9 хувь нь эдгээр үйл ажиллагааны талаар мэддэг гэж хариулсан байгаа нь чамлахаар тоо болж байгаа юм. Төгсөгчид хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааны талаар хамгийн сайн мэдээлэлтэй байхад жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар, хөдөлмөрийн яармагын арга хэмжээний талаарх мэдээлэл хомс байдаг нь тодорхойлогдсон.

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны зорилго нь дээд боловсролын болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн мэргэжил, ур чадварын хөгжил болон хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг судалж, дүн шинжилгээ хийх замаар боловсрол болон хөдөлмөрийн зах зээл хоорондын зүй тогтолт холбоог харуулсан мэдээллийг бий болгох, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн үр ашигтай бодлого боловсруулахад ашиглах суурь мэдээллээр хэрэглэгчдийг хангах явдал юм.

Тус судалгаанд их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгсөгчдийг хамруулж, судалгааны үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг шийдвэрлэсэн. Үүнд:

- Төгсөгчдийн хүн ам зүйн төлөв байдал, өрх гэр бүлийн амьдрал, мэргэжлийн тархалтыг тодорхойлох
- Сургууль, мэргэжил сонголтын шалтгаан, сэтгэл ханамжийг судлах

1.2 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөн мэргэжил эзэмшсэн шинэ мэргэжилтэй ажиллах хүчний хөдөлмөрийн зах зээл дэх хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, хөдөлгөөнийг судлах юм. Хамрах хүрээ нь улсын хэмжээнд үйл ажиллагаа

- Сургуульд суралцах болон дараах хугацааны нийт хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг судлан, сургуулийн төрөл, сургуулийн өмчийн хэлбэрүүдээрх ялгааг гаргах
- Одоогийн эдийн засгийн үйл ажиллагааны оролцооны төлөв байдлыг сургуулийн төрөл, мэргэжлийн чиглэл тус бүрээр тайлбарлах
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг ажлын байрны хэлбэр, статус, ажил, амралтын цаг, өдөр, хөдөлмөрийн хөлс, ААНБ-ын ажилтны тоо, үйл ажиллагааны чиглэл зэрэг олон талаас нь задлан судалж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн онцлогыг тодорхойлох
- Хөдөлмөр эрхлэлтийн талаарх хэтийн төлөвлөгөө, зорилгын талаар судлах

явуулж байгаа их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг 2011 онд төгссөн 54,5 мянган төгсөгч болно. Судалгааны үндсэн нэгж нь Монгол улсын нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч буй тухайн жилд шинэ төгсөгчид юм.

1.3 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

Аливаа судалгааны түүвэрлэлтийн загварт тухайн судалгааны зорилго, хамрах хүрээ, цаг хугацаа зэргээс шалтгаалан түүврийн хэмжээ, түүвэрлэлт хийх арга зүй, техник ямар байх нь тогтоогддог. Энэхүү судалгаанд пропорциональ магадлал, энгийн санамсаргүй түүврийн арга ашиглахаар сонгосон бөгөөд судалгааны тавьсан зорилгод хамгийн тохиромжтой гэж үзсэн болно.

Хүснэгт 1. Эх олонлогийн ерөнхий мэдээлэл

Төгсөгчдийн тоо	2010/2011
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн тоо	63
Их, дээд сургуулийн тоо	113
Дүн	176
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгсөгчид	18705
Их, дээд сургууль төгсөгчид	35847
Дүн	54552

Түүврийн хэмжээ: Түүврийн хэмжээ нь судалгаа болгоны онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байдаг. Гэвч тавигддаг гол шаардлага нь эх олонлогоо төлөөлөх чадвартай байх явдал бөгөөд дараах хүчин зүйлсийг анхаарч үзсэн. Үүнд:

- Цаг хугацааны боломж
- Судалгааны үр дүн нарийвчлалтай буюу бодитой байх шаардлага
- Байж болох алдааны түвшин

Түүвэр судалгааны түүврийн хэмжээг тодорхойлоход ашиглах үндсэн томъёо өгөгдсөн байдаг (1). Түүврийн хэмжээг хүлээн зөвшөөрөх алдааны хязгаар буюу үр дүнгийн нарийвчлал болон үзэгдлийн тархалтын тохирох ач холбогдлын түвшинд нийцүүлэн тодорхойлсон.

Судалгаанд шаардлагатай түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцсон. Үүнд:

$$n = \frac{Z^2 p (1-p)}{e^2} \text{ Deff} \quad (1)$$

Түүврийн эх олонлог: Уг судалгаагаар Монгол улсын их дээд сургууль болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгсөгчдийн талаарх мэдээллийг цуглуулсан бөгөөд судалгааны хамрах хүрээ 2010-2011 оны хичээлийн жилд төгсөгчдийн нийт тоогоор тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл судлах эх олонлогийн хэмжээ 54552 төгсөгчид юм.

Эх олонлогийн хэмжээ мэдэгдэж байсан учраас дээрх томъёоны дагуу тооцсон түүврийн хэмжээг дараах томъёоны дагуу шинэчлэн тооцсон.

$$n^* = \frac{n}{1 + \frac{n}{N}} \quad (2)$$

n – түүврийн хэмжээ

Z - тодорхой хувийн ач холбогдолын түвшин дэх t статистикийн тархалтын утга

p - түүврийн хэмжээг тодорхойлоход ашиглах түлхүүр үзүүлэлтийн хувийн жин

e - судалгаанд дэвшүүлж байгаа хүлээн зөвшөөрөх алдааны хязгаар

N - өгөгдсөн түүврийн хүрээн дэх эх олонлогийн хэмжээ

Дээрх томъёоллын дагуу түүврийнхээ хэмжээг тодорхойлохын тулд эхлээд дээрх өгөгдсөн хувьсагчдын утгыг тодорхойлж өгөх шаардлагатай болсон.

Z - 95 хувийн ач холбогдолын түвшин дэх t статистикийн тархалтын утга 1.96

p - хэрвээ судалгааны түлхүүр үзүүлэлтийн мэдээлэл өгөгдөөгүй үед тус үзүүлэлтийн хувийн жинг 50 хувиар авдаг.

e - таамаглаж байгаа алдааны хязгаар буюу үр дүнгийн нарийвчлалын түвшинг практикт 5.0 хувийн харьцангуй болон

абсолют алдаатай байхыг зөвшөөрөгдөхүйц хангалттай гэж үздэг.

Deff - кластерийн нөлөө байгаа үед энэ утгыг өмнө үеийн утгаар эсвэл өмнө нь ямар нэгэн ижил төстэй судалгаа явагдаж байгаагүй тохиолдолд 2-той тэнцүү байна гэж таамагладаг. Бидний тохиолдолд 1-тэй тэнцүү байсан.

Хүснэгт 2. Түүврийн хэмжээг тодорхойлсон байдал

	Z ²	p	1-p	e(a)	e ² (a)	e(x)	n	N	n*
Түлхүүр үзүүлэлт = 0,5, Харьцангуй алдааны хязгаар = 0.05	3.84	0.50	0.50	0.03	0.0006	0.05	1537	54552	1495

Энэхүү түүвэрт харьцангуй алдааны хязгаар 5 хувь байхад түүврийн хэмжээ 1500 дотор байна. Хэрвээ судалгааны үр дүнг 5 хувийн алдааны хязгаарт түүврийн хэмжээ тогтоогоод/fixed/ дээр дурьдсан нийт 10 бүлэг тус бүрт түүврийнхээ хэмжээг хуваарилж, тэдгээрт ногдох таамаглаж байгаа харьцангуй алдааны хязгаарыг

тооцсон тооцооны хүрээнд судалгааны үр дүнг хүлээн зөвшөөрч зарлаж болно.

Дээрх тооцооны хувьд түүврийн хэмжээ 1495 байх бөгөөд 1 бүлэгт дунджаар 149 төгсөгч ногдох бөгөөд тооцоогоор, нэг бүлгийн харьцангуй алдаа 16.0 хувь, абсолют алдаа 8.0 хувьтай тэнцүү байхаар байлаа.

Хүснэгт 3. Түүврийн хэмжээг хуваарилсан байдал

Төрөл	Эх олонлог	Түүвэрлэгдэх хэмжээ	Тооцоолж буй алдааны түвшин
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгсөгчид	18705	513	0,06
Их, дээд сургууль төгсөгчид	35847	982	0,06
Дүн	54552	1495	

Бүлгийн тухайд пропорциональ магадлалт, энгийн санамсаргүй түүврийн арга ашиглан 1495 төгсөгчийг судалгаанд хамруулсан. Мэдээллийн санг нэгдсэн

стандартад оруулах үүднээс сургуулийн төрлөөр багцалсан тоог гаргаж төгсөгчдийн тоонд нь хувь тэнцүүлэн (пропорциональ магадлалт) түүврийн хэмжээг хуваарилсан.

1.4 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

- Мэдээлэл цуглуулах шатанд судалгааны онцлогоос шалтгаалж 4 төрлийн ажил хийгдсэн. Үүнд:
 - Сонгогдсон төгсөгчтэй холбоо барих хаягийг тодорхойлсон.
 - Төгссөн сургуулийн сургалтын албанд байгаа мэдээллийг авах
 - Анги даасан багштай уулзах
 - Холбогдох боломжтой хүнээр дамжуулах холбоо барих, мэдээлэл авах
 - Холбоо тогтоох боломжгүй (гадаад улсад явсан, хөдөө суманд амьдарч байгаа) гэсэн мэдээллийг авсан нөхцөлд нөөц төгсөгчийг судалгаанд хамруулсан.
- Төгсөгчтэй холбогдох судалгаа авах газар, огноог тодорхой болгосон.
 - Зорилгоо товч тайлбарлах
 - Судалгаа явагдах хугацаанд бидний хүрч чадах газар байх эсэхийг тодруулах
- Судалгаанд хамрагдах боломжтой эсэхийг тодруулах
- Хүндэтгэх шалтгаантайгаар судалгаанд хамрагдах боломжгүй гэдгээ илэрхийлсэн нөхцөлд нөөц төгсөгчийг судалгаанд хамруулах
- Судалгааны мэдээллийг авсан. (ярилцлага хийсэн.)
 - Судалгааны зорилго, мэдээллийн нууцлал болон холбогдох бусад мэдээллийг танилцуулах
 - Мэдээллийг нүүр тулсан ярилцлага хийж анкетын аргаар авна(face to face interview)
 - Ярилцлага дууссаны дараа асуулгын маягыг бүрэн бөглөгдсөн эсэхийг нэг бүрчлэн шалгаж баталгаажуулах
 - Ярилцлагын явцад мэдээлэл өгөх боломжгүй болсон нөхцөлд дараа уулзаж ярилцлагаа үргэжлүүлэх хугацааг тохирох

1.5 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Түүвэрлэлтийн бус алдааг багасгах зорилгоор шивэлтийн үед гарч болох алдааг багасгахад анхаарч ажиллаж, шивэлтийн үеийн шалгалтыг тогтмол хийсэн. Мэдээлэл оруулах програмыг АНУ-ын Тооллогын товчооны боловсруулсан тооллого түүвэр судалгааны CPro 5.0 багц програмын хамгийн сүүлийн хувилбарын мэдээлэл оруулах хэрэгсэл (Data entry tools) болон

мэдээллийг шалгах засварлах багцын тусламжтайгаар боловсрууллаа.

Мэдээллийн бааз бэлэн болсоны дараа үр дүнд шинжилгээ хийх болон нэгдсэн хүснэгт, үр дүн гаргах зорилгоор мэдээллийн баазыг статистик мэдээлэл боловсруулах болон дүн шинжилгээ хийх SPSS 18.0 (PASW) програмд хөрвүүлсэн.

БҮЛЭГ 2. 2011 ОНД ТӨГСӨГЧИЙН БҮТЭЦ БОЛОН СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

2.1 ТӨГСӨГЧИЙН ХҮН АМ ЗҮЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд 2010-2011 оны хичээлийн жилд мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагыг бакалавр түүнээс доош түвшний боловсрол эзэмшин төгссөн 1495 төгсөгчийг хамруулсан ба үүнийг эх олонлогт тархаан үзвэл 45,1 мянган төгсөгч болж байгаа юм.

Нийт төгсөгчдийн 60.0 хувь буюу 27,0 мянга нь их, дээд сургууль, коллеж, 40.0 хувьтэй тэнцэх 18,1 мянга нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөгчид байгаа ба, хүйсийн хувьд 56.0 хувь нь эмэгтэйчүүд, үлдсэн 44.0 хувь эрэгтэйчүүд байжээ¹.

Судалгаанд хамрагдагсдын дундаж нас 24 байгаа бол, энэ тоо их, дээд сургуулийн тухайд 25, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийн хувьд 22 байна. Төгсөгчдийг насны бүлгээр тархаахад 23-27 насныхан бусад насныхантай харьцуулахад илүү олон байна. Өөрөөр хэлбэл тэдний эзлэх хувийн жин 65.3 хувь буюу 29,4 мянга, түүний дараа 18-22 насныхан 29.8 хувь буюу 13,5 мянга, 28-32 насныхан 2.8 хувь буюу 1,3 мянга бол, 33-аас дээш насныхан бусад насныхнаас илүү цөөн 2.1 хувь буюу 0,9 мянга байжээ.

Хүснэгт 4. Хүн ам зүйн ерөнхий төлөв байдал /төгсөгчдийн хүйс, нас, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал/

Хэмжих нэгж: тоо, хувь


		ИДС төгсөгч	МСҮТ төгсөгч	Бүгд	Эзлэх жин
	Бүгд	27025	18049	45074	
Хүйс	Эрэгтэй	9671	10314	19985	44,0%
	Эмэгтэй	17353	7735	25089	56,0%
	18-22	712	12736	13449	29,8%
Нас	23-37	24741	4702	29443	65,3%
	28-32	1003	242	1245	2,8%
	33-аас дээш	568	369	937	2,1%
	Дундаж нас	25	22	24	
Гэрлэлтийн байдал	Гэрлэсэн	9573	3118	12691	28,2%
	Гэрлээгүй	17451	14931	32382	71,8%
Боловсролын түвшин	МАШ	0	5422	5422	12,0%
	ТМД	0	12627	12627	28,0%
	Бакалавр	25880	0	25880	57,0%
	Магистр, түүнээс дээш	1144	0	1144	3,0%

¹2010-2011 оны хичээлийн жилд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг 18,7 мянган төгсөгч /Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Статистикийн үзүүлэлт 2011/, их, дээд сургууль, коллежийг 35,8 мянган төгсөгч /Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Статистикийн эмхэтгэл/ тус тус төгссөн мэдээлэл байдаг. Тус судалгаанд 2011-2012 оны хичээлийн жилийн өвлийн ээлжинд дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийг хамруулаагүй, мөн түүнчлэн зарим мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийн мэдээлэл албан ёсны мэдээллийн нэгтгэлд давхардан орсон зэрэг шалтгааны улмаас тархаасан үр дүн статистик мэдээллээс зөрүүтэй байгаа болно.

Сургалтын байгууллагын төрлөөр төгсөгчдийн насны бүтцэд ялгаатай тал байгаа юм. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн мэргэжлийн боловсролын сургалтанд бүрэн бус дунд боловсрол эзэмшсэн хүүхэд залуус элсэн суралцдаг, нөгөө талаас сургалтын нийт хугацаа богино байдаг зэрэг хүчин зүйлтэй

шууд хамааралтайгаар МСҮТ төгсөгчдийн дундаж нас 22, насны бүлгийн тухайд 18-22 насныхны эзлэх хувь хамгийн их буюу 70.6 хувьтай дүйцэх 12,7 мянга байна. Харин дээд боловсролын салбараас нийлүүлэгдэж буй төгсөгчдийн дийлэнх нь буюу 91.6 хувьтай тэнцэх 24,7 мянга нь 23-27 насны залуус байжээ.

Зураг 4. Төгсөгчдийн хүн ам зүйн зарим үзүүлэлт



Гэр бүлийн талаарх мэдээллийг тус судалгааны хүрээнд сонирхон авч үзсэн. Төгсөгчдийн 71.8 хувь буюу 32,4 мянга нь гэрлээгүй бол, үлдсэн 28.2 хувьтай тэнцэх 12,7 мянга нь гэрлэсэн байдалтай байна. Өрхийн гишүүдийн дундаж тоо нийт төгсөгчийн хувьд 3.9 байгаа бол, МСҮТ төгсөгчийн тухайд 4.2, ИДС төгсөгчийн тухайд 3.7 гэсэн зөрүүтэй дүнг харуулжээ.

Өрхийн гишүүдийн дундаж тоог тодруулахын сацуу төгсөгчийн эцэг, эхтэйгээ хамт амьдардаг талаар судалсан. Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд төгсөгчдийн 60.7 хувь буюу 27,4 мянга нь эцэг, эхтэйгээ хамт амьдардаг гэж хариулсан бол, 39.3 хувь нь эцэг эхээсээ тусдаа амьдардаг гэсэн мэдээллийг өгчээ.


Гэр бүлийн амьдралтай холбоотой тодруулан асуусан өөр нэг асуулт нь өрхийн сарын дундаж орлогын мэдээлэл байсан. Өрхийн сарын дундаж орлогын доод хэмжээг 251,0 мянган төгрөг, дээд хэмжээг 1,5 сая төгрөгөөс дээш гэсэн байдлаар бүлэглэн авч үзсэн. Нийт төгсөгчдийн дунд өрхийн сарын дундаж орлого нь 501,0-750,0 мянган төгрөг байдаг бүлэг хамгийн их буюу 28.1 хувь байсан бол, хамгийн цөөн нь 1.5 сая төгрөгөөс дээш сарын орлоготой нь 5.6 хувьтай тэнцэх 2,5 мянган өрх байлаа. Гэхдээ төгссөн сургалтын байгууллагын төрлөөр өрхийн сарын дундаж орлогын бүтцэд зарим ялгаатай талууд байгаа юм. Өөрөөр хэлбэл ИДС төгсөгчдийн дунд бусдаас өндөр давтамжийг харуулж буй

хэмжээ нь 501,0-750,0 мянган төгрөг бол, МСҮТ төгсөгчдийн хувьд 751,0 мянгаас 1,0 сая хүртэл төгрөгийн орлоготой өрх давамгайлжээ.

Төгсөгчид эцэг эхээсээ ахуй хангамж, эдийн засгийн хувьд хэр хараат амьдардаг болохыг судлах зорилгоор өнгөрсөн 3 сарын хугацаанд эцэг, эхээсээ авсан дэмжлэгийн талаар тодруулсан. Бусад дэмжлэгийн төрөлтэй харьцуулахад хүнсний дэмжлэг, ялангуяа махан бүтээгдэхүүнийг эцэг, эхээсээ авч хэрэглэх тохиолдол илүү их байдаг байна. Судалгаанд хамрагдагсдын 35.3 хувь нь хоол хүнсийг ихэвчлэн эцэг, эхээсээ

авч хэрэглэдэг гэж хариулжээ. Харин байр, орон сууцны төлбөр, түрээсийн мөнгө, өдөр тутмын хэрэглээний мөнгийг ихэвчлэн буюу нийт төгсөгчдийн 50.3 хувиас дээш хэсэг нь эцэг, эхээсээ огт авдаггүй ч материаллаг эд зүйлс худалдан авах, жишээлбэл цахилгаан бараа гэх мэтийн худалдаа хийхэд эцэг, эхээсээ дэмжлэг авагсад олон байдаг байна. Энэ нь ИДС, МСҮТ төгсөөд удаагүй байгаа залуус нь эцэг, эхтэйгээ хамт амьдрах, мөн тэднээс дэмжлэг туслалцаа авах нь түгээмэл, өөрөөр хэлбэл бие даан, хараат бусаар амьдрах нөхцөл боломж бүрдээгүй байгааг харуулж буй хэрэг юм.

Зураг 5. Өнгөрсөн 3 сарын хугацаанд эцэг, эхээсээ авсан дэмжлэг



2.2 ТӨГСӨГЧИЙН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖЛИЙН ТАРХАЛТ

Сургалтын байгууллагын өмчийн хэлбэрийн төрлөөр буюу төрийн, хувийн өмчийн хэвшлийн сургуулийн хэлбэр тус бүрээр судалгаанд хамрагдагсдын мэргэжлийн тархалтыг авч үзье.

Дээд боловсролын байгууллагын төгсөгчдийн судалгаанд хамрагдалтын хувьд сургуулийн өмчийн хэлбэрийн ялгаа бага байна. Өөрөөр хэлбэл төрийн өмчийн сургууль төгсөгчид 56.3 хувь буюу 15,2 мянга, хувийн өмчийнх 43.7 хувь буюу 11,8


мянга байна.

Мэргэжлийн хувьд бизнес удирдлага, багш боловсрол судлалын мэргэжил эзэмшсэн төгсөгчид хамгийн олон байгаа бол, нийгэм-эдийн засаг, хүмүүнлэгийн ухаан, хууль эрхзүй, анагаах ухаан, бүх төрлийн инженерүүд бусад мэргэжилтэй харьцуулахад илүү олон байгаа юм. Төрийн өмчийн их, дээд сургууль төгссөн төгсөгчдийн дунд багш, боловсрол судлал, бизнес удирдлага, нийгэм-эдийн засаг,

бүх төрлийн инженерийн мэргэжилтэнгүүд судалгаанд хамгийн олноор хамрагдсан бол, хувийн өмчийн дээд боловсролын байгууллагаас нийлүүлэгдсэн бизнес удирдлага, багш, боловсрол судлал, хууль

эрхзүй, нийгэм-эдийн засаг, хүмүүнлэгийн ухааны чиглэлийн мэргэжил эзэмшсэн төгсөгчдийн эзлэх жин бусад мэргэжлийн чиглэлүүдтэй харьцуулахад их байжээ.

Зураг 6. ИДС төгсөгчдийн мэргэжлийн тархаалт/сургуулийн өмчийн хэлбэрээр/




Мэргэжлийн сургалтын байгууллага буюу мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг 2011 онд төгсөгчдийн тухайд төрийн болон хувийн өмчийн сургуулийн хэлбэрээр судалгаанд хамрагдалтын хувийн жинд томоохон ялгаа байгаа ба энэ нь эх олонлогийн бүтэцтэй холбоотой юм. Өөрөөр хэлбэл 2010-2011 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 63 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв үйл ажиллагаа явуулсны 69.8 хувь буюу 44 нь төрийн өмчийн сургууль, эдгээрт суралцагсдын тоо нийт суралцагсдын 75.3 хувьтай тэнцэх 34,7 мянга байсан².

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн төгсөгчдийн дунд барилга, автозам, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын мэргэжилтнүүд хамгийн олон байхын зэрэгцээ аж үйлдвэрлэлийн салбар, тээврийн салбар, захиргааны үйлчилгээний салбарын мэргэжилтэй ажилтнууд бусад мэргэжлийн чиглэлүүдтэй харьцуулахад судалгаанд олноор хамрагджээ.

Сургалтын байгууллагын өмчийн хэлбэрийн ангилалаар мэргэжлийн чиглэлүүдээр ялгаа харагдахгүй жигд тархаалтыг харуулсан төдийгүй дээр дурьдсан мэргэжлүүдэд хамгийн олон төгсөгчид харьяалагдаж байгаа юм.

²ҮСХ, Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл 2011, 316 дугаар хуудас

Зураг 7. МСҮТ төгсөгчдийн мэргэжлийн тархаалт/сургуулийн өмчийн хэлбэрээр/



2.3 ТӨГСӨГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар тодруулахыг зорьсон чухал үр дүнгийн нэг нь тэдний эдийн засгийн идэвхи буюу эдийн засгийн үйл ажиллагааны оролцооны тухай асуудал юм.

Судалгааны мэдээлэл цуглуулах хугацааны үеийн тухайн долоо хоногт ажил эрхэлж байсан оролцоогоор төгсөгчдийн эдийн засгийн идэвхийг хэмжсэн.

Мэдээлэл цуглуулах өдрийн өмнөх 7 хоногийн хугацаанд нийт төгсөгчдийн 63.4 хувь буюу 28,6 мянга нь ажил хийсэн, үлдсэн 36.6 хувь нь ажил хийгээгүй судалгааны үр дүн гарсан.

Хүйсийн хувьд ажил хийсэн, хийгээгүй аль ч бүлэгт эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдээс өндөр байжээ. Ажил хийсэн эмэгтэйчүүдийн хувийн жин 54.1 хувь байсан бол, ажил хийгээгүй төгсөгчдийн 58.4 хувийг эмэгтэйчүүд эзэлсэн байна. Энэ нь боловсролын салбараас нийлүүлэгдэх

эмэгтэй төгсөгчдийн тоо эрэгтэйчүүдээс их байдагтай холбоотой гэж үзэж байна³.

Бүс нутгийн байршлаар төгсөгчдийн эдийн засгийн идэвхи харилцан адилгүй байна.

Ажил эрхэлж буй үзүүлэлтээр зүүн бүсийн төгсөгчид хамгийн эерэг байгаа ба нийт төгсөгчдийн 77.2 хувьтай тэнцэх 1,0 мянга гаруй нь ажил эрхэлдэг гэж хариулжээ. Мөн түүнчлэн Улаанбаатрын төгсөгчдийн 68.7 хувь буюу 22,9 мянга нь эдийн засгийн идэвхтэй төлөвт байсан байна.


Ажиллах хүчний эрэлтийн богино хугацааны төсөөллийг тодорхойлдог судалгаагаар орон нутгаас төвийн болон баруун бүсүүдэд ажиллах хүчний эрэлт илүү

³Үндэсний статистикийн хорооны 2011 оны статистикийн эмхэтгэлд дурьдсанаар 2010-2011 оны хичээлийн жилд мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагыг нийт 47,0 мянган залуус төгссөн ба, тэдний 60.0 хувь буюу 28,2 мянга нь эмэгтэйчүүд байгаа юм.

их байхаар тооцоологддог⁴. Гэтэл ажиллах хүчний нийлүүлэлтийн талыг тодорхойлж буй уг судалгаагаар баруун бүсийн төгсөгчдөд ажил эрхлэхэд багагүй хүндрэл бэрхшээл байгаа нь эдгээр бүс нутгийн залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогод анхаарал хандуулах шаардлага байгааг харуулж байна. Баруун бүсийн тухайд судалгаанд хамрагдсан нийт төгсөгчдийн 38.0 хувь нь л мэдээлэл цуглуулах хугацаанд ажил эрхэлж байсан дүн гарсан.

Улсын хэмжээнд баруун, хангай, төвийн бүсийн мэргэжилтэй шинэ ажилтнууд хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтээр хамгийн сул идэвхийг харуулж байгаа бол, харин зүүн бүсэд хамгийн таатай хөдөлмөрийн зах зээлийн орчин оршиж байна гэж хэлж болохоор байна. Гэсэн хэдий ч зүүн бүсэд ажилгүйдлийн түвшин⁵ улсын хэмжээнд хамгийн өндөр байгаа нь энэ бүсэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг шинэ залуу ажиллах хүчинд хандуулахаас илүүтэйгээр урт хугацааны ажилгүйчүүд болон дунд насныхны бүлэгт чиглүүлэх шаардлагатай болохыг илтгэж байгаа юм.

Зураг 8. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал /бүсээр/



Тус судалгааны чухал зорилтын нэг нь мэргэжлээс хамааралтай хөдөлмөр эрхлэлтийн ялгаатай түвшин байгааг тодруулах явдал юм. Өөрөөр хэлбэл эзэмшсэн мэргэжлийн чиглэл тус бүрээр хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн тархаалтын зөрүүг тооцож үзэхийг зорьсон.

Их, дээд сургууль төгсөгчдийн мэргэжлийн чиглэл тус бүрээрх хөдөлмөр эрхлэлтийн хувийн жингийн дундаж нь 75.3 хувь байгаа нь дээд боловсролын салбарын нийлүүлэлтийн 3/4-аас дээш хэсэг нь төгссөнөөс хойш 15 сарын дараах байдлаар эдийн засгийн идэвхтэй төлөвт харьяалагдаж

байгааг харуулж буй хэрэг юм.

Мэргэжлийн чиглэлийн байдлаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт өндөр буюу 80.0 ба түүнээс дээш хувийг үзүүлж буй нь барилга архитектур /93,3%/, тээвэр /85.0%/, нийгэм-эдийн засаг /84,8%/, цэрэг цагдаа, аюулгүй байдал /84.1%/, анагаах ухаан /82.2%/, мэдээлэл-сэтгүүл зүй /80.0%/, математик статистик /80.0%/ байна.

Тухайн мэргэжлийн нийт төгсөгчдөд эзлэх хөдөлмөр эрхлэлтийн хувиар дундаж хэмжээг илэрхийлж байгаа, өөрөөр хэлбэл 73.3-79.5 хувийн хөдөлмөр эрхлэлттэй

⁴Барометрийн судалгааны тайлан, 2011, 2012, 2013

⁵ҮСХ, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2012, 116 дугаар хуудас: Ажилгүйдлийн түвшин баруун бүс 9,8%, хангайн бүс 8,3%, төвийн бүс 7,7%, зүүн бүс 10,8%, улаанбаатар 7,1%, улсын дүн 8,2% байна.

мэргэжлийн чиглэлүүд нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй /79.5%/, багш, боловсрол судлал /78.3%/, урлаг болон бизнес удирдлага тус бүр 77.8%, физик хими технологи-газарзүй, бүх төрлийн инженер, мал эмнэлэг тус бүр 75.6%, компьютер /73.3%/ -ийн мэргэжлүүд тодорхойлогджээ.

Харин хөдөлмөр эрхлэлтийн хувь бага буюу 70.0-аас доош хувийг харуулж буй мэргэжлийн чиглэлүүд нь биологи болон үйлдвэрлэлийн технологи тус бүр 68.9 хувь, нийгмийн халамж хангамж /68.2%/, хууль эрхзүй/66.7%/, байгаль хамгаалал /63.6%/, биеийн тамир, спорт /62.2%/, хүмүүнлэгийн ухаан /54.5%/ байна.

Дээрх төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдлын талаарх судалгааны

үр дүн нь хүмүүнлэгийн ухааны чиглэлийн мэргэжилтнүүдийн ажилгүйдэлд анхаарал хандуулах хэрэгтэйг сануулж байна.

Ажилгүйдлийн шалтгаан олон төрөл байж болно. Хувь хүн өөрөөс хамаарсан хүчин зүйлс ажилгүйдлийг бий болгох төдийгүй, нийгэм-эдийн засгийн төлөв байдал, төрийн бодлогын зохицуулалт, үйл ажиллагааны зохион байгуулалт гэх мэт макро түвшний хүчин зүйлийн нөлөөгөөр иргэдийн эдийн засгийн үйл ажиллагааны оролцоонд тодорхой хязгаарлалтууд үүсдэг. Ямартаа ч хөдөлмөр эрхлэлтийн байдлаар хамгийн сул үр дүнг харуулсан мэргэжлийн чиглэлийн эрэлт, нийлүүлэлтийн бодлого, үйл ажиллагааг шинэчлэн сайжруулах шаардлага байгааг тус судалгааны үр дүн харууллаа.

Хүснэгт 5. ИДС төгсөгчдийн судалгааны мэдээлэл цуглуулах хугацааны өмнөх 7 хоногийн хөдөлмөр эрхлэлтийн байдал /мэргэжлийн чиглэлээр/

Мэргэжлийн чиглэл	Нийт төгсөгчид	Ажил эрхэлсэн төгсөгч		Ажил эрхлээгүй төгсөгч	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Багш боловсрол судлал	4925	3854	78,3	1071	21,7
Урлаг	580	451	77,8	129	22,2
Хүмүүнлэгийн ухаан	1985	1083	54,5	902	45,5
Нийгэм, эдийн засаг	2725	2310	84,8	415	15,2
Мэдээлэл, сэтгүүл зүй	558	446	80,0	112	20,0
Бизнес удирдлага	6012	4676	77,8	1336	22,2
Хууль эрхзүй	1873	1249	66,7	624	33,3
Биологи	713	491	68,9	222	31,1
Физик, хими, геологи, газарзүй	209	158	75,6	51	24,4
Математик статистик	222	178	80,0	44	20,0
Компьютер	783	574	73,3	209	26,7
Бүх төрлийн инженер	1341	1013	75,6	328	24,4
Үйлдвэрлэлийн технологи	578	398	68,9	180	31,1
Барилга, архитектур	258	241	93,3	17	6,7
ХАА, ой, загасны аж ахуй	549	437	79,5	112	20,5
Мал эмнэлэг	136	103	75,6	33	24,4
Анагаах ухаан	1664	1368	82,2	296	17,8
Нийгмийн халамж, хангамж	371	253	68,2	118	31,8
Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ	649	404	62,2	245	37,8
Тээвэр болон бусад	46	39	85,0	7	15,0
Байгаль хамгаалал	84	53	63,6	31	36,4
Цэрэг, цагдаа, аюулгүй байдал	764	642	84,1	122	15,9
Бүгд, дундаж %	27025	20422	75,3	6603	24,7

Мэргэжлийн боловсролын салбараас нийлүүлэгдэж байгаа мэргэжлийн анхан шатны болон мэргэжлийн тусгай дунд боловсролтой мэргэжилтэй ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгааны үр дүнг танилцуулая.

Судалгаанд хамрагдсан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгсөгчдийн мэргэжлийн чиглэл тус бүрээрх хөдөлмөр эрхлэлтийн хувийн дундаж нь 43.4 хувь байгаа нь ИДС төгсөгчидтэй харьцуулахад тааруухан үр дүн байлаа. Үүний шалтгааныг дараах хүчин зүйлстэй холбон тайлбарлаж болох юм.

1. Хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжилтэй ажиллах хүчний эрэлтийг дээд боловсролтой ажиллах хүчнээр орлуулдаг төлөв байдал бий болсон. Дээд боловсролын салбарын зарим мэргэжлүүдээр нийлүүлэлтийн илүүдэл бий болсон, нөгөө талаас ажил олгогчид дээд боловсролтой ажиллах хүчнийг төдийлөн мэдлэг, ур чадвар шаардагдахааргүй ажлын байранд ч авч ажиллуулах сонирхол нийтлэг байдаг нь мэргэжилтэй ажилтан, цаашлаад мэргэжилгүй ажилтнуудын хөдөлмөр эрхлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байх талтай юм.
2. Мэргэжлийн боловсролын салбараас байгаль цаг уурын онцлогоос хамаарсан хөдөлмөрийн зах зээлийн багтаамжийн хэлбэлзэлтэй эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын мэргэжлээр ажиллах хүчнийг олноор нийлүүлдэг. Гэтэл тус судалгааны мэдээлэл цуглуулах хугацаа нь 3-4 дүгээр сарууд буюу улирлын шинж чанартай ажиллах

хүчний эрчимтэй эрэлтийн цаг үе хараахан эхлээгүй байсан үетэй давхацсан. Мэргэжлийн салбаруудаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, барилга, автозам, байгаль хамгаалал-аялал жуулчлал, ойн аж ахуйн геологи уул, уурхайн салбарын мэргэжилтэй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал хамгийн сул байгаа нь дурьдсан шалтгаантай холбоотой гэж үзэж байна.

3. Эрэлт, нийлүүлэлтийн зөрүүтэй холбон үзэж болно. Тухайлбал сургалтын байгууллагаас байгаль хамгаалал, аялал жуулчлал болон холбооны салбарын мэргэжилтэй ажилтныг бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад цөөн тоогоор нийлүүлж байгаа хэдий ч хөдөлмөр эрхлэлтийн хувьд төгсөгчдийн 33.3 хувь нь л ажил хийдэг байсан нь тогтоогдсон.
4. МСҮТ төгсөгчдийн хувьд ИДС-д элсэн суралцаж, боловсролын түвшинг дээшлүүлж буйтай холбоотойгоор хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо сул байдаг.

Мэргэжлийн чиглэл тус бүрээр хөдөлмөр эрхлэгсдийн хувийн жинг авч үзвэл тээвэр, соёл урлаг, ойн аж ахуй, мод боловсруулалтын салбарын мэргэжил эзэмшсэн төгсөгчдийн 50-аас дээш хувь нь хөдөлмөр эрхэлж хамгийн өндөр жинг үзүүлсэн бол, байгаль хамгаалал-аялал жуулчлал, холбооны салбарын мэргэжилтэй төгсөгчид хамгийн бага тус бүр 33.3 хувийн хөдөлмөр эрхлэлттэй байсан байна.

Хүснэгт 6. МСҮТ төгсөгчдийн судалгааны мэдээлэл цуглуулах хугацааны өмнөх 7 хоногийн хөдөлмөр эрхлэлтийн байдал /мэргэжлийн салбараар/


Мэргэжлийн салбар	Нийт төгсөгчид	Ажил эрхэлсэн төгсөгч		Ажил эрхлээгүй төгсөгч	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Барилга, автозам, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар	5984	2781	46,5	3203	53,5
ХАА-н үйлдвэрлэлийн салбар	1045	373	35,7	672	64,3
Ойн аж ахуй, мод боловсруулалтын салбар	218	109	50,0	109	50,0
Байгаль хамгаалагч, аялал жуулчлалын салбар	247	82	33,3	165	66,7
Тээврийн салбар	2001	1170	58,5	831	41,5
Холбооны салбар	163	54	33,3	109	66,7
Мэдээллийн технологийн салбар	1424	633	44,4	791	55,6
Аж үйлдвэрийн салбар	3611	1664	46,1	1947	53,9
Геологи, уул уурхайн салбар	1297	514	39,7	783	60,3
Захиргааны үйлчилгээний ажилтан	1875	687	36,6	1188	63,4
Соёл урлагын салбар	184	98	53,3	86	46,7
Бүгд, дундаж хувь	18049	8166	43,4	9883	56,6

Судалгааны мэдээлэл цуглуулахаас өмнөх 7 хоногийн хугацаанд ямар нэг ажил эрхлээгүй байсан төгсөгчид нийт төгсөгчдийн 36.6 хувь буюу 16,5 мянга байсан.

Хэдийгээр ажилгүйдлийн шалтгааныг бүхэлд нь илэрхийлэх мэдээлэл болж чадахгүй ч гэсэн тус судалгаагаар төгсөгчдийн ажил

эрхлээгүй шалтгааныг тодруулсан. Нийт 7 үзүүлэлтээр ажилгүйдлийн шалтгааныг хэмжин үзэхэд хувийн ажилтай байсан /35.3%/, гэрийн ажилтай байсан буюу хүүхэд, өндөр настан, өвчтэй хүн харсан /18.0%/, ажлын байранд орохыг хүлээсэн /9.0%/, болон сургууль, сургалтанд элсэхийг хүлээсэн /8.8%/, зэрэг шалтгаануудыг хамгийн олноор нэрлэжээ.

Зураг 9. Төгсөгчдийн судалгааны мэдээлэл цуглуулах хугацааны өмнөх 7 хоногт ажил хийгээгүй шалтгаан



Ажил хийгээгүй шалтгаанаар хүйсийн хувьд ялгаатай тал байгаа эсэхийг судлан үзсэн. Хөдөлмөрт бэлтгэх сургалтанд хамрагдсаны улмаас ажил хийгээгүй төгсөгчид 100 хувь эрэгтэйчүүд, хувийн ажилтай байсан шалтгаанаар ажил хийгээгүй төгсөгчдийн 55.7 хувь нь эрэгтэйчүүд байсан. Харин эмэгтэйчүүдийн хувьд түр амарсан, эсвэл ээлжийн амралттай байсан, мөн түүнчлэн гэрийн ажилтай буюу хүүхэд, өндөр настан асарсны улмаас ажил эрхлээгүй хэсгийн хувийн жин хамгийн өндөр байна.

Дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн мэргэжлийн чиглэлүүдээр ажил хийгээгүй зарим шалтгааны тархалтыг задлан шинжлэе. Эрхэлж байсан ажил нь зогссон, эсвэл дууссаны улмаас хамгийн олон төгсөгч ажил хийгээгүй байсан нь хууль эрхзүй, хүмүүнлэгийн ухаан, компьютерийн мэргэжилтнүүд байсан бол, мэргэжлийн сургалтанд хамрагдсаны

улмаас багш, боловсрол судлалын мэргэжилтнүүд, хууль эрхзүй, анагаах ухаан, биологийн мэргэжилтнүүдийн хувийн жин хамгийн өндөр байна. Мөн ажлын байранд орохоор хүлээж байсан төгсөгчдөөс бизнес удирдлага, хууль эрхзүй, багш боловсрол судлалын мэргэжилтнүүд давамгайлсан үр дүн гарсан.

Харин мэргэжлийн боловсролын байгууллага төгсөгчдийн тухайд барилга, авто зам, барилгын материалын салбарын мэргэжилтэй ажилтан болон аж үйлдвэрийн салбарын мэргэжилтнүүдийн ажил нь дууссан, эсвэл зогссон учраас ажил хийгээгүй байсан нь бусад мэргэжлүүдтэй харьцуулахад илүү өндөр байлаа. Мэргэжлийн сургалтанд хамрагдсан шалтгаанаар ажил хийгээгүй төгсөгчид олон байгаа нь аж үйлдвэр, байгаль хамгаалал, аялал жуулчлал, мэдээллийн технологи, тээвэр, барилга, авто зам, барилгын материалын салбарын мэргэжилтэй

ажилтнууд байсан төдийгүй, барилгын салбарын мэргэжилтэй ажилтнуудын тухайд ажлын байранд орохоор хүлээсний улмаас ажил хийгээгүй гэсэн хариултыг өгөх нь олонтоо байжээ. Барилгын ажлын тодорхой хугацааны турш үргэлжлэн дуусдаг онцлогоос хамаарч ажил зогсох, дуусах, ажлын байранд орохыг хүлээх зэрэг нөхцөл байдал нь барилгын салбарын хөдөлмөр

эрхлэлтэд нөлөөлдөг болохыг барилгын салбарын мэргэжилтэй ажилтнуудын эдийн засгийн оролцооны талаарх судалгааны үр дүн харууллаа. Төгссөн сургалтын байгууллагын төрөл, мэргэжлийн чиглэл тус бүрээр төгсөгчдийн ажил хийгээгүй шалтгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралтын хүснэгт 1-ээс харах боломжтой.

БҮЛЭГ 3. ТӨГСӨГЧИЙН СУРГУУЛЬ, МЭРГЭЖЛИЙН ТАЛААРХ ҮНЭЛЭМЖ

3.1 СУРГУУЛЬ, МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН ШАЛТГААН, СЭТГЭЛ ХАНАМЖ


Өмнөх бүлэгт төгсөгчдийн мэргэжил, сургуулийн төрөл, сургуулийн өмчийн хэлбэрийн талаар дэлгэрэнгүй авч үзсэн. Тэгвэл энэхүү “Төгсөгчийн сургууль, мэргэжлийн сонголт, сэтгэл ханамжийн байдал”-ын талаарх судалгааны үр дүнгийн тайлангийн 3 дугаар үндсэн бүлэгт эзэмшсэн мэргэжил болон төгссөн сургуулийг

сонгосон шалтгаан, сургуулийн талаарх сэтгэл ханамжийн түвшин, үргэлжлүүлэн суралцагчидтай холбоотой судалгааны үр дүнгүүдийг танилцуулах юм.

Элсэн суралцсан сургуулийг сонгосон шалтгааныг 7 нэрлэсэн үзүүлэлтээр хэмжиж үзсэн.

Зураг 10. Төгссөн сургуулийг сонгон суралцсан шалтгаан

Хэмжих нэгж: тоо



Дээрх зургаас харахад төгссөн сургуулиа сонгосон шалтгаануудаас сонирхсон мэргэжлийн дагуу гэсэн хүчин зүйлийг илүү олноор нэрлэсэн байгаа нь тухайн сургуулийн бэлтгэдэг мэргэжлүүдэд элсэгчид онцгой анхаарал хандуулдаг болохыг илтгэж байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдагсдын 55.8 хувь нь сонирхсон мэргэжлийн дагуу тухайн сургуульд элсэн суралцсан байна.


Мөн суурь боловсролын дүн сургуулийн босго онооны шаардлагыг хангасан учраас тухайн сургуульд элсэн суралцсан гэж нийт төгсөгчдийн 16.5 хувь буюу 7,5 мянга, эцэг эх, багш нар санал болгосон учраас тухайн сургуулийг сонгосон гэж 12.3 хувьтай тэнцэх 5,5 мянган төгсөгч хариулсан байгаа нь эдгээр хүчин зүйлсийн сургууль сонголтод нөлөөлдөг ач холбогдлыг илэрхийлж байгаа хэрэг юм.

Сургууль сонголтын шалтгааны талаарх мэдээлэлд дээд болон мэргэжлийн боловсролын сургуулийн төгсөгчдөд ялгаа байгаа эсэхийг задлан үзэхэд аль аль нь сонирхсон мэргэжлийн дагуу элссэн шалтгааныг хамгийн олон дурьджээ. Дээд боловсролын салбарт сургуулийн босго оноонд сурлагын голч дүн тохирч байгаагаас хамаарч сургууль сонголтыг хийдэг байдал дээрээс хоёрт нэрлэгдсэн хүчин зүйл байхад мэргэжлийн боловсролын салбарт эцэг, эх, багш нарын санал болгосны дагуу сургуулиа

сонгосон шалтгаан давамгайлсан байгаа нь энэ хоёр салбарын ялгаатай талыг харуулжээ.

Мөн ИДС-д элсэгчид сургуулийн нэр хүнд, олонд танигдсан байдалд өгөх ач холбогдлын хэмжээгээр МСҮТ төгсөгчдөөс илүү байгаа бол, МСҮТ төгсөгчид хувийн зан төлөв, найз нөхдийн хүрээлэл, гэр сургууль хоорондын зай зэрэг хүчин зүйлсийг илүү анхааран үзсэн сонголт хийсэн талаар дараах Зураг 11-ээс үзэж болохоор байна.

Зураг 11. Төгссөн сургуулийг сонгон суралцсан шалтгаан /сургуулийн төрлөөр/



Монгол улсын суурь боловсролын тогтолцоонд өсвөр үеийнхэнд мэргэжлийг таниулан ойлгуулах, мэргэжлийг хэрхэн зөв сонгох талаарх зөвлөгөө мэдээлэл өгөх, хувь хүний зан төлөвийн онцлогийг таньж мэдэх, хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжлийн эрэлт, нийлүүлэлттэй холбоотой мэдээллээр хангах сургалтын агуулга, хөтөлбөр хангалтгүй байдаг. Тиймээс мэргэжлээрээ ажиллаж сонирхолгүй залуус, нөгөө талаас мэргэжлийн үл нийцэл буюу зах зээлд эрэлт багатай мэргэжил эзэмшсэнээс улбаалж

ажилд орж чадахгүй байгаа үзэгдэл түгээмэл болсон.

Төгсөгчид эзэмшсэн мэргэжлээ хэрхэн сонгосон, өөрөөр хэлбэл тэдний мэргэжил сонголтод нөлөөлсөн хамгийн чухал хүчин зүйл юу байсныг судлан үзсэн. Мэргэжил сонголтод нөлөөлсөн хүчин зүйлийг 7 нэрлэсэн үзүүлэлтээр хэмжиж үзсэн.


Судалгаанд хамрагдагсдаас цуглуулсан мэдээллээр нийт төгсөгчдийн талаас дээш хэсэг буюу 53.8 хувьтай тэнцэх 24,2 мянга

нь өөрийн хүсэл сонирхлыг харгалзан үзэж мэргэжлээ сонгосон гэж хариулжээ. Түүний дараа элсэлтийн босго оноо, суурь боловсролын дүн тухайн мэргэжлээр суралцах шаардлагыг хангасан гэж 12.8 хувь буюу 5,8 мянга, ажил мэргэжлээрээ хөгжих боломжтой хэмээн үзсэн учраас гэж 12.4 хувь буюу 4,6 мянган төгсөгч хариулсан

нь хамгийн өндөр хувийн жинг харуулсан мэргэжил сонголтын шалтгаанууд болж байна. Хамгийн багаар нэрлэсэн шалтгаан нь найз нөхөд, ахлах ангийн сурагчдын санал болгосноор /1.1 хувь/, мэргэжлийн үнэлэмж, нэр хүндийг харгалзан үзсэн /1.8 хувь/ зэрэг байна.

Зураг 12. Төгсөгчдийн мэргэжил сонголтын шалтгаан

Хэмжих нэгж: тоо




Сургуулийн хэлбэрийн хувьд ИДС болон МСҮТ-д элсэн ороходоо өөрийн хүсэл сонирхлын дагуу мэргэжлээ сонгон суралцсан хувийн жин бусад шалтгаантай харьцуулахад адил, хамгийн өндөр байлаа. Өөрөөр хэлбэл ИДС төгсөгчдийн 53.2 хувь буюу 14,4 мянган төгсөгч, МСҮТ төгсөгчдийн 54.7 хувь буюу 9,9 мянган төгсөгч мэргэжлээ өөрийн сонирхлын дагуу сонгосон болохоо илэрхийлжээ.

Харин ИДС төгсөгчдийн дунд сургалтын голч онооны боломжоос хамаарч ямар мэргэжлийг сонгон суралцах шийдвэр гаргасан төгсөгчид олон байгаа юм. Эдгээр

нь нийт төгсөгчдийн 15.5 хувийг эзэлж байгаа бол, энэ тоо хэмжээ МСҮТ төгсөгчдийн тухайд 8.7 хувьтай тэнцүү байжээ. МСҮТ төгсөгчдийн мэргэжил сонголтод хүчтэй нөлөө үзүүлсэн нэг хүчин зүйл нь эцэг, эх, багш нарын санал байсан ба, энэ шалтгааны улмаас мэргэжлээ сонгосон төгсөгчид нийт МСҮТ төгсөгчдийн 16.7 хувьтай тэнцэх 3,0 мянга гаруй байна. Мөн МСҮТ-д элсэгчид нь ИДС-д элсэгчидтэй харьцуулахад сонгосон мэргэжлийн талаарх нийгмийн үнэлэмж, нэр хүндээс илүүтэйгээр найз нөхөд, ахлах ангийн сурагчдын саналд илүү ач холбогдол өгдөг болох нь тодорхойлогдсон.

Зураг 13. Төгсөгчдийн мэргэжил сонголтын шалтгаан /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар



Төгссөн сургуулийн талаарх сэтгэл ханамжийн талаар судалсан судалгааны үр дүнг танилцуулья. Сургуулийн талаарх сэтгэл ханамжийг сургалтын орчин, нөхцөл болон сургалтын үйл явцын сэтгэл ханамж гэсэн хоёр үндсэн хэсэгт ангилан, нийт 7 үзүүлэлтээр сэтгэл ханамжийн түвшинг огт хангалуун бус /1/, хангалуун бус /2/, ердийн /3/, хангалуун /4/, маш хангалуун /5/ гэсэн түвшингүүдээр үнэлүүлсэн.

Дээд боловсролын салбарын 2011 оны төгсөгчдийн үнэлгээгээр их, дээд сургуулийн талаарх сэтгэл ханамжийн түвшин дунджаар 3.5 байгаа нь сэтгэл ханамжийн ердийнөөс дээгүүр ч хангалуун хэмжээнд байж чаддаггүй түвшинг илэрхийлж байгаа юм. Энэ салбарын хэмжээнд сургалтын орчин-нөхцлийг үнэлүүлсэн сургалтын тоног төхөөрөмж, оюутны тусгай хангамж, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгохтой холбоотой зөвлөгөө өгөх, дэмжих хөтөлбөр гэсэн 4 үзүүлэлтийн

дунджаар сэтгэл ханамжийн 3.3 гэсэн түвшин тодорхойлогдлоо.

Харин сургалтын үйл явцыг үнэлүүлсэн сургалтын хөтөлбөр-агуулга, багшийн ур чадвар-хичээл зүтгэл болон хичээл заах арга барил, чанар гэсэн 3 үзүүлэлтийн дунджаар 3.9 гэсэн сэтгэл ханамжийн түвшин тодорхойлогдож байгаа нь сургалтын орчин-нөхцөлтэй харьцуулахад өндөр байгаа юм. Мэргэжлийн сургалтын салбарын төгсөгчдийн төгссөн сургуулийн талаарх сэтгэл ханамжийн түвшин дунджаар 3.6 гарч байгаа нь дээд боловсролын салбараас илүү сэтгэл ханамжтай байгааг илэрхийлж байна.

Сүүлийн жилүүдэд мэргэжлийн боловсролын салбарт томоохон өөрчлөлтүүд гарч, хөрөнгө оруулалт хийгдэж буйтай холбоотойгоор зарим сургуулиудын сургалтын орчин нөхцөл сайжирсан нь МСҮТ-үүдийн талаарх төгсөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээнд нөлөөлсөн байж болох талтай.

Сургалтын орчин, нөхцлийн талаарх сэтгэл ханамжийн түвшин нь 3.4, сургалтын үйл явцын талаарх сэтгэл ханамжийн түвшин нь 3.9 байгаа юм.

Нийт МСҮТ төгсөгчид болон ИДС төгсөгчдийн үнэлгээгээр хамгийн сайн сэтгэл ханамжийн түвшинг харуулж буй үзүүлэлт нь багшийн ур чадвар, хичээл зүтгэл болон хичээл заах арга барил, сургалтын чанарын асуудал байсан юм. Энэ нь сургалтын байгууллагуудын материаллаг бааз, сургалтын орчин, хэрэгслэлийг сайжруулахад анхаарах, улмаар сургалтанд нэвтрүүлэх хэрэгцээг илтгэж байна. Харин оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний талаарх сэтгэл ханамж хамгийн сул байгаа нь боловсрол, хөдөлмөрийн салбарын уялдаа холбоог сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

Сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр төгсөгчдийн сэтгэл ханамжид

ялгаа байгаа эсэхийг дэлгэрүүлэн авч үзье. Төрийн өмчийн сургууль төгссөн төгсөгчид сургалтын орчин нөхцөл төдийгүй сургалтын үйл явцын талаар төрийн бус өмчийн сургууль төгссөн төгсөгчдөөс өндөр сэтгэл ханамжтай байдаг үр дүн гарсан. Өөрөөр хэлбэл сургалтын орчин нөхцлийн талаарх төрийн өмчийн сургууль төгсөгчдийн сэтгэл ханамж 3.4 байгаа бол хувийн өмчийн сургууль төгсөгчдийнх 3.3, харин сургалтын үйл явцтай холбоотой төрийн өмчийн сургууль төгсөгчдийн сэтгэл ханамж 4.0 байгаа бол, хувийн өмчийн сургууль төгсөгчдийнх 3.9 байжээ. Ялангуяа хувийн өмчийн сургууль төгсөгчдийн хувьд оюутны тусгай хангамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамж хамгийн сул байхад, төрийн өмчийн сургууль төгсөгчдийн хувьд багш нарын ур чадвар, сургалтын чанарт хамгийн сэтгэл ханамжтай байдаг нь тогтоогдсон.

Хүснэгт 7. Төгссөн сургуулийн талаарх төгсөгчдийн сэтгэл ханамж /сургуулийн төрөл болон өмчийн хэлбэр тус бүрээр/

Хэмжих нэгж: тоо

Сургуулийн төрөл	Сургуулийн өмчийн хэлбэр	Сургалтын орчин нөхцөл					Сургалтын үйл явц				
		Сургалтыг дэмжих тоног төхөөрөмж	Оюутны тусгай хангамж	Оюутны ХЭД арга хэмжээ	АМЧБО зөвлөгөө, хөтөлбөр	Дундаж	Сургалтын үйл явц	Багшийн ур чадвар, хичээл зүтгэл	Хичээл заах арга барилга, сургалтын чанар	Дундаж	Нийт дундаж
ИДС	Төрийн өмчийн	3.5	3.1	3.0	3.2	3.2	3.9	4.0	4.0	4.0	3.6
	Хувийн өмчийн	3.5	3.2	3.3	3.2	3.3	3.7	3.8	3.8	3.8	3.6
МСҮТ	Төрийн өмчийн	3.7	3.5	3.5	3.4	3.5	3.9	4.0	4.0	3.9	3.7
	Хувийн өмчийн	3.5	3.3	3.2	3.2	3.3	3.9	4.0	4.0	3.9	3.6
Дундаж	ИДС	3.5	3.2	3.2	3.2	3.3	3.8	3.9	3.9	3.9	3.6
	МСҮТ	3.6	3.4	3.3	3.3	3.4	3.9	4.0	4.0	3.9	3.7
	Төрийн өмчийн	3.6	3.3	3.3	3.3	3.4	3.9	4.0	4.0	4.0	3.7
	Хувийн өмчийн	3.5	3.2	3.2	3.2	3.3	3.8	3.9	3.9	3.9	3.6

3.2 ДАХИН СУРАЛЦАГСАД

Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд 2011 онд ИДС болон МСҮТ төгссөн нийт төгсөгчдийн 16.5 хувь 7,5 мянга нь дахин суралцаж байгаа үр дүн гарсан.


Тайлангийн энэ хэсэгт дахин суралцагсдын хамрагдаж буй сургалтын төрөл, дахин сурч буй шалтган, одоогийн сурч буй мэргэжлийн чиглэл болон өмнө эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдал, адил мэргэжлээр суралцаагүй шалтгаан зэргийг судалсан үр дүнгийн талаар авч үзэх болно.

2011 онд төгсөгчдийн дахин сургалтанд хамралтын хувиар МСҮТ төгсөгчид давамгайлж, нийт дахин суралцагсдын 58.5 хувийг эзэлж байгаа юм.

Дахин суралцаж буй төгсөгчдийн хамрагдаж буй сургалтын төрлийг судлан үзэхэд олонх нь буюу 61.9 хувьтай тэнцэх 4,6 мянга нь ИДС-д бакалаврын зэргээр суралцаж байгаа гэж хариулжээ. Мөн магистр, докторантурт сурч байгаа гэж 24.6 хувь буюу 1,8 мянга нь хариулсан байна.

ИДС-д бакалавраар суралцагсдын 24.6 хувь өмнө нь ИДС төгссөн, үлдсэн 75.4 хувь өмнө нь МСҮТ төгсөгчид байгаагаас харахад эдгээр төгсөгчдийг мэргэжлээ солих зорилгоор суралцагсад, эсвэл мэргэжил дээшлүүлж, боловсролын түвшинг ахиулан суралцагсад гэж үзэж нэрлэж болох юм.

Зураг 14. Дахин суралцагсдын сургалтын төрөл /сургуулийн төрлөөр/



2011 онд ИДС болон МСҮТ төгсөгчдөөс 16.5 хувь нь дахин суралцаж байгаа ба, тэдний дахин суралцаж буй шалтгааныг 7 хүчин зүйлээр хэмжиж үзэхэд 2/3-аас их хэсэг нь мэргэжил дээшлүүлэх болон боловсролын түвшин ахиулах зорилгоор суралцаж байгаа гэж хариулжээ. Мөн сонирхсон ажилдаа орохын тулд суралцах шаардлагатай болсон нь нийт дахин суралцагсдын 23.0 хувь буюу 1,7 мянган төгсөгчийн шийдвэр байжээ.


Хөдөлмөрийн зах зээлд мэргэжил, ур чадварын зөрүүгээс үүдэлтэйгээр ажилд ороход хүндрэлтэй байдаг талаарх мэдээлэл түгээмэл байдаг учраас энэ талаар лавлан судалсан. Нийт дахин суралцагсдын 1.2 хувь буюу 92 төгсөгч “мэргэжил, ур чадварт тохирох ажил олдоогүйн улмаас

үргэлжлүүлэн суралцахаар шийдсэн” гэж хариулсан үр дүн гарсан байгаа нь ажил мэргэжлийн үл нийцэл ажилгүйдэлд нөлөөлж байгаа хүчтэй нөлөөлөгч биш гэж үзэж болох талтай ч дахин суралцагсдын бусад шалтгаанаас үзэхэд шинээр төгсөгчид ажил хийх гэхээс илүүтэйгээр боловсрол, ур чадвараа дээшлүүлэхэд илүү анхаарч байгаа нөхцөл байдлыг тооцон үзэх ёстой юм.

Сургуулийн төрлөөр дахин суралцаж буй шалтгаануудын тархалт ерөнхий байдлаар нийтлэг байна. Дахин суралцагч МСҮТ төгсөгч болон ИДС төгсөгчдөд эзлэх хувиар мэргэжил дээшлүүлэх, боловсролын түвшин ахиулах, сонирхсон ажилдаа орохын тулд үргэлжлүүлэн суралцаж байгаа шалтгаанууд өндөр байгаа юм.

Зураг 15. Дахин суралцаж буй шалтгаан

Хэмжих нэгж: тоо




Дахин суралцаж буй судалгаанд хамрагдагсдаас одоо суралцаж буй мэргэжлийн чиглэл өмнө эзэмшсэн мэргэжлийн чиглэлтэй хэр нийцтэй талаар тодруулсан. Энэхүү судалгааны үр дүнгээс харахад суралцагсдын 36.6 хувь буюу 2,7 мянга өмнө эзэмшсэн мэргэжлээс огт өөр, 33.9 хувь буюу 2,5 мянга нь өмнө эзэмшсэн мэргэжилтэй адил, 15.8 хувь буюу 1,2 мянга өмнө эзэмшсэн мэргэжилтэй төсөөтэй, 8.2 хувь буюу 0,6 мянга нь өмнө эзэмшсэн мэргэжилтэй ойролцоо, үлдсэн 5.5 хувь буюу 0,4 мянга нь өмнө эзэмшсэн мэргэжилтэй бага зэрэг төсөөтэй мэргэжлээр суралцдаг болохыг мэдээллэсэн.

Сургуулийн төрлөөр ангилан үзвэл МСҮТ төгсөгчдийн дунд мэргэжил солих байдал ИДС-тэй харьцуулахад их байна. Үүнийг МСҮТ төгсөгчдийн 42.5 хувь, ИДС төгсөгчдийн 28.3 хувь огт өөр мэргэжлээр суралцаж байгаа талаарх судалгааны үр дүн харуулж байгаа юм. Мөн ИДС төгсөгчдөөс дахин суралцаж буй бүлгийн 59.3 хувь өмнө нь эзэмшсэн мэргэжилтэй адил болон төсөөтэй мэргэжлээр суралцаж байгаа бол, энэ тоо хэмжээ МСҮТ-ийн тухайд 43.0 хувь байна.

Зураг 16. Одоо суралцаж буй болон өмнө эзэмшсэн мэргэжлийн нийцлийн түвшин /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувь




Суралцаж буй мэргэжил нь өмнө нь эзэмшсэн мэргэжлээс огт өөр болон бага зэрэг төсөөтэй хэсгийн нийт дүнгээр адил мэргэжлийг сонгон суралцаагүй шалтгааныг тодруулсан.

Мэргэжлээ солихыг хүссэн гэж 41.6 хувь, эзэмшсэн мэргэжлээр өсөн дэвших, хөгжих боломж багатай гэж 23.4 хувь, эзэмшсэн мэргэжлээр ажилд ороход хүндрэлтэй байсан гэж 18.3 хувь, эзэмшсэн мэргэжил хувийн зан төлөвт тохирдоггүй гэж 3.1 хувь, үлдсэн 13.6 хувь нь бусад шалтгааны улмаас өөр мэргэжлийг сонгон үргэлжлүүлэн суралцаж байгаа нь тодорхойлогдсон.

Энэ мэдээлэл МСҮТ төгсөгч болон ИДС төгсөгч тус бүрээр ялгаа байгаа эсэхийг задлан үзвэл мэргэжлээ солихыг хүссэн тохиолдол аль алинд нь хамгийн өндөр хувийн жинг үзүүлсэн байна. ИДС төгсөн өөр мэргэжлээр суралцагсдын хувьд эзэмшсэн мэргэжил нь хувийн зан төлөвт таарч тохирохгүй хүндрэл байдаггүй гэж хариулсан бол, МСҮТ төгсөгчдөд энэ асуудал нь багагүй бэрхшээл болдогыг өөр мэргэжлээр суралцаж буй төгсөгчдийн мэдээлэл тодорхойлж байна.

Зураг 17. Адил мэргэжлийг сонгон суралцаагүй шалтгаан /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар



БҮЛЭГ 4. ТӨГСӨГЧИЙН СУРАЛЦАХ ХУГАЦААНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

4.1 ТӨГСӨГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, МЭРГЭЖЛИЙН НИЙЦЭЛ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны үр дүнгийн тайлангийн 4 дүгээр бүлгийн 4.1 дэх “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, түүний шалтгаан, мэргэжлийн нийцэл” гэсэн хэсэгт сургуульд суралцаж байх хугацааны хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог тэдний хөдөлмөр эрхлэлтийн байдалтай холбон судалсан үр дүнг танилцуулна. Өөрөөр хэлбэл төгсөгчид суралцах хугацаанд ажил хийдэг байсан эсэх, ажил хийхэд нөлөөлсөн хүчин зүйл юу болох, эрхэлж байсан ажлын чиг үүрэг нь эзэмшсэн мэргэжилтэй нийцтэй байсан эсэх талаарх мэдээллийг энэ хэсэг агуулах юм.

2011 онд төгсөгчдийн 36.7 хувь нь суралцаж байх хугацаандаа ажил хийж ажлын туршлага, хөдөлмөрийн дадал хуримтлуулсан бол, 63.3 хувь нь суралцаж байх хугацаандаа ажил хийж байгаагүй гэж хариулжээ.

Тэгвэл энэ үзүүлэлт сургуулийн төрлөөр ялгаа байгаа эсэхийг тодруулахад ИДС төгсөгчдийн 42.9 хувь буюу 11,6 мянга нь ажил хийж байсан, 57.1 хувь буюу 15,4 мянга нь ажил хийж байгаагүй бол, МСҮТ төгсөгчдийн 27.3 хувь буюу 4,9 мянга нь ажил хийж байсан, 72.7 хувь буюу 13,1 мянга нь ажил хийж байгаагүй үр дүнг харуулжээ.

Сургуульд суралцах хугацаанд ажил хийж байсан төгсөгчдийн ажлын туршлагыг


ажилласан ажлын байрны тоогоор хэмжихэд, ИДС болон МСҮТ төгсөгчдийн сургуульд суралцах хугацааны ажлын байрны дундаж тоо 1.5 гэж тооцоологджээ. Энэ үзүүлэлт ИДС төгсөгчийн тухайд 1, МСҮТ төгсөгчийн хувьд 2 байгаа юм.

Суралцах хугацааны хөдөлмөр эрхлэлтийн байдлаар МСҮТ төгсөгчидтэй харьцуулахад ИДС төгсөгчид илүү их байгаа ч, ажлын байрны дундаж тоогоор МСҮТ төгсөгчдийн ажлын байрны тоо олон байгааг харж болж байна. Үүнээс ИДС-д суралцагсад нь суралцах хугацааны эдийн засгийн оролцооны идэвхи МСҮТ-ээс илүү сайн, харин МСҮТ-д суралцагсад нийт суралцагсдын хөдөлмөр эрхлэлт бага ч ажлын байрны шилжих хөдөлгөөн ихтэй байдаг байна.

ИДС болон МСҮТ-д суралцах хугацаанд ажил хийж байсан төгсөгчдөөс тэдний хөдөлмөр эрхлэлтийн шалтгааны талаар тодруулсан. Хөдөлмөр эрхлэлтийн шалтгааныг 8 үзүүлэлтээр дамжуулан тодруулахад өдөр тутмын хэрэглээний мөнгө олох зорилгоор ажил хийсэн гэж нийт ажил хийж байсан төгсөгчдийн 54.7 хувь нь хариулсан байна. Үүний дараа ажлын туршлага хуримтлуулах /15.2 хувь/, сургалтын төлбөрийн мөнгө олох /15.1 хувь/ шалтгаануудыг нэрлэж болохоор байгаа ба дэлгэрэнгүйг дараах зураг 18-д үзүүлэе.

Зураг 18. Суралцах хугацаанд ажил хийсэн шалтгаан

Хэмжих нэгж: хувиар




Төгссөн сургуулийн төрлөөр ажил хийсэн шалтгааныг нарийвчлан үзвэл МСҮТ болон ИДС төгсөгчдийн аль ч бүлэгт өдөр тутмын хэрэглээний мөнгө олох шалтгаанаар суралцах хугацаанд тодорхой ажлын туршлага хуримтлуулсан тохиолдол давамгайлжээ. Хоёр бүлэгт

нийтлэг сургалтын төлбөрийн мөнгө олох зорилгоор ажил хийсэн төгсөгчид олон байгаа ба, МСҮТ төгсөгчдийн хувьд ажлын туршлага хуримтлуулах хэрэгцээгээр, ИДС төгсөгчдийн тухайд чөлөөт цагаа ашиглах зорилгоор ажил хийсэн төгсөгчдийн хувийн жин өндөр байгаа нь онцлог байгаа юм.

Зурга 19. Суралцах хугацаанд ажил хийсэн шалтгаан /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: тоогоор



Суралцах хугацаандаа ажиллаж байсан ажлын байранд гүйцэтгэж байсан ажил үүрэг нь эзэмшсэн мэргэжилтэй хэр нийцсэн талаар судалсан. Төгсөгчдийн суралцах хугацааны ажлын туршлагын тоо харилцан адилгүй байгаа ба 1-ээс дээш тооны ажлын туршлагатай бол нийт ажлын байрны дунджаар энэхүү ажил үүрэг болон мэргэжлийн нийцлийн түвшинг хэмжсэн.


Мэргэжлийн болон дээд боловсролын салбараас ажлын туршлагатай бөгөөд мэргэжилтэй ажиллах хүчнээр нийлүүлэгдсэн төгсөгчдийн 25.7 хувь нь эзэмшсэн мэргэжилтэйгээ огт тохирдоггүй ажил үүргийг гүйцэтгэсэн талаар мэдээллэсэн байгаа нь хамгийн өндөр хувийн жинг харуулжээ. Бусад ажлын туршлагатай төгсөгчдийн тухайд маш сайн тохирдог 25.3 хувь, тохирдог 20.9 хувь, тохирдоггүй 15.1 хувь болон дунд зэрэг гэж 13.0 хувь гэсэн тархалттай байна.

Сургуулийн төрлөөр ажлын туршлагын ажил үүрэг, эзэмшсэн мэргэжил хоорондын нийцлийн түвшинд ялгаа байгаа эсэх талаар одоо тайлбарлая.

ИДС төгсөгчдийн 36.2 хувь нь огт тохирдоггүй, 13.3 хувь нь тохирдоггүй, 14.7 хувь нь дунд зэрэг, 19.2 хувь нь тохирдог, 17.7 хувь нь эзэмшсэн мэргэжилтэйгээ маш сайн тохирсон ажлын туршлагыг суралцах хугацаандаа хуримтлуулсан гэжээ. Харин МСҮТ төгсөгчдийн хувьд 18.1 хувь нь огт тохирдоггүй, 16.4 хувь нь тохирдоггүй, 12.4 хувь нь дунд зэрэг, 22.3 хувь нь тохирдог, 30.8 хувь нь маш сайн тохирдог гэсэн мэдээлэл өгчээ.

Үүнээс ИДС төгсөгчдийн суралцах хугацааны хөдөлмөр эрхлэлт нь ихэвчлэн мэргэжлийн бус байдаг бол, МСҮТ-ийн суралцагсдын тухайд суралцаж буй мэргэжлээрээ ажлын туршлага хуримтлуулах боломж илүү байдаг нь харагджээ.

Зураг 20. Суралцах хугацааны ажлын туршлага болон мэргэжлийн нийцэл /сургуулийн төрлөөр/



Мэргэжлийн чиглэлийн тархалтаар суралцах хугацааны хөдөлмөр эрхлэлтийн ажил үүрэг болон эзэмшсэн мэргэжил хоорондын нийцэлд ямар ялгаа байсан талаар дэлгэрүүлэн авч үзье.

ИДС-ийн суралцах хугацааны ажлын туршлагатай төгсөгчдийн дунджаар 49.3 хувь нь эзэмшсэн мэргэжилтэй огт тохирдоггүй болон тохирдоггүй ажил хийж байсан бол, нийгэм-эдийн засаг /66.7%/,

физик, хими, геологи газарзүй /64.5%, хүмүүнлэгийн ухаан/60.0%/-ы мэргэжлээр суралцагсдын мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт бусад суралцагсдаас илүү өндөр байжээ. Харин эзэмшсэн мэргэжилтэй маш сайн тохирдог болон тохирдог ажил үүргийг гүйцэтгэж байсан мэргэжлийн чиглэлүүдэд цэрэг, цагдаа аюулгүй байдал /70.0%/, урлаг /52.9%/ болон анагаах ухаан /50.0%/ багтжээ.

МСҮТ-ийн тухайд сургууль төгсөхөөс өмнөх хөдөлмөр эрхлэлттэй төгсөгчдөөс холбооны салбар /100.0%/, тээврийн салбар /61.7%/, мэдээллийн технологийн

салбар /58.8%/-ын мэргэжлээр суралцагсад суралцаж байсан мэргэжилтэй огт тохирдоггүй болон тохирдоггүй ажил үүргийг гүйцэтгэсэн талаар мэдээллэсэн. Эзэмшсэн мэргэжилтэй хамгийн сайн нийцтэй ажил хийж, мэргэжлийн ажлын туршлага хуримтлуулсан нь барилга-авто зам, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар /91.1%/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбар /70.8%/, соёл урлагын салбар/70.0%/-ын мэргэжлээр суралцагсад байжээ.

4.2 АЖИЛД ОРОХ ҮЙЛ ЯВЦ, БЭРХШЭЭЛ

Судалгааны ажлын хүрээнд төгсөгчдийн ажилд ороход ихээр анхаардаг хүчин зүйлсийг ач холбогдлын 1-ээс 5 хүртэлх түвшингээр хэмжиж судалсан. Мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагын нийт төгсөгчдийн дунджаар авч үзвэл ажилд ороход хамгийн их ач холбогдол өгч, харгалзан үздэг хүчин зүйл нь цалин ба цалингийн талаарх ач холбогдлын түвшин байлаа. Мөн түүнчлэн хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа болон өсөн хөгжих боломжийг онцгойлон анхаарч үздэг болох нь 4.1 гэж тодорхойлогдсон ач холбогдлын түвшин илэрхийлж байна. Харин нийт

төгсөгчдийн хувьд ажилд ороход төдийлөн анхаарч үздэггүй хүчин зүйлээр 3.3 гэсэн ач холбогдлын түвшингээр илэрхийлэгдсэн ажлын цаг болон ажил гэр хоорондын зай байсан.

Сургуулийн төрлөөр ажилд ороход анхааран үздэг хүчин зүйлсэд ялгаа байгаа ба МСҮТ төгсөгчдийн хувьд ажлын байрны цалин, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хангалт зэрэгт илүү их анхаардаг байхад ИДС төгсөгчид нь өсөн хөгжих боломж болон ажил мэргэжлийн ирээдүйтэй байдалд онцгойлон ач холбогдол өгдөг байна.

Хүснэгт 8. Ажилд орох хүсэлт гаргахад анхаардаг хүчин зүйл /сургуулийн төрлөөр/

Хүчин зүйл	Бүгд /дундаж/	ИДС төгсөгч	МСҮТ төгсөгч
Цалин	4.1	4.0	4.3
Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа	4.1	4.0	4.1
Байгууллагын нэр хүнд	3.9	3.9	3.4
Ажлын чиг үүргийн хүндрэл	3.8	3.7	3.9
Ажлын ачаалал	3.6	3.6	3.6
Өсөн хөгжих боломж	4.2	4.2	4.1
Ажил мэргэжлийн ирээдүй	4.1	4.2	3.9
Ажлын цаг	3.7	3.7	3.3
Ажил гэрийн хоорондын зай	3.1	3.1	3.3
Хувийн зан чанарт нийцэх байдал	3.5	3.4	3.7

Дээд боловсролын салбараас нийлүүлэгдсэн нийгэм-эдийн засаг, тээвэр, математик-статистик, урлагынхан ажил мэргэжлээр өсөн хөгжих боломж, мэргэжлийн ирээдүйтэй байдалд илүүтэй ач холбогдол өгдөг байхад, байгаль хамгаалал, багш боловсрол судлал, мал эмнэлэг, компьютерийн мэргэжилтнүүдийн тухайд ач холбогдол багатай үзүүлэлт байгаа юм.

Мөн ИДС-ийн мэдээлэл-сэтгүүлзүй, нийгэм-эдийн засгийн мэргэжилтнүүд цалинг, биеийн тамир спорт, тээврийн чиглэлийн мэргэжилтнүүд хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны хангалтыг ажилд орох хүсэлт гаргах шийдвэр гаргахад илүү их нөлөө үзүүлдэг гэж хариулжээ.

МСҮТ төгсөгчдийн хувьд хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны хангалт болон цалингийн хэмжээ нь ажлын байрны сонголтод онцгой үүрэг гүйцэтгэдэг хүчин зүйлс гэж үзсэн. Тухайлбал мэдээллийн технологийн салбар, аж үйлдвэрлэлийн салбарын мэргэжилтэй ажилчдад хөдөлмөрийн нөхцөл-аюулгүй ажиллагааны хангалт илүү чухал бол, геологи-уул уурхайн салбар, тээврийн салбарын мэргэжилтэй ажилчид цалинг нэн тэргүүний зорилт болгодог нь тогтоогдсон. Сургуулийн төрөл болон мэргэжлийн чиглэл тус бүрээрх ажилд ороход анхаардаг хүчин зүйлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтын хүснэгт 2-оор харууллаа.

Суралцаж байх хугацаанд ажиллаж байсан ажлын байрны мэдээллийн эх


сурвалжийн талаар тодруулахад нийт төгсөгчдийн 20.2 хувь нь сонин, телевизийг ашигласан талаар дурьдсанаас харахад хэвлэл мэдээллийн хэрэгслэл нь оюутан залуусын ажлын байрны мэдээллийн гол эх сурвалж болохыг илэрхийлж байна. Мөн найз нөхөд, хамт суралцагсад /15.1 хувь/, интернэтээс буюу ажлын зар, ажил олгогч байгууллагын вэбсайт /14.0 хувь/-ын хэлбэрийг түлхүү ашиглаж, ажилтай болдог нь төгсөгчдийн өгсөн мэдээллээс харагдлаа.

Нийт төгсөгчдийн ажлын байрны мэдээллийн эх үүсвэрийн хамгийн идэвхгүй хэлбэр нь сургалтын төв, сургуулийн оюутныг дэмжих төв зэрэг байгууллагууд байгаа нь энэ чиглэлийн байгууллагуудын үйл ажиллагааны сул талыг харуулж байна.

Ажлын байрны мэдээллийн эх сурвалжуудаас хамгийн нийтлэг хэрэглээ нь ИДС-д суралцагсдын тухайд хэвлэл мэдээллийн хэрэгсэл /20.2%/ , интернэтээс буюу ажлын зар, ажил олгогч байгууллагын вэбсайт /16.3%/ , найз нөхөд хамт суралцагсад /15.9%/ , ажлын байрны зарын сонин /9.9%/ зэрэг байна.

Тэгвэл МСҮТ-д суралцагсад мөн адил хэвлэл мэдээллийн хэрэгслэлийг илүү түгээмэл ашигладаг ба энэ хэрэгслэлийг ашиглагч нь 20.6 хувь, ажлын байрны зарын сонин 19.5 хувь, эцэг эх, хамаатан садны хүн 13.3 хувь, 12.9 хувь найз нөхөд хамт суралцагсдын сүлжээг ашиглан ажлын байрны мэдээллийг голчлон олж авдаг нь тогтоогдсон.

Зураг 21. Ажлын байрны мэдээллийн эх сурвалж /сургуулийн төрлөөр/




Төгсөгчдийн суралцах хугацааны хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судлагдахууны хүрээнд тодруулсан өөр нэг асуудал нь төгсөгчдийн ажил хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаанд тулгардаг хүндрэл бэрхшээл юм. Энэхүү хүндрэл бэрхшээлийг судлахдаа хамгийн түгээмэл тохиолдож болох 9 асуудлаар хэмжиж үзсэн.

Хамгийн олноор нэрлэсэн, өөрөөр хэлбэл төгсөгчдөд хамгийн нийтлэг бэрхшээл болдог зүйл нь ажлын туршлага дутах явдал ба нийт төгсөгчдийн 23.3 хувь

нь энэхүү бэрхшээлийг нэрлэжээ. Цалин хөлсний талаарх сэтгэл ханамжгүй байдал ажил хийхэд хүндрэл болдог гэж судалгаанд оролцогсдын 21.9 хувь, ажлын байрны талаарх мэдээлэл бага байдаг гэж 19.4 хувь нь хариулсан байгаа нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд түгээмэл тохиолддог бэрхшээлүүд болохыг илэрхийлж байгаа юм. Харин төгсөгчдийн хувьд гадаад дүр төрх, биеийн хөгжил болон ар гэрийн нөхцөл байдал ажилд орох асуудалд төдийлөн бэрхшээл болдоггүй нь судалгаанаас харагдлаа.

Зураг 22. Ажил хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаанд тулгардаг бэрхшээл

Хэмжих нэгж: хувиар




Сургуулийн төрлийн хэлбэрээр ажилд ороход тулгардаг хүндрэл бэрхшээлийн эрэмбэд ИДС болон МСҮТ төгсөгчдийн хооронд ялгаа бага байна. Ажлын туршлагын

бэрхшээлийг ИДС төгсөгч хамгийн олноор нэрлэсэн бол, МСҮТ төгсөгч цалинг нэрлэжээ.

Зураг 23. Ажил хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаанд тулгардаг бэрхшээл /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар



Шинээр төгсөгчдийн хувьд ажлын туршлагатай хүн цөөн учир ажлын байрны шаардлагад ажлын туршлага заасан нь ажилд ороход хүндрэл учруулдаг шалтгаан болж байна. Ажилд зуучлагдахгүй байгаагийн нэг шалтгаан нь ажлын байрны талаарх мэдээллийн хомсдол, мөн түүнчлэн

ажил олгогчоос санал болгож буй цалинг голох үзэгдэл байгаа юм. Нээлттэй ажлын байрны мэдээллийн хомсдлыг багасгахын тулд хөдөлмөр зуучлалын байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэдээллийг хүртээмжтэй болгоход анхааран ажиллах хэрэгтэй нь ажиглагдаж байна.

4.3 ТӨГСӨГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОО

Сургууль төгсөгчид, залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийн болон сургалтын байгууллагуудаас түлхүү зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд хамрагдаж байсан талаар судлан үзсэн.

ИДС болон МСҮТ-д элсэн орсон цагаас хойш хөдөлмөрт бэлтгэх сургалт, хөтөлбөрт хамрагдагдсан төгсөгчид нийт төгсөгчдийн 42.0 хувь байгаа бол, үлдсэн 58.0 хувь нь энэ төрлийн арга хэмжээнд хамрагдаж байгаагүй гэж хариулсан байна.

Сургалт, хөтөлбөрийн төрлөөр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө өгөх хөтөлбөрт хамгийн олон төгсөгч хамрагдсан ба нийт хамрагдагсдын 24.5 хувийг эзэлж байгаа юм. Мөн ил хөдөлмөрийн аялал буюу байгууллагын үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн ажиллагаатай танилцах арга хэмжээнд хамрагдагсад 22.3

хувь, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрт бэлтгэх, зөвлөгөө мэдээлэл өгөх арга хэмжээнд хамрагдагсад 18.8 хувь, зан төлөв, сэтгэлзүйн сорил тестэд хамрагдагсад 16.8 хувийг тус тус эзэлж байгаа нь хамгийн өргөн хамралттай хөтөлбөр, арга хэмжээнүүдээр тодорхойлогджээ.

Хамралтын цар хүрээ хамгийн багатай байсан сургалт, хөтөлбөр нь ажлын байран дахь хөтөлбөр, үйлдвэрлэлийн дадлага болон ярилцлагын техник, өөрийгөө танилцуулахад бэлтгэх хөтөлбөр зэрэг байжээ.

Сургуулийн төрөл тус бүрээр хамгийн өргөн болон сул хамралттай сургалт, хөтөлбөрүүд адил байлаа. Дараах хүснэгтээр төгсөгчдийн мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагад суралцах хугацаанд хамрагдсан хөдөлмөрт бэлтгэх сургалт, хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг харууллаа.

Хүснэгт 9. Хөдөлмөрт бэлтгэх, сургалт хөтөлбөрт хамрагдсан байдал /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар

Нэр	АМЧО, хөдөлмөрт бэлтгэх, зөвлөгөө мэдээлэл өгөх	АБ дахь хөтөлбөр, үйлдвэрлэлийн дадлага	Зан төлөвийн сорил, сэтгэлзүйн сорил тест	Сургуулиас зохион байгуулсан хөдөлмөрийн яармаг	АМЧО бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө өгөх хөтөлбөр	Ярилцлагын техник, өөрийгөө танилцуулахад бэлтгэх хөтөлбөр	Ажил хөдөлмөрийн аялал, байгууллагын үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн ажиллагаатай танилцах	Бусад
ИДС төгсөгч	19.7	4.1	18.0	2.7	23.0	6.2	20.7	5.7
МСҮТ төгсөгч	14.9	2.5	11.9	2.5	31.0	4.2	29.3	3.7
Бүгд	18.8	3.8	16.8	2.7	24.5	5.8	22.3	5.3

Үүнээс үзэхэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж байгаа ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа нь бусад арга хэмжээнүүдтэй харьцуулахад илүү өргөн далайцтай явагдаж, олон суралцагсдыг хамарч чадаж байгаа нь сайшаалтай юм. Энэ төрлийн арга хэмжээ нь хувь хүн өөрийгөө мэргэжил болон

ажлын байранд хэрхэн бэлтгэх, улмаар хөдөлмөрийн зохистой зан төлөвийг төлөвшүүлэх зэрэгт хувь нэмэр оруулдаг сайн талтай. Суралцаж байх хугацааны турш төгсөгчид ажлын байран дахь сургалт, үйлдвэрлэлийн дадлагад багаар хамрагдаж байгаа нь ажлын дадал суух, төгсөөд ажлын байран дээр шууд гарахад дасан зохицох

зэрэг олон асуудалд хүндрэл учирч болох учраас цаашид сургалтын байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр дорвитой арга хэмжээ авч, хэрэгжүүлэх шаардлагатай байгааг сануулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйлчилгээ, арга хэмжээнд оролцож байсан талаар судалгаанд хамрагдагсдаас тодруулсан. Эдгээр арга хэмжээнүүдийн дийлэнх хэсэг нь сүүлийн 2 жилийн хугацаанд илүү далайцтайгаар хэрэгжиж байгаа, сургалтын байгууллагуудад чиглэсэн арга хэмжээнүүд цөөнгүй байгаа зэргээс шалтгаалж цаг хугацааны хувьд нийцтэй буюу 2011 онд ИДС болон МСҮТ төгсөгчдөөс энэ талаар тодруулах нь зүйтэй гэж үзсэн.

Судалгаагаар нийт сургууль төгсөгчдийн 15.9 хувь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцож байсан бол, үлдсэн 84.1 хувь нь оролцож байгаагүй нь тогтоогдсон.

Энэ төрлийн үйл ажиллагаанд оролцогсдоос хөдөлмөрийн бирж, хувийн

хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаагаар дамжуулан ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх арга хэмжээнд оролцогсод хамгийн олон буюу нийт оролцогсдын 19.9 хувь байгаа юм. Түүний дараа Оюу толгой төслийн хөрөнгө оруулалтаар мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрт 16.4 хувь нь оролцсон, аймаг, дүүрэг хороонд байршуулсан ажлын байрны зар хайх мэдээллийн цахим самбарыг ашигласан гэж 16.2 хувь, 15.1 хувь нь www.labor.net.mn, www.hudulmur.mn, www.mergejil.mn вэб сайтаар үйлчлүүлсэн эрэмбийг үзүүлжээ. Дээд боловсролын салбараас нийлүүлэгдсэн төгсөгчдийн 18.1 хувь, мэргэжлийн боловсролын салбараас нийлүүлэгдсэн төгсөгчдийн 12.5 хувь нь суралцах хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцсон дүн гарсан. Хамгийн олноор оролцсон үйл ажиллагааны төрөл нь сургуулийн төрөл тус бүрээр нийт дүнтэй адил байгаа ба, мэргэжлийн боловсролын салбарын төгсөгчдөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр мэргэжлийн үнэмлэх олгох түр сургалтанд хамрагдсан төгсөгчид олон байсан нь ялгаатай байлаа.

Хүснэгт 10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны оролцоо /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар

Нэр	Хөдөлмөрийн бирж, хувийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаагаар дамжуулж, ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	Ажил, амьдралын гараа төгсөгчдийн хөдөлмөрийн яармаг, бусад яармаг	www.labor.net.mn , www.hudulmur.mn , www.mergejil.mn вэб сайтын ажиллагаа	Аймаг, дүүрэг, хороонд байршуулсан ажлын байрны зар хайх мэдээллийн цахим самбар	Хөдөөөлмөр эрхлэлтийг дэмжих, сангийн хөрөнгөөр мэргэжлийн үнэмлэх олгох түр сургалт зохион байгуулах	Жижиг дунд үйлдвэрийн сангийн хөрөнгөөр хөнгөлөлттэй зээл олгон аж ахуй, бизнесийг дэмжи	Оюу толгой төслийн хөрөнгө оруулалтаар мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр
ИДС	19.7	7.3	16.4	15.4	10.6	11.3	15.9
МСҮТ	20.5	7.4	12.4	18.0	15.2	9.1	17.5
БҮГД	19.9	9.7	15.1	16.2	12.0	10.6	16.4

БҮЛЭГ 5. ТӨГСӨГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны үр дүнгийн тайлангийн энэ бүлэгт нийт төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн идэвхийг судалсан дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулах юм. Мэдээлэл цуглуулах хугацаанд ажил хийж байсан эсэхээс хамаарч нийт төгсөгчид

ажил хийсэн, ажил хийгээгүй гэсэн хоёр үндсэн бүлэгт хуваагдаж байгаа ба 5 дугаар бүлгийн эхний хэсэг “Өнөөгийн эдийн засгийн идэвхи”-т ажил хийгээгүй хэсэгтэй холбоотой багц мэдээллийн талаар тайлбарлана.

5.1 ӨНӨӨГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИ


Судалгаанд хамрагдагсдын 36.6 хувь 16,5 мянга нь судалгааны мэдээлэл цуглуулах хугацааны өмнөх 7 хоногт ажил хийгээгүй нь тогтоогдсон. Энэхүү ажил хийгээгүй төгсөгчид ажил хийгээгүй ч ажлын байртай байсан эсэх, мөн түүнчлэн ажил хайж байгаа эсэх, ажил хайгаагүй бол шалтгаан нь юу болох талаар судалсан үр дүнгийн талаар энэ хэсэгт дэлгэрэнгүй танилцуулах юм.

Ажил хийгээгүй байсан ч ажлын байртай байсан төгсөгч нь нийт ажил хийгээгүй төгсөгчдийн 4.2 хувь буюу 1,9 мянга байжээ. Ажлын байртай байсан ч ажил хийгээгүй

шалтгааны талаар тодорхой мэдээлэл өгөөгүй хэсгийн хувийн жин хамгийн өндөр 43.9 хувь байгаа бол, ээлжийн амралттай болон суралцах шалтгаанаар 29.9 хувь нь ажил эрхлээгүй гэж хариулсан нь нэрлэсэн шалтгаануудад өндөр жинг үзүүлж байна. Мөн ар гэрийн ажил, өвчтэй байсан гэх мэт хувийн шалтгааны улмаас ажлаа хийж чадаагүй төгсөгчид цөөнгүй байгаа юм. Ажил олгогч хоорондын зөрчилдсөн шалтгаанаар ажлаа хийгээгүй тохиолдол гараагүй бол, ажил нь зогссоны улмаас ажил хийгээгүй нь 1.5 хувь байгаа нь бусад үзүүлэлттэй харьцуулахад бага байлаа.

Зураг 26. Ажлын байртай байсан ч ажил хийгээгүй шалтгаан /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: Тоо




Ажил хийгээгүй төгсөгчдөөс ажил хайж байгаа эсэхийг лавласан. Нийт 16,5 мянган төгсөгч ажил хийгээгүй байгаагийн 19.5 хувьтай тэнцэх 3,2 мянган төгсөгч ажил хайж, үлдсэн 80.5 хувь буюу 13,3 мянган төгсөгч ажил хайгаагүй гэсэн мэдээлэл өгсөн. Ялангуяа МСҮТ төгсөгчдийн хувьд ажил хайх идэвхи илүү сул байгаа ба, ажил хийгээгүй байсан МСҮТ төгсөгчдийн 86.6 хувь нь энэ төлөвт харьяалагдаж, харин энэ үзүүлэлт ИДС төгсөгчдийн тухайд 71.3 хувь байлаа.

Ажил хайгаагүй төгсөгчдийн олонх нь буюу 58.3 хувь буюу 7,7 мянга нь ар гэрийн ажил болон сургуульд суралцаж байгаа гэсэн шалтгаануудын улмаас ажил хайгаагүй бол, нас тохирохгүй байдал, гэрт ойр ажил олдохгүй, боловсрол ажлын туршлага дутсан зэрэг шалтгаанаас хамаарсан эдийн засгийн идэвхгүй байдал бага байжээ.

Сургуулийн хэлбэр тус бүрээр ажил хайгаагүй шалтгааныг задлан үзвэл хамгийн нийтлэг шалтгаан дээр дурьдсан ар гэрийн ажил болон сургуульд сурч байсан зэрэг байна. Харин ИДС төгсөгчдийн дунд мэргэжил, ур чадварт тохирох ажлын байр байхгүйн улмаас 5.2 хувь нь, шинээр сургуульд элсэн орохоор бэлтгэсний улмаас 4.1 хувь нь ажил хайгаагүй гэж хариулсан байгаа нь өндөр байгаа юм. МСҮТ төгсөгчдийн хувьд мөн адил шинээр сургуульд орохоор бэлтгэсэн гэж 3.8 хувь, өвчтэй байсан болон цэрэгт явахаар хүлээж байсан гэж тус бүр 3.1 хувь нь хариулсан байгаа нь МСҮТ төгсөгчдийн эдийн засгийн идэвхгүй байдлын гол шалтгаанууд болж байна. Сургуулийн төрөл тус бүрээр ажил хайгаагүй шалтгааны тархалтыг дараах зураг 27-оор харуулья.

Зураг 27. Ажил хийгээгүй төгсөгчдийн ажил хайгаагүй шалтгаан /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: тоо




5.2 ТӨГСӨГЧИЙН АЖЛЫН ТУРШЛАГЫН БАЙДАЛ

Судалгааны тайлангийн энэ хэсэгт төгсөгчдийн нийт хөдөлмөрийн түүхийг тодруулсан ажлын туршлагын талаарх ерөнхий мэдээллийг тайлбарлах юм. Төгсөгчдийн ажлын туршлагын мэдээллээр олон болон цөөн ажлын туршлагатай, эсвэл огт ажлын туршлагагүй хэсгийг ангилан тодорхойлсон.

2011 оны хичээлийн жилд нийт 45,1 мянган залуус төгссөн ба сургуульд суралцаж байх болон сургууль төгссөнөөс хойшхи хугацаанд нийт төгсөгчдийн 53.4 хувьтай тэнцэх 24,1 мянга нь нэг л ажил хийж байгаа, 24.5 хувь буюу 11,0 мянга нь огт ажил хийж байгаагүй, 16.0 хувь буюу 7,2 мянга одоогийн ажлаас гадна олон ажлын туршлагатай, 5.4 хувь буюу 2,5 мянга нь одоогоор ажил хийгээгүй ч өмнө нь ажил хийсэн нэг туршлагатай, үлдсэн 0.7 хувь буюу 0,3 мянга нь

одоогоор ажил хийгээгүй ч өмнө нь олон ажил хийж байсан туршлагатай хэмээн хариулсан байна. Үүнээс нийт төгсөгчдийн 58.8 хувь нэг ажлын туршлагатай байгаа нь төгссөнөөс хойшхи 15 сарын дараах байдлаар тэдний талаас илүү хэсэг нь ажлын байрны солилтгүй, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг хадгалсан байгааг харж болох юм. Мөн төгсөгчдийн 16.7 хувь хэдий нь олон ажлын байранд ажиллан, ажлын дадал, туршлага хуримтлуулсан байна. Огт ажил хийж, туршлага хуримтлуулаагүй хэсгийн эзлэх хувийн жин 24.5 байгаа нь анхаарал хандуулахаас өөр аргагүйд хүргэж байна. Иймээс судалгааны энэхүү үр дүнд тулгуурлан тэдний ажил хийгээгүй шалтгааныг дэлгэрүүлэн судлах, энэ бүлгийн онцлогийг тодорхойлж, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх бодлого, үйл ажиллагаагаар дэмжих хэрэгцээ байгааг дурьдах нь зүйтэй болов уу.

Зураг 28. Төгсөгчдийн ажлын туршлагын байдал /сургуулийн төрлөөр/



Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн ажлын туршлагыг эзэмшсэн мэргэжилтэй нь харьцуулан авч үзье. Нийт төгсөгчдийн 65.7 хувь нь сургуульд суралцах болон төгссөнөөс хойшхи хугацаанд зөвхөн нэг л ажлын туршлагыг хуримтлуулсан ба, энэ бүлэгт харьяалагдаж буй төгсөгчдийн 94.0 хувьтай дүйцэх 16,4 мянга нь тухайн ажлын байрандаа одоо ч үргэлжлүүлэн ажиллаж, үлдсэн 6.0 хувь буюу 1,5 мянга нь ажлаасаа гарч, ажил хийгээгүй байсан нь судлагдсан.

Мэргэжлийн чиглэлийн хувьд бусад мэргэжилтэй харьцуулахад хамгийн тогтвортой хөдөлмөр эрхлэлттэй буюу нэг ажлын байранд тасралтгүй ажиллах байдлаар хамгийн өндөр үзүүлэлтийг үзүүлж байгаа нь нийгэм-эдийн засгийн мэргэжилтэн /76.1%/, тээвэр, байгаль хамгааллын мэргэжилтэн /тус бүр 75.0%/, математик статистикийн мэргэжилтэн /68.9%/, компьютерийн мэргэжилтэн, бүх төрлийн инженер, үйлдвэрлэлийн технологийн мэргэжилтэн, болон мал эмнэлгийн мэргэжилтэн /тус бүр 66.7%/-үүд байна.

Харин хэд хэдэн ажил хийж, олон ажлын туршлагатай болсон байдлаар анагаах ухаан, барилга-архитектур болон мэдээлэл-сэтгүүл зүйн мэргэжилтнүүд /тус бүр 31.1%/- бусад мэргэжилтнүүдээс давамгайлжээ. Дээд боловсролын салбараас нийлүүлсэн хүмүүнлэгийн ухааны мэргэжилтнүүдийн 36.4 хувь, хууль эрхзүйн мэргэжилтнүүдийн 31.1 хувь, биеийн тамир, спортын мэргэжилтнүүдийн 26.7 хувь, нийгмийн халамж, хангамжийн мэргэжилтнүүдийн 20.5 хувь, биологийн мэргэжилтнүүдийн 20.0 хувь огт ажил хийж байгаагүй нь эдгээр мэргэжлийн нийлүүлэлтэд анхаарал хандуулах шаардлага хөдөлмөрийн зах зээлд үүссэн байгаа талаарх дохио болж байна.

Мэргэжлийн боловсролын салбараас 2011 онд нийлүүлэгдсэн нийт төгсөгчдийн 47.3 хувь буюу 2,8 мянга нь сургалтын туршид болон дараах хугацаанд зөвхөн нэг л ажил хийсэн дүр зураг гарсан бол, тэдний 48.3 хувь буюу 1,4 мянга нь одоогоор

ажил хийгээгүй, үлдсэн 51.7 хувьтай тэнцэх 1,5 мянга нь ажлын байрандаа тасралтгүй ажиллаж байгаа нь судлагдсан.

Ялангуяа МСҮТ төгсөгчдийн хувьд тээврийн салбарын мэргэжилтэй ажилтнууд хамгийн тогтвортой хөдөлмөр эрхлэлттэй / энэ мэргэжлийн салбарын нийт төгсөгчдийн 62.3 хувийг эзэлсэн/ байгаа ба, түүний дараа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбар /57.1%/, барилга-авто зам, барилгын материалын салбар /52.4%/, ойн аж ахуй-мод боловсруулалтын салбар, геологи-уул уурхайн салбарын мэргэжилтэй ажилтнууд / тус бүр 50.0%/-ыг нэрлэж болохоор байна.

МСҮТ төгсөгчдөөс 10.2 хувь нь хэд хэдэн ажил хийсэн буюу олон ажлын туршлагатай гэж судлагдсан ба ялангуяа байгаль хамгаалагч-аялал жуулчлалын мэргэжилтэй ажилтнуудын дунд энэ үзэгдэл хамгийн түгээмэл байжээ.

Нийт төгсөгчдийн тэн хагас буюу түүнээс дээш хэсэг нь огт ажил хийгээгүй, ажлын туршлага хуримтлуулаагүй нь холбоо /66.7%/, захиргаа-үйлчилгээний ажилтан /52.1%/- болон ойн аж ахуй-мод боловсруулалт /50.0%/-ын чиглэлийн мэргэжил эзэмшсэн мэргэжилтэй ажилтнууд байгаа юм.

Судалгааны үр дүнгийн тайлангын “Төгсөгчдийн ажлын туршлага”-ын талаарх энэ хэсэгт тайлбарлах асуудлын нэг нь ажлын байранд ортол зарцуулах хугацааны мэдээлэл юм. Нийт төгсөгчдийн 24.5 хувь буюу 11,0 мянга гаруй нь огт ажил хийж байгаагүй учраас ажлын туршлагатай 75.5 хувийн тухай яригдах юм¹.

Ажилд ортол зарцуулсан хугацааг сургууль төгсөхөөс өмнө болон дараах хугацаанд гэсэн хоёр хүрээнд ангилан авч

¹Тайлбар: Төгсөгчид нь хөдөлмөр эрхлэлтийн ялгаатай төлөв байдалд байгаа ба үүнийг “Ажилд ортол зарцуулсан хугацаа”-ны талаарх мэдээллээр хэрхэн ойлгон судалсныг тайлбарлая. Нэг ажлын туршлагатай, түүндээ одоо хүртэл ажиллаж байгаа бол тэрхүү ажлын байранд ортол зарцуулсан хугацаа Хэд, хэдэн ажил зэрэг хийж байгаа бол хамгийн олон цаг зарцуулж буй ажилдаа орох хүртэл зарцуулсан хугацаа Одоогоор ажилгүй ч өмнө нь нэг ажил хийж байсан бол тэрхүү ажилдаа ортол зарцуулсан хугацаа Одоогоор ажил хийгээгүй ч өмнө нь хэд хэдэн ажил хийж байсан бол хамгийн урт хугацааны турш ажилласан ажлын байранд ортол зарцуулсан хугацаа

үзвэл нийт ажлын туршлагатай төгсөгчдийн 9.3 хувь буюу 3,2 мянга нь сургууль төгсөхөөс өмнө, харин үлдсэн 90.7 хувь буюу 30,9 мянга нь сургуулиа төгссөний дараа тогтвортой ажлын байртай болсон гэж хариулжээ. Төгссөний дараах хугацааг задлавал төгссөнөөс хойш 3 хүртэл сарын дотор 16.1 хувь, 4-6 сарын дараа 20.0 хувь, 7-12 сарын дараа 20.0 хувь, 13 болон түүнээс дээш сарын дараа 34.5 хувь ажилтай болсон байна. Үүнээс шинээр сургууль төгсөгчдийн тэн хагасаас дээш хэсэг нь сургууль

төгссөнөөс хойш дор хаяж хагас жилийн дараа байнгын ажилтай болж чаддаг байгаа юм. Иймд энэ хугацааг богиносгох, мөн хөдөлмөрт бэлтгэх, ажилд ороход чиглүүлэх богино хугацааны хөтөлбөр, сургалтанд хамруулах бодлого, арга хэмжээг хөгжүүлэх, идэвхижүүлэх шаардлагатай байна. Дараах хүснэгт 11-т төгсөгчдийн ажилд орох хүртэл зарцуулах хугацааг төгсөгчдийн хүйс, төгссөн сургуулийн байршлын ялгаатай байдлаар нарийвчлан үзүүлье.

Хүснэгт 11. Төгсөгчдийн ажилд ортол зарцуулах хугацаа /хүйс, сургуулийн байршлаар/

Хэмжих нэгж: тоо

Ангилал	Төгсөхөөс өмнө	Төгссөөд 3 сар дотор	Төгссөөд 4-6 сар дараа	Төгссөөд 7-12 сарын дараа	Төгссөөд 13+ сарын дараа	
Бүгд	3183	5496	6807	6813	11745	
Хүйс	Эрэгтэй	1784	2722	2879	2314	5364
	Эмэгтэй	1399	2774	3928	4499	6381
	Баруун	194	328	221	271	620
Байршил	Хангай	262	235	243	355	843
	Төв	430	314	303	777	983
	Зүүн	75	278	223	271	257
	Улаанбаатар	2222	4341	5818	5139	9043

Төгсөгчдийн мэргэжлийн чиглэлүүдээрх ажилд ороход зарцуулсан хугацааны дэлгэрэнгүй мэдээллийг задлан авч үзье.

ИДС төгсөгчдийн 11.7 хувь нь төгсөхөөс өмнө ажилтай болсон бол, мэдээлэл-сэтгүүлзүйн мэргэжилтнүүдийн 24.4 хувь, урлагын мэргэжилтнүүдийн 24.3 хувь, үйлдвэрлэлийн ажилтнуудын 23.1 хувь, мал эмнэлгийн мэргэжилтнүүдийн 17.9 хувь, математик-статистикийн мэргэжилтнүүдийн 17.5 хувь, бүх төрлийн инженерүүдийн 15.4 хувь нь энэ бүлэгт харьяалагдаж байгаа нь хамгийн их хэмжээг харуулж байна.

Хамгийн урт хугацаа зарцуулж ажилтай болж буй мэргэжлүүдээс хууль эрхзүйн мэргэжилтэн /тухайн мэргэжлээр нийт төгсөгчдийн 48.4 хувь/, нийгмийн халамж, хамгааллын мэргэжилтэн /45.7 хувь/, хүмүүнлэгийн ухааны мэргэжилтэн /42.9 хувь/, багш-боловсрол судлалын мэргэжилтэн /41.0 хувь/-үүд нэрлэж болохоор байна.

МСҮТ-ийг нийт төгсөгчдийн 13.2 хувьтай тэнцэх 1,5 мянга нь сургуулиа төгсөхөөс өмнө ажилтай болжээ. Харин 14.8 хувь буюу 1,6 мянга нь төгссөнөөс хойш 3 сарын дотор, 12.4 хувь буюу 1,4 мянга нь 4-6 сар

дотор, 22.3 хувь буюу 2,5 мянга нь 7-12 сар дотор, 37.2 хувь буюу 4,1 мянга нь 13-аас дээш сарын дараа ажилтай болсон тархалтыг харуулжээ. Мэргэжлийн салбарын хувьд геологи-уул уурхайн салбар болон барилга, авто зам, барилгын материал үйлдвэрлэлийн салбарын мэргэжилтэй

ажилтнууд бусдаас эрт хөдөлмөр эрхлэлттэй, харин холбооны салбар, ойн аж ахуй-мод боловсруулалтын салбар, соёл урлагын салбарынхан ажилд ортол хамгийн урт хугацааг зарцуулж байгаа судалгааны үр дүн гарсан.

5.3 ТӨГСӨГЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ, ОНЦЛОГ

2011 онд ИДС болон МСҮТ төгсөгчдийн 24.5 хувь буюу 11,0 мянга сургуульд суралцах, төгссөнөөс хойшхи нийт хугацаанд ажил огт хийж байгаагүй, өөрөөр хэлбэл ажлын туршлагагүй байгаа талаар судалгааны үр дүнгийн тайлангийн 5.2 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Харин нийт төгсөгчдийн 75.5 хувьтай тэнцэх 34,0 мянга нь нэг болон хэд хэдэн ажлын туршлагатай бол, судалгааны тайлангийн энэ хэсэгт эдгээр ажлын туршлагатай төгсөгчдийн ажлын байрны талаар дэлгэрэнгүй судалсан үр дүнг танилцуулан, хөдөлмөрийн зах зээл дэх шинэ мэргэжилтэй ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, онцлогийг тодорхойлохыг зорьлоо².

Ажлын байрны төлөв байдал, онцлогийг хэд хэдэн үзүүлэлтээр тодруулан судалсан. Нийт төгсөгчдийн 86.7 хувь буюу 29,5 мянга нь байнгын ажлын байранд ажиллажээ. Мөн түр ажлын байранд ажиллагсдын тоо хэмжээ нийт ажлын туршлагатай төгсөгчдийн 7.9 хувь буюу 2,7 мянга байгаа бол, үлдсэн 5.4 хувьтай тэнцэх 1,8 мянга нь улирлын чанартай ажил эрхэлж байжээ. Үүнээс үзэхэд ажлын туршлагатай нийт төгсөгчдийн олонх нь багадаа 6 сараас дээш хугацааны турш тухайн ажлыг хийсэн бол, үлдсэн хэсэг нь 6 сараас бага хугацаагаар, мөн улирлын

чанартай түр ажлын байранд богино хугацаагаар ажилласан дүр зураг харагдаж байна.

Ажлын байрны хэлбэрийн хувьд төрийн болон хувийн өмчийн сургууль төгсөгчдийн тухайд төдийлөн ялгаа харагдсангүй, мөн адил дийлэнх нь буюу 85-аас дээш хувь нь байнгын ажлын байранд харьяалагдаж байгаа бол хувийн өмчийн сургууль төгсөгчдийн улирлын чанартай хөдөлмөр эрхлэлтийн оролцоо төрийн өмчийн сургууль төгсөгчидтэй харьцуулахад харьцангуй бага байгаа юм.


Сургуулийн төрлөөр буюу ИДС болон МСҮТ төгсөгчдийн ангиллаар төгсөгчдийн ажлын байрны хэлбэрт томоохон ялгаа байгаа нь судалгааны үр дүнгээр тодорхойлогдлоо. ИДС төгсөгчдийн олонх буюу 93.7 хувь нь байнгын ажил эрхэлж байхад, МСҮТ төгсөгчдийн хувьд 72.1 хувь байгаа юм. Мэргэжлийн боловсролын салбар нь дээд боловсролын салбартай харьцуулахад түр болон улирлын чанартай ажлын байранд шаардлагатай ур чадвараар мэргэжилтэй ажилтныг илүү олноор бэлтгэдэг учраас МСҮТ төгсөгчдийн дунд түр болон улирлын чанартай ажил эрхлэгсдийн хувийн жин өндөр, тус бүр 14.0 хувь байгаа юм.

²Тайлбар: Төгсөгчдийн дунд нэг болон хэд хэдэн ажлын туршлагатай бүлгүүд тодорхойлогдож байгаа ба энэ хэсэгт "Төгсөгчдийн ажлын байр"-ны талаарх мэдээллийг хэрхэн ойлгон судалсан талаар авч үзье.

- Нэг ажлын туршлагатай, түүндээ одоо хүртэл ажиллаж байгаа бол тэрхүү ажлын байрны мэдээлэл
- Хэд, хэдэн ажил зэрэг хийж байгаа бол хамгийн олон цаг зарцуулж буй ажлын байрны мэдээлэл
- Одоогоор ажилгүй ч өмнө нь нэг ажил хийж байсан бол тэрхүү ажлын байрны мэдээлэл
- Одоогоор ажил хийгээгүй ч өмнө нь хэд хэдэн ажил хийж байсан бол хамгийн урт хугацааны турш ажилласан ажлын байрны мэдээлэл

Зураг 29. Ажлын туршлагатай төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: тоо



Ажиллаж буй ажлын байрны судалгааны хүрээнд ахуй нэгж байгууллагын ажилтны тоог тодруулсан ба ажилтны тоог багадаа 10 хүртэл ажилтантай, ихдээ 251-ээс дээш ажилтантай гэсэн байдлаар нийт 5 бүлэгт хуваан мэдээлэл цуглуулсан.

Нийт ажлын туршлагатай төгсөгчдийн 34.9 хувь буюу 11,9 мянга нь 11-50 ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж буй нь хамгийн олон байлаа. Мөн 24.8 хувь буюу 8,5 мянга нь 10 хүртэл ажилтантай, 16.1 хувь буюу 5,5 мянга нь 51-100 ажилтантай, 12.7 хувь буюу 4,3 мянга нь 251-аас дээш ажилтантай, үлдсэн 11.5 хувь буюу 3,9 мянга нь 101-250 ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажилласан тархалтыг харуулжээ.

Монгол улсын хэмжээнд 2012 оны сүүлчийн байдлаар нийт 51,9 мянган аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 90,9 хувь нь 19 хүртэлх ажилтантай гэсэн статистик байдаг³. Төгсөгчдийн 59.7 хувь нь 50-аас цөөн ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байгаа судалгааны дүнг статистикийн мэдээлэлтэй харьцуулан үзвэл шинээр төгсөгчид нь томоохон аж ахуйн нэгж байгууллагад олноор ажиллаж байгааг харуулж байна.


Төгссөн сургуулийн өмчийн хэлбэрээр аж ахуйн нэгж байгууллагын ажилтны тоог задлан үзье. Төгсөгчдийн хамгийн олноор ажиллаж буй байгууллага нь 11-50 ажилтантай ба, энэ үзүүлэлт нь төрийн өмчийн сургууль төгсөгчдийн тухайд 32.6 хувь, хувийн өмчийн сургууль төгсөгчдийн тухайд 39.0 хувь байгаа юм. 10 хүртэлх болон 11-50 ажилтантай байгууллагыг жижиг, дунд ААНБ гэж үзвэл хувийн өмчийн сургууль төгсөгчид нь төрийн өмчийнхнөөс илүү олноор энэ хэлбэрийн ААНБ-д ажиллаж, төрийн өмчийн сургууль төгсөгчид томоохон ААНБ-д илүү олноор ажилладаг болж таарч байна. Үүнийг 251-ээс дээш ажилтантай ААНБ-д ажиллаж буй төрийн өмчийн сургууль төгсөгчдийн хувийн жин 14.4 хувь, хувийн өмчийн сургууль төгсөгчдийнх 9.9 хувь гэсэн дүнгээр баталгаажуулж болох юм.

Сургуулийн төрлөөр ч мөн адил байгууллагын ажилтны тоо хэмжээнд тодорхой ялгаанууд байгаа нь судлагдсан. Өөрөөр хэлбэл ИДС төгсөгчдийн 56.6 хувь нь 50 хүртэлх ажилтантай жижиг, дунд аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байхад, МСҮТ төгсөгчдийн тухайд энэ тоо хэмжээ 66.2 хувь байгаа нь МСҮТ төгсөгчид жижиг, дунд ААНБ-д ажиллах нь илүү түгээмэл байгааг харуулж байна.

³ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2012, хуудас 428

Зураг 30. Ажлын туршлагатай төгсөгчдийн ААНБ-ын ажилтны тоо/сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: тоо



Төгссөн сургуулийн байршлаас хамаарч хөдөлмөр эрхлэлтийн байдалд ялгаа байдаг эсэхийг судлахын тулд судалгаанд хамрагдагсдаас сургуулийн хот, хөдөөгийн байршлын талаар асуусан. Нийт ажлын туршлагатай төгсөгчдийн 67.0 хувьтай тэнцэх 22,8 мянга нь Улаанбаатар хотод байршилтай МСҮТ болон ИДС төгсөж, үлдсэн 33.0 хувь буюу 11.2 мянга нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг сургуулиас хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэгджээ.

Улаанбаатарт байрлалтай төрийн өмчийн сургууль төгсөгчдийн 62.8 хувь нь ажлын дадал эзэмшсэн, ажлын туршлагатай байхад энэ үзүүлэлт орон нутгийн төрийн өмчийн сургууль төгсөгчдийн хувьд 9.0 мянга буюу 74.6 хувь байгаа нь орон нутгийн төрийн өмчийн сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт Улаанбаатартай харьцуулахад өндөр болохыг харуулж байна.

Төгсөгчдийн хувьд сургуулийн өмчийн хэлбэртэй харьцуулахад ИДС болон МСҮТ-ийн төрлөөр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн ялгаатай байдал хот, хөдөөд үйл ажиллагаа явуулж буйгаас төдийлөн хамааралтай биш болох нь тодорхойлогдсон. Өөрөөр хэлбэл Улаанбаатрын ИДС-ийн хөдөлмөр эрхлэлтийн хувь 69.1 хувь, МСҮТ-ийнх 62.7 хувь байж 6.4 хувийн зөрүү гарч

байгаа юм.

Ажлын байрны мэдээллийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн статусыг судлан үзсэн. Нийт ажлын туршлагатай төгсөгчдийн 95.6 хувь буюу 32,6 мянга нь цалин хөлстэй ажилтны статусаар хөдөлмөр эрхлэгч байсан бол, тэдний 87.2 хувь нь байнгын ажилтан, 7.7 хувь нь түр ажилтан, 5.1 хувь улирлын чанартай ажилтан гэсэн үр дүнг үзүүлжээ. Харин хөдөлмөр эрхлэлтийн бусад статусын хувьд ажил олгогчийн статусаар хөдөлмөр эрхлэгч 0.3 хувь буюу 0,1 мянга, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3.5 хувь буюу 1,1 мянга, өрхийн бизнест оролцогч 0.6 хувь буюу 0,2 мянга байна.


Сургуулийн өмчийн хэлбэрээр хөдөлмөр эрхлэлтийн статусын байдлыг дэлгэрүүлэн тайлбарлая. Энэхүү харьцуулалтаар төрийн болон хувийн өмчийн сургууль төгсөгчдийн олонх нь цалин хөлстэй, ялангуяа цалин хөлстэй байнгын ажилтны статустайгаар хөдөлмөр эрхэлдэг байна. Харин сургуулийн төрлөөр ИДС төгсөгчдийн 97.9 хувьтай тэнцэх 22,5 мянга нь цалин хөлстэй ажилтан, түүнд байнгын ажилтны эзлэх хувь өндөр /92.4%/ байгаа бол, МСҮТ-ийн тухайд цалин хөлстэй ажилтнууд 90.8 хувь, түүнд байнгын ажилтны хувийн жин ИДС-тэй харьцуулахад бага 64.7 хувь байгаа юм.

МСҮТ төгсөгчид нь хөдөлмөр эрхлэлтийн статусаар олон төрөл хэлбэртэй, цалин хөлстэй ажилтны бүтцэд түр болон улирлын чанартай ажилтны орон зай том, мөн

түүнчлэн хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувийн жин ИДС-тэй харьцуулахад өндөр 7.8 хувь байгаа зэргээр онцлог байлаа.

Зураг 31. Ажлын туршлагатай төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн статус /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/


Хэмжих нэгж: тоогоор



Цалин хөлстэй ажилтны хувьд хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа төгсөгч нь 80,1 хувь буюу 26,1 мянга, үлдсэн 19,8 хувь буюу 6,4 мянга хөдөлмөрийн гэрээгүйгээр ажилладаг талаар мэдээллэжээ. Ялангуяа төрийн өмчийн сургууль төгсөгчид илүү олноор буюу нийт цалинтай ажиллагсдын 22.5 хувьтай тэнцэх 4,7 мянга нь хөдөлмөрийн гэрээгүй байгуулалгүй ажиллаж байхад, хувийн өмчийн сургууль төгсөгчийн тухайд энэ тоо хэмжээ 14.8 хувь байж, 1,7 мянга нь хөдөлмөрийн гэрээ байгуулахгүй, ажлын байрны эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа

нь тогтоогдсон. Сургуулийн төрлөөр ИДС-ийн тухайд хөдөлмөрийн гэрээ байгуулан цалинтай ажиллагч нь 89.1 хувь буюу өндөр байхад МСҮТ-ийнх 60.4 хувь байгаа даруй 28.7 хувиар бага байгаа юм. МСҮТ төгсөгчдийн хувьд эзэмшсэн мэргэжлээс хамаарч албан бус хөдөлмөр эрхлэлт өндөртэй салбаруудад олноороо ажилладаг гэж үзэж болох талтай ба албан бус салбар нь бүртгэл мэдээллийн тогтолцооноос гадуур оршдог учраас хөдөлмөрийн харилцааг зохицуулах үндсэн баримт бичиг болох хөдөлмөрийн гэрээгүй ажиллагсад их байхаас өөр аргагүйд хүрч байна.

Зураг 32. Цалин хөлстэй ажилтны хөдөлмөрийн гэрээтэй, гэрээгүй байдлын бүтэц /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/




Ажлын туршлагатай төгсөгчдийн ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагын төрлийг судлан үзэхэд хамгийн олноороо ажилладаг нь дотоодын хөрөнгө оруулалттай компани /нийт ажлын туршлагатай төгсөгчдийн 45.9 хувь буюу 15,6 мянга/, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллага /25.8 хувь буюу 8,8 мянга/-иуд төдийгүй хувиараа хөдөлмөр эрхлэгчид харьяалан ажилладаг нь 11.1 хувь буюу 3,8 мянган төгсөгч байна. Харин тусгай сан, нийгэмлэг, олон улсын байгууллагад хамгийн цөөн тоогоор буюу 0.6 хувьтай тэнцэх 0,2 төгсөгч, төрийн өмчит үйлдвэрийн газарт 0,7 мянга буюу 2.1 хувь нь ажилладаг тооцоо гарчээ.

Тэгвэл ажиллаж буй байгууллагын төрөлд сургуулийн өмчийн хэлбэр болон төрлөөс хамаарсан ялгаатай тал байгаа эсэхийг одоо авч үзье. Нийт дүнд эзлэх хувиар хамгийн олноор ажилладаг байгууллагуудын³

төрөл сургуулийн өмч болон төрөл тус бүрээр ангилан тооцсон тооцоогоор мөн адил хамгийн өндөр хувийн жингүүдийг харуулжээ. Харин сургуулийн өмч болон төрлөөрх нийт дүнд эзлэх хэмжээгээр дотоодын хөрөнгө оруулалттай компанид ажиллагсдын хувийн жингээр төрийн өмчийн сургуультай харьцуулахад хувийн өмчийнхөн илүү өндөр, ИДС төгсөгчидтэй харьцуулахад МСҮТ төгсөгчдийн хувийн жин илүү өндөр байгаа ялгаатай тал ажиглагдаж байна. ИДС төгсөгчдийн тухайд төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллага дахь хөдөлмөр эрхлэлт өндөр 34.1 хувь буюу 7,8 мянга байгаа бол энэ дүн МСҮТ төгсөгчдийн тухайд 8.5 хувь буюу 0,9 мянга байгаа юм. МСҮТ төгсөгчид хувиараа хөдөлмөр эрхлэгчид харьяалан ажил эрхлэх үзэгдэл нэлээд түгээмэл байгаа ба 23.1 хувь нь энэ төрөлд харьяалагдаж байна.

Зураг 33. Ажлын туршлагатай төгсөгчдийн ажил олгогч байгууллагын хэлбэр

Хэмжих нэгж: тоогоор



Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, онцлогийг судлахдаа тэдний 7 хоногийн дундаж ажлын цаг, өдөр, нэмэлт ажлын цаг, сарын дундаж цалин орлого, ажлын болон амралтын өдөр гэх мэт ажлын байрны нөхцөлтэй холбоотой асуудлыг нарийвчлан авч үзсэн.

Ажлын туршлагатай нийт төгсөгчдөд тархаасан байдлаар долоо хоногийн дундаж ажлын өдөр нь 5.5, ажлын цаг нь 47.2, нэмэлт ажлын цаг нь 12.6 гэсэн эцсийн үр дүн гарсан. Ажлын цаг болон өдрийн хувьд энгийн ажлын цагийн горим, стандарттай харьцуулахад илүү өндөр гарч байгаа ба үүнд төгсөгчдийн дунд хувийн хэвшилд ажиллагсад олон, ялангуяа МСҮТ төгсөгчдөөс цөөнгүй хэсэг нь ажилладаг улирлын чанартай ажил болон түр ажлууд нь тодорхой хугацааны турш уртасгасан ажлын цаг, өдрийн горимоор ажилладаг зэрэг хүчин зүйлтэй холбоотой гэж үзэж болох юм.

Төрийн өмчийн сургууль төгсөгчдийн 7 хоногийн ажлын дундаж өдөр нь нийт дунджаас доогуур 5.4 өдөр байгаа бол, хувийн өмчийн сургууль төгсөгчид нийт дундажтай адил 5.5 өдөр байна. Харин 7 хоногийн ажлын дундаж цаг төрийн өмчийн сургууль төгсөгчдийн хувьд 46.3 цаг, хувийн өмчийн сургууль төгсөгчдийнх их 48.1 цаг байгаа хэдий ч нэмэлт ажлын цагаар төрийнхөн өндөр 13.9 цаг байгаа бол, хувийн өмчийн сургууль төгсөгчийн хувьд 11.3 цаг байгаа юм. Үүнээс үзэхэд төрийн өмчийн сургууль төгсөгчид хувийнхантай харьцуулахад илүү цагийн хөдөлмөр эрхлэлт өндөр байдаг нь ажиглагдлаа.

МСҮТ төгсөгчдийн ажлын цаг, өдөр нь ИДС төгсөгчидтэй харьцуулахад өндөр байна. Учир нь МСҮТ төгсөгчдийн 7 хоногийн ажлын дундаж өдөр 5.6 байхад, ИДС төгсөгчийнх 5.3 өдөр, 7 хоногийн дундаж ажлын цаг нь ИДС төгсөгчийнх 43.7 цаг, МСҮТ-ийнх 50.7 цаг байж, бүтэн 7 цагаар илүү байгаа юм. Нэмэлт цагийн

хувьд ч мөн адил МСҮТ төгсөгчийнх 13.7 цаг бол, ИДС-ийнх 11.5 цаг байгаа нь дээд боловсролтой ажилчидтай харьцуулахад мэргэжилтэй ажилчид илүү олон цагаар, ажлын ачаалалтай ажилладаг болохыг харуулж байна.

Долоо хоногийн дундаж ажил, амралтын өдрөөс гадна сарын дундаж ажил, амралтын өдрийг тодруулсан. Нийт төгсөгчдийн тухайд сарын дундаж ажлын өдөр нь 23.6 байгаа, амралтын өдөр нь 7.0 байгаа юм. Хөдөлмөр эрхлэлтийн долоо хоногийн дунджаар тодорхойлогдсон үр дүн зүй тогтлын хувьд сарын дундажтай адил байлаа. Өөрөөр хэлбэл ИДС төгсөгчдийн сарын дундаж ажлын өдөр МСҮТ-ийнхээс цөөн 23.3 өдөр байгаа юм. Харин дундаж амралтын өдөрт төгссөн сургуулийн төрлөөр ялгаатай байхгүй, нэгэн адил 7.0 өдөр байжээ. Сургуулийн өмчийн хэлбэрээр сарын дундаж амралт, ажлын өдөр нь 7 хоногийн ажил, амралтын өдөртэй адил төлөв байдал ажиглагдаж, төрийн өмчийн сургууль төгсөгчийн ажлын өдөр 23.7, амралтын өдөр 6.8 байж, харин хувийн өмчийн сургууль төгсөгчийн ажлын өдөр 23.3, амралтын өдөр 7.1 байна.

Сарын дундаж цалин, орлогын талаарх мэдээллийг тус судалгааны хүрээнд тодруулсан асуусан. Сургуулийн төрөл харгалзахгүйгээр нийт төгсөгчдийн сарын дундаж цалин, орлогын хэмжээ нь 505,2 мянган төгрөг байгаа улсын дунджаас 9.3 хувиар бага байна⁴. Төрийн өмчийн болон хувийн өмчийн сургууль төгсөгчийн тухайд цалин, орлогын дундаж ялгаа бага байгаа ч сургуулийн төрлөөр томоохон зөрүү байгаа нь судлагдсан. Өөрөөр хэлбэл ИДС төгсөгчийн сарын дундаж орлого, цалин нь 540,6 мянган төгрөг бол, МСҮТ төгсөгчийнх 469,8 мянга байгаа нь 13.1 хувиар бага байгаа гэсэн үг юм. Төгсөгчдийн ажлын байрны нөхцөлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгт 12-аар үзүүлье.

⁴ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2012, хуудас 121. Аж ахуйн нэгж байгууллагын сарын дундаж цалин улсын хэмжээнд 557.6 мянган төгрөг

Хүснэгт 12. Ажлын туршлагатай төгсөгчдийн ажлын байрны нөхцөл /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: тоогоор

Ангилал Ажлын өдөр		7 хоногийн дундаж			Сарын дундаж		
		Ажлын цаг	Нэмэлт ажлын цаг	Амралтын өдөр	Ажлын өдөр	Цалин, орлого / мян.төгрөг/	
Сургуулийн төрөл	ИДС төгсөгч	5.3	43.7	11.5	7.0	23.3	540,6
	МСҮТ төгсөгч	5.6	50.7	13.7	7.0	23.9	469,8
Сургуулийн өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	5.4	46.3	13.9	6.8	23.7	501,3
	Хувийн өмчийн	5.5	48.1	11.3	7.1	23.3	509,1
Дундаж /ИДС+МСҮТ/		5.5	47.2	12.6	7.0	23.6	505,2

Эрхэлж буй ажилдаа хэр сэтгэл ханамжтай байдгыг тодруулахын тулд ажлын байрны талаарх 10 үзүүлэлт тус бүрт 1 буюу огт хангалуун бусаас 5 буюу маш хангалуун хүртэлх 5 түвшнээр хэмжин үзсэн.

Нийт төгсөгчдийн бүлгээр ажлын байрны хамгийн сэтгэл ханамжтай байдаг үзүүлэлт нь ажил, амралтын цаг болон байгууллагын нэр хүнд ба энэ үзүүлэлтүүдэд өгсөн сэтгэл ханамжийн түвшин нь тус бүр 4.1 ба 4.0 буюу хангалуун байдаг гэж үнэлжээ. Түүний дараа үнэлгээний ердийн, түүнээс дээш түвшинд хангалуунаас доогуур үнэлэгдсэн хэд хэдэн үзүүлэлтүүд эрэмбэлэгдэж байгаа бол, эдгээр

нь ажлын байранд өсөн хөгжих боломж /3.5/, цалин /3.2/, ажлын орчин /3.1/ байна. Сэтгэл ханамжийн доогуур түвшинг илэрхийлж буй хангалуун бус болон огт хангалуун бусаар үнэлэгдсэн үзүүлэлтүүдээс байгууллагын хүний нөөцийн менежментийн асуудал онцгой анхаарал татаж байгаа юм. Өөрөөр хэлбэл нийт төгсөгчдийн үнэлгээгээр ажлын байрны талаар хамгийн сэтгэл ханамжгүй буюу 1.9 гэсэн түвшнээр хэмжигдсэн хүний нөөцийн менежментийн асуудал байлаа. Мөн хариуцаж буй ажил үүрэгтээ сэтгэл ханамжгүй байдал нийтлэг байгаа ба энэ үзүүлэлтэд өгсөн төгсөгчдийн үнэлгээ 2.0 байна.

Хүснэгт 13. Ажлын байрны сэтгэл ханамж /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: 1-5 хүртэлх үнэлгээний онооны дундаж

Ангилал		Цалин	Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа	Хариуцаж буй ажил	Ажлын орчин	Ажил, амралтын өдөр	Өсөн хөгжих боломж	Ажлын байрны хангамж	Хүний нөөцийн менежмент	Ажил мэргэжлийн үнэлэмж	Байгууллагын нэр хүнд
Сургуулийн төрөл	ИДС төгсөгч	3.2	2.3	1.9	3.0	4.2	3.6	2.7	1.9	2.6	4.1
	МСҮТ төгсөгч	3.2	2.3	2.0	3.3	4.0	3.3	2.4	2.0	3.2	4.0
Сургуулийн өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	3.3	2.4	1.9	3.0	4.2	3.6	2.6	1.9	2.8	4.1
	Хувийн өмчийн	3.1	2.3	2.1	3.2	4.0	3.4	2.5	2.0	3.1	3.9
Дундаж		3.2	2.3	2.0	3.1	4.1	3.5	2.6	1.9	2.9	4.0

Судалгаанд хамрагдагсдаас ажлын байран дээр гүйцэтгэдэг ажил үүрэг нь эзэмшсэн боловсролын түвшинтэй хэр нийцдэг талаар лавласан.

Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг нь эзэмшсэн боловсролын түвшинтэй тохиромжтой байдаг гэж төгсөгчдийн 67.2 хувь буюу 22,9 мянга нь үзсэн байгаагаас харахад боловсролоос хамаарсан ажил үүргийн үл нийцлийн хүндрэл бэрхшээл бага байдаг гэж үзэж болохоор байна. Мөн ажил үүрэг нь боловсролын түвшинтэй харьцуулахад доогуур гэж 16.9 хувь, хэт доогуур гэж 3.4 хувь нь хариулснаас үзэхэдэдгээр төгсөгчид нь эзэмшсэн боловсролын түвшнээс доогуур түвшний боловсрол шаардсан ажлын байранд ажиллагсад байж болох юм. Тухайлбал ИДС төгссөн ч мэргэжилтэй ажилтны боловсролд тохирсон ажлын байранд, эсвэл энгийн ажил мэргэжлүүдээр ажиллаж байж болох талтай. Харин нийт төгсөгчдийн 12.5 хувь буюу 4,2 мянга нь ажлын байрны ажил үүргийн шаардлага нь эзэмшсэн боловсролоос өндөр болон хэт өндөр байдаг талаар мэдээллэсэн нь эдгээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд боловсрол, мэдлэгээс хамаарсан бэрхшээлүүд тулгардаг байж болохыг үгүйсгэхийн аргагүй юм.

Төрийн өмчийн сургууль төгсөгчдийн ажил үүрэг болон боловсролын түвшний нийцлийн түвшин нь тохиромжтой 65.9 хувь буюу 14,4 мянга, доогуур, хэт доогуур гэж үнэлсэн үнэлгээний нийлбэр нь 22.7 хувь буюу 5,0 мянган төгсөгч, өндөр болон хэт өндөр гэсэн нь 11.3 хувь буюу 2,5 мянга байжээ. Хувийн өмчийн сургууль төгсөгчдийн 69.4 хувь нь тохиромжтой, 16.1 хувь нь доогуур, хэт дээгүүр, үлдсэн 14.4 хувь нь өндөр, хэт өндөр байдаг гэж ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг болон боловсролын түвшний нийцтэй байдлыг үзсэн байгаа юм. Үүнээс судалгаанд авч үзсэн энэ үзүүлэлтэд төгссөн сургуулийн өмчийн хэлбэрээс хамаарсан томоохон ялгаа байхгүй ч гэсэн хувийн өмчийн сургууль төгсөгчдийн үнэлгээ төрийнхөнтэй харьцуулахад бага зэрэг сөрөг байгааг харж болохоор байна.

ИДС болон МСҮТ-ийн төрлөөр ч мөн адил энэ хоёр салбараас нийлүүлэгдсэн ажиллах хүчинд ажлын байрны ажил үүргийн шаардлага болон боловсролын түвшин хоорондын үл нийцлээс хамаарсан хүндрэл бэрхшээл төдийлөн тохиолддоггүй гэж хариулсан байгаа юм. Тодруулбал МСҮТ төгсөгчидтэй харьцуулахад ИДС төгсөгчдийн ажил үүрэг нь боловсролын түвшнээс өндөр, хэт өндөр гэсэн үнэлгээ нь 1.9 хувиар их байгаа юм.

Хүснэгт 14. Боловсролын түвшин, ажил үүргийн нийцтэй байдал /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: хувиар

Ангилал	Хэт доогуур	Доогуур	Тохиромжтой	Өндөр	Хэт өндөр	
Бүгд	3.4	16.9	67.2	11.2	1.2	
Сургуулийн төрөл	ИДС төгсөгч	3.3	14.8	68.9	11.8	1.1
	МСҮТ төгсөгч	3.7	21.3	63.7	10.0	1.4
Сургуулийн өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	3.9	18.9	65.9	10.7	0.7
	Хувийн өмчийн	2.7	13.4	69.4	12.3	2.1

Ажлын байрны ажил үүргийн шаардлага нь эзэмшсэн ур чадвартай нь хэр нийцдэг талаар судлан үзсэн. Нийцлийн түвшинг хэт доогуураас эхлэн хэт өндөр хүртэл 5 түвшингээр хэмжсэн. Ур чадварын хомсдолоос үүдэлтэй хөдөлмөр эрхлэлтийн хүндрэл бэрхшээл төгсөгчдийн дунд бага байна. Учир нь судалгаанд хамрагдагсдын 74.2 хувь буюу 25,3 мянга нь ажил үүргийн шаардлага нь эзэмшсэн ур чадвартай тохиромжтой, 15.2 хувь буюу 5,2 мянга нь доогуур, 2.3 хувь буюу 0,8 мянга нь хэт доогуур байдаг гэж хариулсан байгаа юм.

Хувийн өмчийн сургууль төгсөгчидтэй харьцуулахад төрийнхөн ажил үүрэг, ур чадварын зөрүүгээс хамаарсан ажлын байрны хүндрэлтэй бага тулгардаг. Өөрөөр

хэлбэл төрийнхны хувьд гүйцэтгэж буй ажил үүрэг эзэмшсэн ур чадвартай тохиромжтой, доогуур болон хэт доогуур гэсэн үнэлгээний нийлбэр 93.3 хувь байхад, хувийнхны тухайд 88.9 хувь байжээ.

Харин ажил үүрэг, ур чадварын нийцтэй байдлыг үнэлүүлсэн үнэлгээгээр ИДС төгсөгчдөөс МСҮТ-ийнхэн илүү өөдрөг байгаа юм. Өөрөөр хэлбэл МСҮТ төгсөгчдийн 69.6 хувь ур чадвар, ажил үүрэг нь хоорондоо тохиромжтой гэж үнэлснээс гадна, ажил үүргийн шаардлага ур чадвараас доогуур нь 19.7 хувь, хэт доогуур нь 2.8 байна. ИДС төгсөгчдийн 76.5 хувь нь тохиромжтой, 13.0 хувь нь ажил үүргийн шаардлага доогуур, 2.1 хувь нь хэт доогуур гэж хариулжээ.

Хүснэгт 15. Ажил үүргийн шаардлага, ур чадварын нийцтэй байдал /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/
Хэмжих нэгж: хувиар

Ангилал		Хэт доогуур	Доогуур	Тохиромжтой	Өндөр	Хэт өндөр
Бүгд		2.5	16.4	73.0	7.3	0.9
Сургуулийн төрөл	ИДС төгсөгч	2.1	13.0	76.5	7.9	0.5
	МСҮТ төгсөгч	2.8	19.7	69.6	6.7	1.2
Сургуулийн өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	2.2	17.5	73.5	6.2	0.5
	Хувийн өмчийн	2.5	11.0	75.5	9.9	1.1

Дээр судалгаанд хамрагдагсад ажил үүрэг, ур чадварын хооронд зөрүү бага, төгсөгчид ур чадварын хомсдлын бэрхшээлтэй бага тулгардаг талаар мэдээллэсэн. Тэгвэл одоо ажлын байранд тулгардаг ур чадварын хомсдлын талаарх судалгааны үр дүнг тайлбарлая.

Хамгийн нийтлэг тохиолдож болох ур чадварын хомсдолын хэлбэрүүдээс 2 хүртэлх хариултыг сонгох нөхцөлтэйгээр мэдээлэл цуглуулсан. Хамгийн олноор нэрлэсэн ур чадварын хомсдолын хэлбэр нь багаар ажиллах чадвар ба нийт судалгаанд хамрагдагсдын 14.7 хувь нь энэ хэлбэрийг сонгосон байна. Мөн мэдээллийн технологийг ашиглах, эзэмших

ур чадвар /14.3%/, харилцааны ур чадвар, соёлч боловсон байдал /14.1%/, гадаад хэлний мэдлэг /13.4%/-ийг хамгий олноор нэрлэжээ. Харин ур чадварын төрлүүдээс хамгийн бага байгаа нь олон улсын мэдлэг /2.5%/ болон төрөлх хэлээр зөв бичих, ярих ур чадвар /5.4%/ байна.

Ур чадварын хомсдолыг цаг хугацаанаас хамааралтай хомсдол, өөрчлөлт шинэчлэлтээс хамааралтай хомсдол гэж 2 хувааж авч үзэж болох юм. Өөрөөр хэлбэл ур чадварын хомсдол орших, эсвэл бага байх тохиолдол нь хэд хэдэн нөхцөлд үүснэ. Тухайлбал ур чадварын хомсдол бага байх нөхцөл нь ажлын байранд төдийлөн шаардагдахгүй ур чадварын

хувьд хүндрэл бэрхшээл гарахгүй, нөгөө талаас тухайн ажлын байранд хамгийн ихээр шаардагддаг ур чадвар нь тодорхой хугацааны дараа дадал болон өөрчлөгдөж бэрхшээл биш болдог. Тэгвэл ур чадварын хомсдол орших нөхцөл нь ажлын байранд хамгийн ихээр шаардагддаг ур чадварын хувьд хугацааны эхэнд хомсдол болох, нөгөө талаас тасралтгүй шаардагддаг, байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг ажил үүрэгт хомсдол оршоор байх талтай. Тиймээс шинээр сургууль төгсөгчдийн ур чадварын хомсдолын шалтгаан, мэргэжил, боловсролын төрлөөрх ялгаатай тал, хэлбэр, үргэлжлэх хугацаа, хугацааны мөчлөг, шийдвэрлэх хичээл зүтгэл зэрэг олон талаас нь дэлгэрүүлэн судлах нь чухал юм.

Төгссөн сургуулийн өмчийн хэлбэрийн ангиллаар ажлын байранд хамгийн ихээр дутагддаг ур чадварууд нийт төгсөгчдийн үр дүнтэй адил байна. Төрийн өмчийн болон хувийн өмчийн сургууль төгсөгчдөд аль алинд нь хамгийн нийтлэг тохиолддог ур чадварын хомсдол нь харилцааны ур чадвар, соёлч боловсон байдал /төрийнхний 15.3%, хувийнхны 12.0%/, багаар ажиллах чадвар /төрийнхний 14.2%, хувийнхны 15.7%/,

мэдээллийн технологийн ашиглах, эзэмших чадвар /төрийнхний 13.6%, хувийнхны 15.6%/ болон гадаад хэлний мэдлэг /төрийнхний 12.5%, хувийнхны 15.2%/ зэрэг байдаг нь судлагдсан.

ИДС болон МСҮТ төгсөгчийн төрлөөр ч хамгийн их бэрхшээл болдог ур чадварын хомсдол нь нийт төгсөгчдийн нэрлэсэнтэй нэгэн адил байгаа юм. Өөрөөр хэлбэл ИДС төгсөгчдийн хувьд гадаад хэлний мэдлэг, ур чадвар хамгийн тулгамдсан шинжтэй байгаа бол, багаар ажиллах чадвар, мэдээллийн технологийн мэдлэг, харилцаан ур чадварууд нь ажил эрхлэхэд тулгардаг нийтлэг хүндрэл бэрхшээлүүд байдаг гэжээ. Харин МСҮТ төгсөгчдийн тухайд ИДС төгсөгчидтэй харьцуулахад ажлын байранд олон төрлийн ур чадварын хомсдолууд тулгардаг байна. Тухайлбал тэд багаар ажиллах чадварыг хамгийн түгээмэл тохиолддог ур чадварын хомсдол гэж үзсэн ба, түүний дараа мэдээллийн технологийн мэдлэг, харилцааны ур чадвар, тасралтгүй суралцах ур чадвар, асуудлыг шийдвэрлэх, зөв зохистой хандлагыг тодорхойлох ур чадваруудыг хамгийн олноор нэрлэжээ.

Хүснэгт 16. Ажлын байран дахь ур чадварын хомсдол /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: хувиар

Ангилал	Төрөлх хэлээр зөв бичих, ярих ур чадвар	Гадаад хэлний мэдлэг	Математик сэтгэлгээ, тооцоолон бодох чадвар	Шинжлэх ухаан, технологийн мэдлэг	Тасралтгүй суралцах чадвар	Харилцааны ур чадвар, соёлч боловсон зан байдал	Асуудлыг шийдвэрлэх, зөв зохистой хандлагыг тодорхойлох	Мэдээллийн технологийг ашиглах, эзэмших	Багаар ажиллах чадвар	Олон улсын мэдлэг	Бусад	
Сургуулийн төрөл	ИДС төгсөгч	5.6	15.3	8.8	6.1	7.1	14.5	8.4	14.3	13.7	3.1	3.1
	МСҮТ төгсөгч	4.8	9.2	4.9	8.6	11.2	13.3	10.0	14.1	16.9	2.2	4.4
Өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	6.0	12.5	7.6	6.8	9.9	15.3	8.8	13.6	14.2	3.0	2.2
	Хувийн өмчийн	4.2	15.2	7.5	7.0	5.4	12.0	8.9	15.6	15.7	2.4	6.0
Бүгд		5.4	13.4	7.6	6.9	8.4	14.1	8.9	14.3	14.7	2.8	3.5

Бид өмнө нь төгсөгчдийн хувьд ажлын байранд хамгийн ихээр тулгардаг хүндрэл бэрхшээлийн нэг болох ур чадварын хомсдолын талаарх судалгааны үр дүнг танилцуулсан бол одоо ажлын байрны бэрхшээлийг илүү дэлгэрүүлэн судалсан судалгааны үр дүнг авч үзье. Төгсөгчид нь шинэ залуу, туршлагагүй ажиллах хүч учраас энэхүү хүндрэл бэрхшээлийг судалгаанд “Ажлын байранд дасан зохицоход тулгардаг бэрхшээл” гэсэн асуултаар дамжуулан мэдээлэл цуглуулсан ба хамгийн түгээмэл тохиолддог 3 хүртэл тооны бэрхшээлийг сонгох боломжтой байсан.

Судалгаанд оролцогчдын 6.2 хувь нь л ажлын байранд дасан зохицоход ямар нэг хүндрэл бэрхшээл тулгардаггүй гэж хариулсан байгаагаас үзэхэд үлдсэн 93.8 хувь нь ямар бэрхшээлүүдтэй тулгардаг талаарх мэдээллийг өгчээ. Нийт төгсөгчдийн 39.0 хувь нь нэрлэсэн бэрхшээлүүдээс өөр буюу “бусад бэрхшээл” гэсэн хувилбарыг сонгосон байгаа нь хамгийн их байгаа юм. Харин төгсөгчдийн 16.7 хувь нь хамт ажиллагсад, удирдлагатай харилцах харилцааны бэрхшээлийг сонгож, 11.8 хувь нь ажлын байран дахь ялгаварлан гадуурхал/хүйс, боловсрол, хот-хөдөөгийн ялгаварлал г.м/, 10.7 хувь нь ажлын хэв маягт дасан зохицох байдал зэргийг хамгийн ихээр тулгардаг бэрхшээлүүд гэсэн байна.

Сургууль төгсөгчид буюу шинэ ажиллах хүчний тухайд цалин, ажлын цаг, хангамжийн хүсч байсан түвшин болон ажил-гэр хоорондын зай зэрэг нь ажлын байранд дасан зохицоход төдийлөн бэрхшээл болдоггүй гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд залуучуудын ажлын гарааны нэн тэргүүний зорилго, бас сэтгэл ханамж нь эдгээр асуудлууд биш, харин нэн тэргүүнд ажлын туршлага хуримтлуулах,

хөдөлмөрийн дадал эзэмших, баг хамт олноор ажиллах чадварыг төлөвшүүлэхэд суралцах зэрэг хүчин зүйлүүд байдаг гэж үзэж болох юм.

Төрийн өмчийн сургууль төгсөгчдийн 6.8 хувь нь ажлын байранд дасан зохицоход бэрхшээлтэй тулгарч байгаагүй гэж хариулсан байхад хувийн өмчийн сургууль төгсөгчдийн тухайд энэ үзүүлэлт 5.0 хувь байгаагаас хувийнхан төрийнхөнтэй харьцуулахад илүү олноор бэрхшээлтэй тулгардаг болохыг харуулжээ. Сургуулийн өмчийн хэлбэр тус бүрээр задлан үзэхэд хамгийн нийтлэг тохиолддог бэрхшээлүүд нь нийт төгсөгчдийн дүнгээр тооцоологдсон бэрхшээлүүдтэй адил байгаа хэдий ч тухайн бэрхшээлтэй тулгарсан төгсөгчийн нийт төгсөгчдөд эзлэх хувийн жингүүдэд зөрүүтэй талууд байна. Сургуулийн төрлөөр авч үзвэл ИДС төгсөгчидтэй харьцуулахад МСҮТ төгсөгчид илүү их бэрхшээлтэй тулгардаг байх юм. Ямар нэг хүндрэл бэрхшээл байгаагүй гэж хариулсан хэсгийн эзлэх хувийн жин ИДС-ийн тухайд 6.9 хувь бол МСҮТ-ийн тухайд 4.7 хувь байна. ИДС төгсөгчдөд хамгийн ихээр тохиолддог бэрхшээл нь нийт төгсөгчдийн 18.4 хувийг хамарсан хамт ажиллагсад, удирдлагатай харилцах харилцааны бэрхшээл ба, хүйс, боловсрол, хот-хөдөөгийн ялгаварлан гадуурхлын бэрхшээлийг 12.2 хувь, ажилд тохирох байдал болон сонирхлын үл нийцэлтэй холбоотой бэрхшээлийг 10.2 хувь нь нэрлэжээ. Харин МСҮТ төгсөгчдөд хамгийн нийтлэг тохиолддог бэрхшээл нь ажлын хэв маягт дасан зохицох байдаг гэж нийт төгсөгчдийн 18.9 хувь хариулжээ. Мөн 13.3 хувь хамт олон, удирдлагатай харилцах харилцааг, 11.1 хувь нь ажлын байран дахь ялгаварлан гадуурхлын бэрхшээлийг сонгожээ.

Хүснэгт 17. Ажлын байранд дасан зохицоход тулгардаг бэрхшээл/сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: хувиар

Ангилал	Ажлын хэв маягт дасах байдал	Хамт ажилласад, удирдлагатай харилцах харилцаа	Ажилд тохирох байдал болон сонирхлын үл нийцэл	Хүсч байсан түвшин/цалин, ажлын цаг, хангамж г.м/	Ялгаварлан гадуурхал /хүйс, боловсрол, хот-хөдөө г.м/	Ажил гэр хоорондын зай	Бусад	Хүндрэл бэрхшээл байгаагүй	
Сургуулийн төрөл	ИДС төгсөгч	6.5	18.4	10.2	3.3	12.2	3.9	38.5	6.9
	МСҮТ төгсөгч	18.9	13.3	6.7	3.5	11.1	1.9	39.9	4.7
Өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	10.7	17.2	9.3	4.1	12.2	4.2	35.6	6.8
	Хувийн өмчийн	10.6	15.7	8.5	2.1	11.1	1.2	45.7	5.0
Бүгд		10.7	16.7	9.0	3.4	11.8	3.2	39.0	6.2

Төгсөгчдөөс ажиллаж буй ажлын байранд орж ажиллахад хамгийн ихээр тус болсон хүчин зүйл юу байсан болохыг тодруулсан. Энэ асуудлыг судлахдаа ажлын байранд ороход нөлөөлөх 11 хүчин зүйлээс 3 хүртэл хүчин зүйлийг сонгуулахаас гадна, аль нь ч нөлөөлөөгүй гэсэн хэлбэрийг оруулсан.

Ажлын байранд амжилттай ороход хамгийн ихээр нөлөөлдөг хүчин зүйл нь эзэмшсэн мэргэжил байдаг байна. Нийт төгсөгчдийн 19.0 хувь эзэмшсэн мэргэжил нь тухайн ажилд ороход хамгийн ихээр нөлөөлсөн гэж хариулсан бол, түүний дараа хувийн зан чанар/өөрийгөө илэрхийлэх, таниулах чадвар/ гэж 12.8 хувь, ажилд орох ярилцлагын ур чадвар гэж 12.4 хувь, төгссөн сургууль нөлөөлсөн гэж 11.9 хувь, сурлагын дүн, голч оноо гэж 10.6 хувь нь тус тус хариулж, ажилд ороход нөлөөлдөг зэрэг хүчин зүйлсийн эрэмбийг үзүүлжээ. Харин ажилд ороход нөлөөлөх нөлөөллөөр

гадаадад суралцсан, ажилласан туршлага⁵ болон хөдөлмөрт бэлтгэсэн байдал, ажилд төвлөрөх чадвар болон гадаад хэлний мэдлэг зэрэг хүчин зүйл хамгийн сул байдаг гэсэн судалгааны үр дүн гарчээ.

Сургуулийн өмчийн хэлбэрээр авч үзвэл төрийн өмчийн сургууль төгсөгчдийн 18.8 хувь нь эзэмшсэн мэргэжил ажилд ороход хамгийн ихээр нөлөөлдөг гэж хариулсан төдийгүй, хувийн зан чанар/12.7%/ , төгссөн сургууль /12.3%/ болон сурлагын дүн, голч оноо /11.0%/ -ны үүрэг ажлын байртай болоход их байсан гэжээ. Тэгвэл хувийн өмчийн сургууль төгсөгчдийн тухайд мөн адил эзэмшсэн мэргэжлийн үүргийг өндөрт үнэлсэн ба нийт төгсөгчдийн 19.2 хувь, мөн

⁵Судалгааны объект нь дотоодын ИДС болон МСҮТ төгсөгчид учраас гадаадад суралцсан, ажилласан ажлын туршлага хамгийн сул хүчин зүйлээр судлагдсан байж болох талтай. Судалгаанд 2011 онд төгссөн сургуулиас өмнөх сургууль, өмнөх шатны сургууль нь гадаадад суралцсан сургууль , мөн гадаадад ажиллаж байгаад дотоодод сургуульд суралцсан тохиолдлуудыг "гадаадад төгссөн байдал"-аар илэрхийлэгдэнэ гэж авч үзсэн.

түүнчлэн ярилцлагын ур чадвар /16.9%/ болон хувийн зан чанар /13.0%/-ын үүрэг хамгийн их байсан нь тодорхойлогдсон.

Эзэмшсэн мэргэжил нь ажилд ороход их нөлөөтэй байдаг талаар ИДС төгсөгчид тайлбарласан ба тэдний 20.1 хувь нь мэргэжлийн үүргийг үнэлсэн байна. Мөн төгссөн сургууль, ярилцлагын ур чадварууд нь ажилд ороход бусад хүчин зүйлсээс илүү үүрэг гүйцэтгэсэн гэсэн байна.

МСҮТ төгсөгчдийн хувьд ялгаатай тал харагдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл ИДС төгсөгчид 3-4 тооны хүчин зүйлд өндөр ач холбогдол өгсөн бол, МСҮТ төгсөгчдийн үнэлгээ олон тооны хүчин зүйлд тархсан

байдалтай байна. Тэдний хувьд хувийн зан чанарын ажилд ороход үзүүлсэн үүргийг бусдаас илүүтэйгээр үнэлсэн ба нийт МСҮТ төгсөгчдийн 18.7 хувь нь энэ хүчин зүйлийг нэрлэсэн. Мөн 15.3 хувь нь эзэмшсэн мэргэжил, 10.1 хувь нь мэргэжил ур чадварын үнэмлэх, 10.0 хувь нь ярилцлагын ур чадвар, 8.3 хувь нь хөдөлмөрт бэлтгэсэн байдал, 7.2 хувь нь гадаад дүр төрх бие бялдрын хөгжил, 7.2 хувь нь төвлөрч ажиллах чадвар ажилд ороход нөлөөлсөн гэсэн байгаа юм. Энэ нь мэргэжилтэй ажиллах хүчний хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн хэмжээ, ажил мэргэжлийн онцлог зэрэг нөхцөл байдалтай холбоотой.

Хүснэгт 18. Ажлын байранд ороход нөлөөлдөг хүчин зүйл/сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: хувиар

Ангилал		Сурлагын дүн, голч оноо	Эзэмшсэн мэргэжил	Гадаад хэлний мэдлэг	Мэргэжил-ур чадварын үнэмлэх	Төгссөн сургууль	Ярилцлагын ур чадвар	Хөдөлмөрт бэлтгэсэн байдал	Хувийн зан чанар	Төвлөрч ажиллах чадвар	Гадаад ажиллаж, суралцсан туршлага	Гадаад дүр төрх-бие бялдрын хөгжил	Аль нь ч нөлөөлөөгүй
Сургуулийн төрөл	ИДС төгсөгч	11.9	20.1	7.1	6.1	13.5	13.1	3.4	11.0	4.9	1.2	5.5	2.3
	МСҮТ төгсөгч	6.3	15.3	1.7	10.1	6.6	10.0	8.3	18.7	7.2	2.3	7.2	6.3
Өмчийн хэлбэр	Төрийн өмчийн	11.0	18.8	6.0	7.0	12.3	9.8	4.8	12.7	6.4	1.5	5.9	3.8
	Хувийн өмчийн	10.0	19.2	5.4	7.0	11.1	16.9	4.2	13.0	3.6	1.4	5.9	2.3
Бүгд		10.6	19.0	5.8	7.0	11.9	12.4	4.6	12.8	5.4	1.5	5.9	3.2

Ажлын байрны төлөв байдал, онцлогийн талаарх судалгааны мэдээллийн чухал ач холбогдолтой мэдээллийн нэг нь төгсөгчдийн ажиллаж буй салбарыг эзэмшсэн мэргэжилтэй харьцуулан үзсэн үр дүн юм. Өөрөөр хэлбэл энэ үр дүнгээс

төгсөгчдийн хамгийн олноор болон цөөн тоогоор ажиллаж буй эдийн засгийн үйл ажиллагааны салбарууд, мэргэжлийн чиглэл тус бүрээр ажиллаж буй салбаруудын тархалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл гэсэн үг юм.

Төгсөгчдөөс ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэлийн талаар тодруулан, мэдээллийг эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 21 салбарт тархаан боловсруулсан⁶. Судалгааны үр дүнгээр 2011 онд ИДС болон МСҮТ төгсөгчид нь цөөн хэдэн тооны салбаруудад тархан ажилладаг дүр зураг гарчээ. Ялангуяа шинэ ажиллах хүчнийг хамгийн олноор шингээсэн эдийн засгийн үйл ажиллагааны салбарууд нь Монгол улсын стратегийн ач холбогдолтой, хөдөлмөрийн нөөцийн эрэлт хэрэгцээ ихтэй салбарууд байгаа юм. Тухайлбал уул уурхайн салбарт онцгой их хэмжээний нийлүүлэлт хийгдэж нийт төгсөгчдийн 68.4 хувь буюу 23,3 мянга нь харьяалагдаж байна. Мөн ажиллах хүчний багтаамж томтой хөдөө аж ахуйн салбарт 10.8 хувь буюу 3,7 мянган төгсөгч, боловсролын салбарт 5.2 хувь 1,8 мянга, худалдааны салбарт 3.0 хувь буюу 1,1 мянга, төрийн удирдлага батлан хамгаалах салбарт 2.9 хувьтай тэнцэх 0,9 мянга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 2.2 хувь буюу 0,8 мянган төгсөгч тус тус тархан ажиллаж буй нь эдгээр салбарууд нь 2011 онд дээд боловсролын болон мэргэжлийн боловсролын төгсөгчдийн хамгийн олноор ажиллаж буй салбарууд болохыг тодорхойлж байна.

Өөр нэг сонирхолтой үр дүн нь төгсөгчид усан хангамж, үл хөдлөх хөрөнгө, олон улсын байгууллагын үйл ажиллагааны салбарт ажил эрхэлдэггүй явдал юм. Өөрөөр хэлбэл 2011 онд сургууль төсөгчдийн ажлын туршлага нь эдгээр 3 салбараас гадуур байгаа нь тодорхойлогдсон. Сургалтын байгууллагын төрлөөр ИДС болон МСҮТ төгсөгчдийн олноор ажиллаж буй салбарууд ижил төсөөтэй байна. Гэхдээ ИДС төгсөгчид харьцангуй олон тооны салбаруудад тархан ажилладаг байхад МСҮТ төгсөгчид цөөн хэдэн салбарт тархан ажилладаг болох нь тогтоогдсон. Уул уурхайн салбарт ажиллаж буй ИДС-ийн төгсөгчдийн хувийн жин 71.3 хувь бол, МСҮТ-ийнх 62.2 хувь байж

⁶Ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллага нь эдийн засгийн хэд хэдэн салбарт үйл ажиллагаа явуулдаг бол тухайн төгсөгчийн эрхэлж буй ажил үүргийн хамаарах салбарыг сонгох зарчмаар мэдээллийг цуглуулсан.

9.1 хувиар бага, хөдөө аж ахуйн салбарт ажилладаг ИДС төгсөгчдийн хувийн жин 7.6 хувь бол, МСҮТ төгсөгчийнх 17.6 хувь байж 10 хувиар их байгаа ялгаатай талууд ажиглагдлаа.

Мөн ИДС төгсөгчдийн хамгийн олноор ажиллаж буй нь боловсрол 7.1 хувь, төрийн удирдлага-батлан хамгаалах 3.6 хувь, худалдаа 2.3 хувь, боловсруулах үйлдвэрлэл 2.1 хувь, санхүү даатгал 1.7 хувь зэрэг салбарууд байгаа юм. Харин МСҮТ төгсөгчдийн хувьд 21 салбараас 13 салбарт нь тархан ажилладаг ба уул уурхай, хөдөө аж ахуйн салбаруудаас гадна 4.4 хувь нь худалдаа, 3.5 хувь нь барилга, 2.8 хувь нь зочид буудал-зоогийн газар, 2.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад бусад салбартай харьцуулахад илүү олноор ажилладаг байна.

Нийтажлын туршлагатай төгсөгчдөд эзлэх хувиар хамгийн өндөр жинг үзүүлж байгаа зарим мэргэжлийн чиглэлүүдээс салбараарх хөдөлмөр эрхлэлтийг харьцуулан авч үзье. Тухайлбал ИДС төгсөгчдийн дунд бизнес удирдлагын чиглэлийн мэргэжилтэй ажлын туршлагатай төгсөгчийн тоо 5,3 мянга байгаагаас 80.0 хувь буюу 4,3 мянга нь уул уурхайн салбарт, худалдаа болон санхүүгийн салбарт тус бүр 5.0 хувь буюу 0,3 мянган төгсөгч ажилладаг. Багш боловсрол судлалын мэргэжилтэй, ажлын туршлагатай төгсөгчийн нийт дүнд эзлэх хувийн жин 12.3 хувь буюу 4,2 мянга ба, тэдний 51.3 хувьтай тэнцэх 2,1 мянга нь уул уурхайн салбарт, 33.3 хувь буюу 1,4 мянга нь боловсролын салбарт, 10.3 хувь буюу 0,4 мянга нь хөдөө аж ахуйн салбарт тус тус ажилладаг болохыг тодорхойллоо.

Тэгвэл МСҮТ-ийн ажлын туршлагатай төгсөгчдийн эзлэх хувийн жин өндөр байгаа барилга, автозам, барилгын материал үйлдвэрлэлийн мэргэжилтэй ажиллах хүчнүүдийн 68.2 хувь буюу 2,6 мянга нь уул уурхайн салбарт, 12.2 хувь буюу 0,5 мянга нь хөдөө аж ахуйн салбарт, 7.5 хувь 0,3 мянга нь барилгын салбарт ажилладаг байна. Мөн түүнчлэн аж үйлдвэрийн салбарын

мэргэжилтэй ажилтнуудын 51.6 хувьтай тэнцэх 1,1 мянга нь уул уурхайн салбарт, 38.7 хувь буюу 0,9 мянга нь хөдөө аж ахуйн салбарт тус тус ажилладаг тооцоо гарсан. Төгсөгчдийн мэргэжлийн чиглэл болон ажилладаг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын тархалтын харьцуулсан дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтын хүснэгт 3-аас харах боломжтой.

Төгсөгчид эзэмшсэн мэргэжлээрээ ажилладаг байдлыг тандах зорилгоор ажил үүрэг болон мэргэжлийн нийцтэй байдлын талаар асуусан. Огт тохирдоггүйгээс эхлэн маш сайн тохирдог хүртэл буюу 1-5 хүртэлх үнэлгээний хэрэгслэлээр дамжуулан мэдээллийг цуглуулсан.

Нийт судалгаанд оролцогчдын 36.7 хувь 12,5 мянга нь тохирдог, маш сайн тохирдог гэж 17.0 хувь буюу 5,8 мянга нь хариулсанаас үзэхэд нийт ажлын туршлагатай төгсөгчдийн 51.3 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажилладаг гэж үзэж болохоор байна. Мөн төгсөгчдийн 21.9 хувь 7,5 мянга нь эзэмшсэн мэргэжил, ажил үүргийн нийцэл дунд зэрэг гэсэн байгаа ба үндсэн мэргэжлээр биш ч гэсэн мэргэжлийн чиглэл нь адил, ойролцоо мэргэжлээр

ажилладаг болохыг харуулж байна. Харин эзэмшсэн мэргэжил нь ажил үүрэгтэй тохирдоггүй гэж судалгаанд хамрагдагсдын 10.7 хувь буюу 3,7 мянга, огт тохирдоггүй гэж 13.6 хувь буюу 4,7 мянга нь хариулсан байгаагаас үзэхэд нийт төгсөгчдийн 25 хувиас дээш хэсэг нь мэргэжлийн бус ажил хийдэг болохыг тодорхойлж байна.

Ялангуяа мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт нь МСҮТ төгсөгчдийн дунд илүү түгээмэл байна. Өөрөөр хэлбэл МСҮТ төгсөгчдийн 43.2 хувь нь ажил үүрэг болон мэргэжил нь тохирдог, маш сайн тохирдог, эсрэгээрээ 36.1 хувь нь тохирдоггүй болон огт тохирдоггүй гэж хариулсан байгаа юм. Ажил үүрэг, мэргэжлийн нийцтэй байдлын түвшин дунд зэрэг байдаг гэсэн мэдээллийг нийт ажлын туршлагатай МСҮТ төгсөгчдийн 20.8 хувь нь өгсөн байгаа юм.

Тэгвэл энэ дүн ИДС төгсөгчдийн хувьд дараах байдалтай байна. Ажил үүрэг, мэргэжлийн нийцтэй байдлын түвшингийн талаар төгсөгчдийн 58.8 хувь нь тохирдог, маш сайн тохирдог, 18.7 хувь нь тохирдоггүй, огт тохирдоггүй, үлдсэн 22.4 хувь нь дунд зэрэг байдаг гэсэн хариултыг өгчээ.

Хүснэгт 19. Ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдал /сургуулийн төрлөөр/

Хэмжин нэгж /тоо, хувь/

Сургуулийн төрөл	Огт тохирдоггүй		Тохирдоггүй		Дунд зэрэг		Тохирдог		Маш сайн тохирдог	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ИДС төгсөгч	1760	7.7	2546	11.1	5153	22.4	9284	40.4	4240	18.5
МСҮТ төгсөгч	2884	26.1	1104	10.0	2297	20.8	3219	29.1	1555	14.1
Бүгд	4645	13.6	3650	10.7	7450	21.9	12503	36.7	5796	17.0

Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг нь эзэмшсэн мэргэжилтэй нийцтэй байдаг гэсэн үнэлгээг олноор өгсөн, мөн нийцгүй байдаг гэж үнэлсэн мэргэжлийн чиглэлүүдийн талаар авч үзье.

Ажил үүрэг болон мэргэжлийн нийцтэй түвшнээр тохирдог, маш сайн тохирдог гэсэн ИДС төгсөгчдийн мэргэжлийн чиглэл

тус бүрийн үнэлгээний дундаж нь 58.5 хувь байгаа нь ИДС төгсөгчдийн талаас илүү хувь нь эзэмшсэн мэргэжлийн дагуу ажиллаж байгааг харуулж байна. Тухайн мэргэжлийн чиглэлийн нийт төгсөгчдийн 70-аас дээш хувь нь мэргэжлийн дагуу ажиллаж байгаа буюу өндөр тоо хэмжээг үзүүлж буй мэргэжлийн чиглэлүүдээс дурьдвал урлаг

/75.7%/, мэдээлэл-сэтгүүл зүй /тус бүр 75.6%/, компьютер болон анагаах ухаан /тус бүр 74.4%/, биологи /72.2%/, барилга архитектур /72.1%/ байна. Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг нь эзэмшсэн мэргэжилтэй тохирдоггүй, огт тохирдоггүй гэсэн үнэлгээний мэргэжлийн чиглэл бүрээрх нийлбэрийн дундаж нь 20.5 хувь байгаа юм. Ялангуяа дээд боловсролын салбараас нийлүүлдэг нийгмийн халамж-хангамж /42.9%/, тээвэр /36.1%/, хууль эрхзүй /32.3%/, хүмүүнлэгийн ухаан /32.1%/, байгаль хамгаалал /31.6%/-ын мэргэжилтнүүд нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт өндөртэй болохыг судалгааны үр дүн харууллаа.

Харин МСҮТ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт дэх ажил үүрэг болон мэргэжлийн нийцтэй байдлын “тохиромжтой болон маш сайн тохиромжтой” гэсэн мэргэжлийн чиглэл тус бүрийн үнэлгээний дундаж нь 38.2 хувь байгаа нь МСҮТ төгсөгчдийн дунд мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт өндөр байгааг үзүүлж байна. Бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад мэргэжлийн дагуух хөдөлмөр эрхлэлт өндөр байгаа мэргэжлийн чиглэлүүд нь соёл урлаг /100.0%/, барилга, авто зам, барилгын материал үйлдвэрлэл /49.5%/ болон аж үйлдвэр /48.4%/ байгаа юм. Ажил үүрэг болон эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдлын түвшин доогуур буюу тохирдоггүй, огт тохирдоггүй гэсэн мэргэжлийн чиглэл тус бүрийн үнэлгээний дундаж нь 44.7 хувь байна. Ялангуяа мэргэжлийн боловсролын салбараас бэлтгэдэг холбоо /100.0%/, ойн аж ахуй, мод боловсруулалт /66.7%/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл /55.6%/ болон байгаль хамгаалал-аялал жуулчлал /50.0%/-ын мэргэжилтэй ажилтнууд мэргэжлийн бус ажил эрхлэх байдал нийтлэг байгаа нь нийлүүлэлтэд анхаарах шаардлагатайг анхааруулжээ. Ажлын туршлагатай төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн ажил үүрэг болон мэргэжлийн чиглэлийн нийцтэй байдлын талаарх илүү нарийвчилсан мэдээллийг хавсралтын хүснэгт 4-өөс харах боломжтой.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, онцлогийн талаарх судлагдахууны хүрээнд авч үзсэн өөр нэг асуудал бол төгсөгчдийн ажлын байрны ажил мэргэжлийн байдал юм. Тус судлагдахууныг ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүргийн мэдээллээр авсан ба ажил үүргийн мэдээллийг YAMAT-08⁷ дэх ажил мэргэжлийн нэр болон кодоод хөрвүүлэн боловсруулсан.

Энэхүү төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн ажил мэргэжлийн талаарх мэдээллийг YAMAT-08 дахь ажил мэргэжлийн дэд бүлгийн түвшинд нэгтгэн авч үзсэн. Өөрөөр хэлбэл ажил мэргэжлийн мэдээллийг нийт 43 бүлэгт тархаан тайлбарлах юм. Төгсөгчид олон ажил мэргэжлүүдээр тархан ажиллаж байгаа ч тодорхой хэдэн ажил мэргэжлүүдэд төвлөрөл их байгаа нь тогтоогдсон. Тухайлбал багшлах мэргэжилтнээр нийт ажлын туршлагатай төгсөгчдийн 12.3 хувь нь ажиллаж байгаа нь хамгийн өндөр жинг харуулжээ. Бизнес захиргааны мэргэжилтнээр 10.5 хувь, хууль, нийгэм соёлын мэргэжилтнээр 7.9 хувь, борлуулалтын ажилтнаар 6.8 хувь, шинжлэх ухаан-инженерийн мэргэжилтнээр 6.5 хувь, хувийн үйлчилгээний ажилтнаар 5.3 хувь, хэрэглэгчдэд үйлчлэх ажилтнаар 4.8 хувь, барилга түүнтэй холбогдох ажил мэргэжлийн ажилтнаар /цахилгаанчаас бусад/ 4.3 хувь, эрүүл мэндийн мэргэжилтэн болон хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч, тэдгээрт холбогдох мэргэжлийн ажилтнаар тус бүр 3.5 хувь нь тус тус ажилладаг нь судлагдаж, эдгээр ажил мэргэжлүүд нь төгсөгчдийн хамгийн олноор тархан ажилладаг ажил мэргэжлүүдээр тодорхойлогдсон.

Зэвсэгт хүчний ажил мэргэжил, зах зээлд чиглэсэн хөдөө аж ахуйн ажил мэргэжил, бусад худалдаа үйлчилгээний ажил мэргэжил болон энгийн ажил мэргэжлүүдээрх төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцоо байхгүй болон маш бага байна.

⁷YAMAT-08 нь “Монгол Улсын Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал ба Тодорхойлолт”-ын товчлол.

ИДС төгсөгчдийн хамгийн олноор ажилладаг ажил мэргэжлүүд нь “Мэргэжилтэн” гэсэн ажил мэргэжлийн үндсэн бүлэгт харьяалагдаж байгаа юм. Багшлах мэргэжилтнээр 17.4 хувь /нийт ажлын туршлагатай ИДС төгсөгчид эзлэх хувь/, бизнес захиргааны мэргэжилтнээр 15.4 хувь, хууль, нийгэм-соёлын мэргэжилтнээр 10.6 хувь, шинжлэх ухаан-инженерийн мэргэжилтнээр 8.3 хувь, хэрэглэгчдэд үйлчлэх ажилтнаар 6.9 хувь, эрүүл мэндийн мэргэжилтнээр 5.1 хувь нь ажилладагаас харахад эдгээр нь ИДС төгсөгчдийн хамгийн олноор ажилладаг ажил мэргэжлүүд болж байна.

МСҮТ төгсөгчдийн тухайд “Худалдаа, үйлчилгээний ажилтан” болон “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан” гэсэн ажил мэргэжлийн үндсэн бүлгүүдэд хамаарах ажил мэргэжлүүдээр илүү олноор тархан

ажилладаг нь тогтоогдсон. Ажлын туршлагатай МСҮТ төгсөгчдийн 14.3 хувь нь хувийн үйлчилгээний ажилтан, 12.8 хувь нь барилга, түүнтэй холбогдох ажил мэргэжлийн ажилтан/цахилгаанчаас бусад/, 10.8 хувь нь борлуулалтын ажилтан, хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч, тэдгээрт холбогдох мэргэжлийн ажилтан, 6.5 хувь нь металл, машин механизм, холбогдох ажил мэргэжлийн ажилтан болон 6.2 хувь нь жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторчийн ажил үүрэг гүйцэтгэж байгаа ба эдгээр нь мэргэжлийн боловсролын салбарын нийлүүлэлтийг шингээдэг гол талбарууд болохыг үзүүлж байна.

Төгсөгчдийн эзэмшсэн мэргэжил болон ажилладаг ажил мэргэжлийн байдлыг харьцуулсан дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтын хүснэгт 5-аас тодруулан харна уу.

БҮЛЭГ 6. ТӨГСӨГЧИЙН АЖИЛ ХАЙХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨГӨӨ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны үр дүнгийн тайлангийн зургаадугаар бүлэг болох “Төгсөгчдийн ажил хайх үйл явц”-д нийт төгсөгчдийн ажил хайх, ажлаа солих төлөвлөгөөг тодруулахаас гадна, ажил хайх шалтгаан, ажил хайж буй


хэлбэр, хугацаа, хичээл зүтгэл болон ойрын нэг жилийн хугацаанд хийхээр төлөвлөж буй эдийн засгийн үйл ажиллагааны оролцооны төлөвлөгөөний талаарх судалгааны үр дүнг толилуулна.

6.1 АЖИЛ ХАЙХ ЗОРИЛГО, ШАЛТГААН

2011 онд дээд боловсролын болон мэргэжлийн сургалтын байгууллагыг 45,0 мянга оюутан төгссөнөөс судалгааны мэдээлэл цуглуулах хугацааны өмнөх долоо хоногт 63.4 хувь буюу 28,6 мянга нь ажил хийсэн, үлдсэн 36.6 хувь буюу 16,5 мянга ажил хийгээгүй байсан талаарх мэдээллийг тайлангийн хоёрдугаар бүлгийн “Төгсөгчдийн эдийн засгийн идэвхи”-ийн хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

Нийт төгсөгчдөөс ажил хийдэг, ажил хийдэггүй байдлаас үл хамаарч ажил хайж байгаа талаар тодруулан үзэхэд 17.5 хувь буюу 7,9 мянга нь ажил хайж, үлдсэн 82.5 хувь буюу 37,2 мянга нь ажил хайгаагүй гэж мэдээллэсэн. Ажил хайж буй төгсөгчдийн 65,5 хувь нь ИДС төгсөгчид, 34,5 хувь нь МСҮТ төгсөгчид байгаа юм.

Зураг 34. Төгсөгчдийн ажил хайх байдал /сургуулийн төрлөөр/



Сургуулийн төрлөөр ажил хайгчдын тоо хэмжээг ангилан үзвэл, ИДС төгссөн 27,0 мянган төгсөгчийн 19,2 хувь нь, МСҮТ төгссөн 18,1 мянган төгсөгчийн 15,1 хувь нь ажил хайж байгаа нь тогтоогдсон. Ажил хайж буй төгсөгчдөөс ажил хайж буй

зорилгыг нь тодруулахад 64.0 хувь буюу 5,1 мянга нь ажил хийх, 36.0 хувь буюу 2,8 мянга нь ажлаа солих зорилготой гэсэн байна. ИДС төгссөн ажил хайгчдын 57.6 хувь буюу 3,0 мянга нь ажил хийх, үлдсэн 42.4 хувь буюу 2,2 мянга нь одоо хийж буй


ажлаа солих зорилгоор ажил хайж байгаа болох нь тодорхойлогдсон.

Дээрх үзүүлэлтийг МСҮТ төгссөн ажил хайгчдаар авч үзвэл 76.2 хувь буюу 2,1

мянга нь ажил хийх, үлдсэн 23.8 хувь буюу 0,7 мянга нь ажлаа солихын тулд ажил хайж байгаа гэж хариулжээ.

Зураг 35. Төгсөгчдийн ажил хайж буй зорилго /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: тоо



Мэргэжлийн чиглэл тус бүрээр нийт төгсөгчдөд эзлэх хувийн жинг тооцон үзэж, ажил хайгчид хамгийн олонтой мэргэжлийн чиглэлүүдийг тодорхойлсон.

Дээд боловсролын салбарын тухайд хамгийн олон төгсөгч ажил хайж байгаа мэргэжлийн чиглэлүүд нь хууль, эрхзүйн мэргэжилтэн /тухайн мэргэжлийн нийт төгсөгчдөд ажил хайгч төгсөгчийн эзлэх

хувийн жин 33,3 хувь/, нийгмийн халамж, хангамжийн мэргэжилтэн /31.8 хувь/, биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээний мэргэжилтэн /26.7 хувь/, мал эмнэлгийн мэргэжилтэн /24.4 хувь/, бизнес удирдлага, үйлдвэрлэлийн технологи болон мэдээлэл-сэтгүүл зүйн мэргэжилтэн /тус бүр 22.2 хувь/, хөдөө аж ахуй, ойн, загасны ажуурын мэргэжилтэн /20.5 хувь/ зэрэг байна.

Мэргэжлийн боловсролын салбарын мэргэжлийн чиглэлийн төрлөөр ажил хайгч төгсөгчид олон байгаа нь холбоо болон ойн аж ахуй, мод боловсруулалт /тухайн мэргэжлийн нийт төгсөгчдөд ажил хайгч төгсөгчийн эзлэх хувийн жин тус бүр 33.3 хувь/ болон соёл урлаг /20.0 хувь/-ын

салбарын мэргэжилтэй ажилтнууд болох нь тогтоогдсон.

Нийт ажил хайгчдаас ажил хайж буй зорилгын төрлөөр төгсөгчдийн мэргэжлийн чиглэлийг тархаасан үр дүнгээс сонирхол татсан хэсгүүдээс дурьдая.

Тухайлбал ИДС-аас бэлтгэдэг мэргэжлийн чиглэлүүдээс ажлаа солих зорилгоор ажил хайж буй төгсөгч хамгийн олон байгаа нь урлаг, байгаль хамгаалал /тухайн мэргэжлийн чиглэлийн ажил хайж буй нийт төгсөгчдөд ажлаа солих зорилгоор ажил хайгчийн эзлэх хувийн жин тус бүр 100,0 хувь/, физик, хими, геологи, газарзүй /87.5 хувь/, цэрэг, цагдаа, аюулгүй байдал /80.0 хувь/-ын мэргэжилтнүүд байна.

Хүснэгт 20. ИДС төгсөгчдийн ажил хайх үйл явцын мэдээлэл

Хэмжих нэгж: тоо, хувиар

Мэргэжлийн чиглэл	Нийт төгсөгчийн тоо	Ажил хайж буй төгсөгчийн тоо	Нийт төгсөгчид эзлэх хувь (%)	Ажил хайж буй зорилго /тоо/		Ажил хайж буй төгсөгчид эзлэх хувь (%)	
				Ажил хийх	Ажлаа солих	Ажил хийх	Ажлаа солих
Багш боловсрол судлал	4925	749	15.2	428	321	57.1	42.9
Урлаг	580	64	11.1	64	0	100.0	0.0
Хүмүүнлэгийн ухаан	1985	361	18.2	271	90	75.0	25.0
Нийгэм, эдийн засаг	2725	474	17.4	178	296	37.5	62.5
Мэдээлэл, сэтгүүл зүй	558	124	22.2	62	62	50.0	50.0
Бизнес удирдлага	6012	1336	22.2	802	534	60.0	40.0
Хууль эрхзүй	1873	624	33.3	375	250	60.0	40.0
Биологи	713	127	17.8	95	32	75.0	25.0
Физик, хими, геологи, газарзүй	209	37	17.8	33	5	87.5	12.5
Математик статистик	222	39	17.8	10	30	25.0	75.0
Компьютер	783	139	17.8	70	70	50.0	50.0
Бүх төрлийн инженер	1341	238	17.8	119	119	50.0	50.0
Үйлдвэрлэлийн технологи	578	128	22.2	64	64	50.0	50.0
Барилга, архитектур	258	11	4.4	0	11	0.0	100
ХАА, ой, загасны аж ахуй	549	112	20.5	75	37	66.7	33.3
Мал эмнэлэг	136	33	24.4	18	15	54.5	45.5
Анагаах ухаан	1664	185	11.1	74	111	40.0	60.0
Нийгмийн халамж, хангамж	371	118	31.8	67	51	57.1	42.9
Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ	649	173	26.7	101	72	58.3	41.7
Тэвэр болон бусад	46	8	17.5	2	6	28.6	71.4
Байгаль хамгаалал	84	10	11.4	10	0	100.0	0.0
Цэрэг, цагдаа, аюулгүй байдал	764	87	11.4	69	17	80.0	20.0
Бүгд /нийт тоо, дүнд эзлэх хувь/	27025	5180	19.2	2986	2193	57.6	42.4

МСҮТ-ийн хувьд ажлаа солих зорилгоор ажил хайж буй төгсөгчийн тоо олонтой нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон соёл урлаг /тухайн мэргэжлийн чиглэлийн ажил хайж буй нийт төгсөгчдөд ажлаа солих

зорилгоор ажил хайгчийн эзлэх хувийн жин тус бүр 100.0 хувь/, барилга, авто зам, барилгын материал үйлдвэрлэл /86.2 хувь/, аж үйлдвэр /82.4 хувь/-ийн салбаруудын мэргэжилтэй ажилтнууд байна.

Хүснэгт 21. МСҮТ төгсөгчдийн ажил хайх үйл явц

Хэмжих нэгж: тоо, хувиар

Мэргэжлийн салбар	Нийт төгсөгчийн тоо	Ажил хайж буй төгсөгчийн тоо	Нийт төгсөгчид эзлэх хувь (%)	Ажил хайж буй зорилго /тоо/		Ажил хайж буй төгсөгчид эзлэх хувь (%)	
				Ажил хийх	Ажлаа солих	Ажил хийх	Ажлаа солих
Барилга, автозам, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар	5984	1021	17.1	880	141	86.2	13.8
ХАА-н үйлдвэрлэлийн салбар	1045	149	14.3	149	0	100.0	0.0
Ойн аж ахуй, мод боловсруулалтын салбар	218	73	33.3	36	36	50.0	50.0
Байгаль хамгаалагч, аялал жуулчлалын салбар	247	0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тээврийн салбар	2001	264	13.2	151	113	57.1	42.9
Холбооны салбар	163	54	33.3	0	54	0.0	100.0
Мэдээллийн технологийн салбар	1424	158	11.1	79	79	50.0	50.0
Аж үйлдвэрийн салбар	3611	602	16.7	496	106	82.4	17.6
Геологи, уул уурхайн салбар	1297	157	12.1	89	67	57.1	42.9
Захиргааны үйлчилгээний ажилтан	1875	211	11.3	158	53	75.0	25.0
Соёл урлагын салбар	184	37	20.0	37	0	100.0	0.0
Бүгд /нийт тоо, дүнд эзлэх хувь/	18049	2726	15.1	2076	650	76.2	23.8

Ажил эрхэлж буй төгсөгчид нь цаашид тухайн ажлын байранд хэр тогтвортой ажиллах төлөвтэй байгааг тандах зорилгоор ажил хайгчдаас ажлаа солихын тулд ажил хайж байгаа хэсгийг ялган авч үзсэн. Энэхүү ажлаа солих зорилгоор ажил хайгч төгсөгчдийг тогтвортой хөдөлмөр эрхлэхэд нь хүндрэл бэрхшээл тулгарсан, эмзэг хөдөлмөр эрхлэлтэд байгаа, цаашлаад ажилгүйдэлд өртөх эрсдэл байгаа бүлэг гэж үзэж болох юм.

Ажлаа солих шалтгааныг судлахдаа нийт 12 хүчин зүйлээс ажлаа солиход хамгийн

хүчтэй нөлөөлж 1 хүчин зүйлийг сонгуулах замаар мэдээллийг цуглуулсан. Судалгааны үр дүнгээс төгсөгчдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтэд хүчтэй нөлөө үзүүлдэг цөөн хэдэн тооны хүчин зүйлүүд байгааг олж мэдсэн.


Төгсөгчдийн ажлаа солиход хүргэдэг ажлын байрны таагүй хүчин зүйл нь цалин хөлс байна. Өөрөөр хэлбэл ажлаа солих зорилгоор ажил хайж буй нийт төгсөгчийн 52.9 хувь буюу 1,5 мянга нь “ажлын хөлс бага” гэсэн шалтгааны улмаас ажил хайж байгаа нь тодорхойлогдсон. Цалин хөлстэй холбоотой хүндрэл бэрхшээлтэй

харьцуулахад хувийн жингээр бага ч гэсэн хувиараа бизнес эрхлэхийн тулд нийт ажлаа солих хүсэлтэй төгсөгчдийн 9.8 хувь, эрхэлж буй ажил нь ирээдүйгүйн улмаас 9.4 хувь, ажлаасаа үр дүн, сэтгэл ханамж авдаггүйн

улмаас 4.0 хувь нь болон ажил үүрэг нь эзэмшсэн мэргэжилтэй нийцдэггүй учраас 3.4 хувь нь ажлын байраа өөрчлөхөөр төлөвлөсөн байна.

Зураг 36. Ажил хайгчийн ажлаа солих шалтгаан /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: тоо



6.2 АЖИЛ ХАЙХ ХЭЛБЭР, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ


Шинээр сургууль төгсөгчид нь ажлын байр хайхдаа ихэвчлэн ямар хэлбэрийг сонгон ашигладаг болохыг тандахын тулд ажил хайгч төгсөгчдөөс энэ талаар лавлан асуусан. Өнөөгийн манай улсын хөдөлмөрийн зах зээлд ажил хайх хамгийн түгээмэл хэлбэрүүдийг судалгааны асуулгад тэмдэглэн нэг хэлбэрийг сонгуулсан.

Ажил хайж буй төгсөгчдийн 17.5 хувь буюу 1,4 мянга нь хөдөлмөр зуучлалын байгууллагаар үйлчлүүлэх, 30.0 хувь болох

2,4 мянга нь зарын дагуу, 27.5 хувь буюу 2,2 мянга нь танил талаараа дамжуулан, 2.4 хувь 0.2 мянга нь бусад хэлбэрийг ашиглан ажил хайдаг нь судлагдсан. Харин нийт ажил хайгч төгсөгчдийн 22.6 хувь буюу 1,8 мянга нь ажил хайх талаар бодож байгаа ч ямар нэг алхам хийгээгүй гэж хариулжээ. Үүнээс үзэхэд ажил хайгчид хөдөлмөр зуучлалын байгууллагаар үйлчлүүлэхээс илүүтэй мэдээллийн хэрэгслүүдээрх зарын дагуу, эсвэл танил талаараа дамжуулан ажил хайдаг явдал түгээмэл байна.

Зураг 37. Ажил хайх хэлбэр /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: тоо




ИДС төгсөгч ажил хайгчдын 34.5 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслэлд гарсан зарын дагуу, 28.6 хувь нь танил талаараа дамжуулан ажил хайж буйгаас үзэхэд эдгээр хэлбэрүүд нь ИДС төгсөгчдийн ажил хайхдаа хамгийн өргөнөөр хэрэглэдэг хэрэгслэлүүд болохыг харуулж байгаа юм. Харин МСҮТ төгсөгч ажил хайгчдын 29.4 хувь нь ажил хайх талаар бодож байгаа ч ямар нэг алхам хийгээгүй байгаа гэснээс үзэхэд ажил хайх хэлбэр, арга замын талаар мэдээлэл бага, идэвх зүтгэл сул байгааг илтгэж байна. МСҮТ төгсөгчдийн харьцангуй түгээмэл хэрэглэдэг ажил хайдаг хэрэгслэлүүд нь танил тал /25.5 хувь/ болон хэвлэл мэдээллийн зарууд /21.6 хувь/ болох нь тогтоогдсон.

Нийт төгсөгчдөөс ойрын нэг жилийн хугацаанд ажил амьдралын ямар төлөвлөгөөтэй байгаа талаар сонирхсон. Тэдний ойрын нэг жилийн төлөвлөгөөг хэд хэдэн үзүүлэлтүүдээр дамжуулан тодруулсан ба нийт төгсөгчдийн 37.4 хувьтай тэнцэх 16,8 мянга нь одоо хийж буй ажлаа үргэлжлүүлэн хийнэ гэж хариулсан байгаа нь хамгийн өндөр хувийн жинг үзүүлжээ. Мөн түүнчлэн 11.1 хувь буюу 5,0 мянга нь ажлаа солих, 9.8 хувь 4,4 мянга дотоодын сургуульд элсэн суралцах, 7.8 хувь буюу 3,5 мянга нь хувиараа бизнес эрхлэх төлөвлөгөөтэй байгаа талаар мэдээллэсэн.

Зураг 38. Төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө

Хэмжих нэгж: тоо



Сургуулийн төрлөөр ойрын нэг жилийн хугацааны төлөвлөгөөнд ялгаа байгаа эсэхийг нарийвчлан авч үзье.


ИДС төгсөгчдийн тухайд нийт төгсөгчдийн 47,5 хувь нь одоо хийж буй ажлаа үргэлжлүүлэн хийх, 11.3 хувь нь ажлаа солих, 7.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэх төлөвлөгөөтэй гэсэн байгаагаас үзэхэд

ИДС төгсөгчдийн 60 орчим хувь нь ойрын нэг жилийн хугацаанд ажил хөдөлмөртэй холбоотой төлөвлөлтийг хийсэн байгааг харж болж байна. Нийт МСҮТ төгсөгчдийн 22.2 хувь нь ажлаа үргэлжлүүлэн хийх, 10.7 хувь нь ажлаа өөрчлөх, 8.8 хувь нь хувиараа бизнес эрхлэхээр төлөвлөсөн байгаа нь МСҮТ төгсөгчдийн эдийн засгийн үйл

ажиллагааны оролцоо ИДС төгсөгчидтэй харьцуулахад сул байгааг харуулжээ. Дараах зураг 39-өөр ИДС болон МСҮТ төгсөгчдийн

ойрын нэг жилийн төлөвлөгөөг харьцуулан харуулья.

Зураг 39. Төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө /сургуулийн төрлөөр/




Төгсөгчдийн ажил хайхад зарцуулж буй хичээл зүтгэлийг тодруулан судалсан. Судалгааны асуулгад ажил хайхын тулд хийж буй хичээл зүтгэлийн 11 төрөл тус бүрээрх “тийм, үгүй” гэсэн сонголтоос тохирох хэлбэрийг сонгуулсан.

Нийт ажил хайж буй төгсөгчдийн 29,1 хувь нь хөдөлмөр зуучлалын байгууллагаар үйлчлүүлэх, 21,5 хувь нь мэргэжил

дээшлүүлэх, 20,3 хувь нь гадаад хэлний сургалтанд хамрагдан хэлний мэдлэгээ дээшлүүлж, 20,9 хувь нь гадаад төрхөндөө анхаарах, 48,2 хувь нь танил талаараа дамжуулан ажил хайх, 48,1 хувь нь зарын вэб сайтаас мэдээлэл авах хэлбэрүүдээр ажил хайх хичээл зүтгэлүүд гаргасан байгаа нь хамгийн түгээмэл хэрэгслэлүүд болж байна.

Зураг 40. Ажил хайх хичээл, зүтгэлийн төрөл

Хэмжих нэгж: хувь



Судалгааны төгсгөлд төрөөс хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийн цар хүрээний, оролцооны төлөв байдлыг тандсан үр дүнг танилцуулья. Уг үйл ажиллагааны хүрээнд хэрэгждэг дараах үйлчилгээ, арга хэмжээний талаар төгсөгчдөд мэдээлэл байдаг эсэхийг тандсан. Үүнд:

Хөдөлмөрийн бирж, хувийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаагаар дамжуулж, ажилд зуулчлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх

Ажил, амьдралын гараа төгсөгчдийн хөдөлмөрийн яармаг, бусад яармаг

www.labornet.mn, www.hudulmur.mn, www.mergejil.mn вэб сайтын ажиллагаа

Аймаг, дүүрэг, хороо дээр байршуулсан ажлын байрны зар хайх, мэдээллийн цахим самбар

Хөдөлмөр эрхэлтийг дэмжих, сангийн хөрөнгөөр мэргэжлийн үнэмлэх олгох түр сургалт зохион байгуулах

Жижиг дунд үйлдвэрийн сангийн хөрөнгөөр хөнгөлөлтэй зээл олгон аж ахуй, бизнесийг дэмжих

Оюу толгой төслийн хөрөнгө оруулалтаар мэргэжилтэй ажилтан бэлтгэх

хөтөлбөр

Ерөнхийдөө төгсөгчид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар хангалтгүй мэдээлэлтэй байдаг нь харагдсан. Нийт төгсөгчдийн 15.9 хувь нь л эдгээр үйл ажиллагааны талаар мэддэг гэж хариулсан байгаа юм. Тухайлбал хөдөлмөрийн бирж, хувийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаагаар дамжуулж, ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний талаар нийт төгсөгчдийн 22,1 хувь, ажил, амьдралын гараа төгсөгчдийн хөдөлмөрийн яармаг, бусад яармагийн үйл ажиллагааны талаар 10,7 хувь, www.labornet.mn, www.hudulmur.mn, www.mergejil.mn вэб сайтын ажиллагааны талаар 16,8 хувь, аймаг, дүүрэг, хороо дээр байршуулсан ажлын байрны зар хайх, мэдээллийн цахим самбарын үйл ажиллагааны талаар 18.0 хувь, хөдөлмөр эрхэлтийг дэмжих, сангийн хөрөнгөөр мэргэжлийн үнэмлэх олгох түр сургалт зохион байгуулах үйл ажиллагааны талаар 13,4 хувь, жижиг дунд үйлдвэрийн сангийн хөрөнгөөр хөнгөлөлтэй зээл олгон аж ахуй, бизнесийг дэмжих үйл ажиллагааны талаар 11,8 хувь, оюу толгой төслийн хөрөнгө оруулалтаар мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар 18,2 хувь нь л тус тус мэддэг гэж хариулжээ.

Хүснэгт 22. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Хэмжих нэгж: Тоо, хувь

Үйл ажиллагааны нэр	ИДС төгсөгч		МСУТ		Нийт төгсөгчдөд эзлэх хувь (%)	ИДС төгсөгчийн эзлэх хувь (%)	МСУТ төгсөгчийн эзлэх хувь (%)
	Мэднэ	Мэдэхгүй	Мэднэ	Мэдэхгүй			
Хөдөлмөрийн бирж, хувийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаагаар дамжуулж, ажилд зуулчлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	6753	20272	3228	14821	22.1	25.0	17.9
Ажил, амьдралын гараа төгсөгчдийн хөдөлмөрийн яармаг, бусад яармаг	3670	23354	1168	16881	10.7	13.6	6.5
www.labor.net.mn, www.hudulmur.mn, www.mergejil.mn вэб сайтын ажиллагаа	5612	21413	1954	16095	16.8	20.8	10.8
Аймаг, дүүрэг, хороо дээр байршуулсан ажлын байрны зар хайх, мэдээллийн Цахим самбар	5292	21733	2833	15216	18.0	19.6	15.7
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сангийн хөрөнгөөр мэргэжлийн үнэмлэх олгох түр сургалт зохион байгуулах	3635	23390	2393	15657	13.4	13.5	13.3
Жижиг дунд үйлдвэрийн сангийн хөрөнгөөр хөнгөлөлтэй эзэл олгон аж ахуй, бизнесийг дэмжих	3892	23133	1430	16619	11.8	14.4	7.9
Оюу толгой төслийн хөрөнгө оруулалтаар мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр	5450	21575	2763	15286	18.2	20.2	15.3

ДУГНЭЛТ

Энэхүү “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” нь дээд боловсрол болон мэргэжлийн боловсролын салбараас нийлүүлж буй мэргэжилтэй шинэ ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг иж бүрнээр судалсан анхны судалгаа болж байгаа юм. Судалгааны судлагдахуун нь маш өргөн хүрээг хамарсан ба төгсөгчдийн сургуульд суралцах болон төгссөнөөс хойшхи хугацааны эдийн засгийн үйл ажиллагааны оролцооны төлөв байдлыг олон үзүүлэлтээр нарийвчлан хэмжиж, хөдөлмөрийн зах зээлд шинэ ажиллах хүчнүүд хэрхэн суурьшиж, бас шилжин байршиж буй бодит байдлыг тодорхойлохыг зорьсон.

2011 оны төгсөгчдийн олонх нь 25-аас доош настай залуус байгаа ба, энэ насны залуусын олонх нь гэр бүлийн амьдрал зохиогоогүй, эцэг, эхтэйгээ хамт амьдардаг, тусдаа амьдарсан ч дэмжлэг туслалцаа, ялангуяа хүнсний хэрэглээний дэмжлэг түлхүү авдаг, хараат бус бие даасан амьдралтай болж чадаагүй байдаг байна. Залуусын амьдралын энэхүү нөхцөл байдлыг тэдний тогтвортой ажилтай, орлоготой болж чадаагүй, цалин хөлс нь амьдрал ахуйд нь бүрэн хүрэлцээтэй байж чаддаггүй зэрэг нийгмийн амьдралтай нь холбон үзэхээс гадна монголчуудын амьдралын хэв маяг, гэр бүлийн уламжлалт харилцаатай холбон ойлгож болох юм.

Ажиллах хүчний эрэлтийн судалгаагаар өндөр ур чадвартай, нарийн мэргэжил шаардсан, дээд боловсролтой ажиллах хүчнээс илүүтэйгээр дунд түвшний ур чадвартай, мэргэжилтэй ажилтан, туслах ажилтан илүү хэрэгцээтэй байхаар тооцоологддог. Гэтэл бодит байдал дээр мэргэжлийн боловсролын бүтээгдэхүүнээс илүү дээд боловсролын бүтээгдэхүүний хөдөлмөрийн зах зээл дэх борлуулалт илүү сайн байгааг судалгаа харуулсан. Төгссөнөөс хойшхи 15 сарын дараах байдлаар нийт төгсөгчдийн 2/3 орчим нь ажил эрхэлж байгаа

ба, хөдөлмөр эрхлэлтийн цар хүрээгээр МСҮТ төгсөгчдөөс ИДС төгсөгчийнх илүү том зах зээлийг эзэлж байна. Үүний шалтгааныг ажил олгогчдын хандлага, өөрөөр хэлбэл төдийлөн шаардлагагүй ажлын байранд дээд боловсролтой ажилтан авахыг илүүд үздэг, зарим ур чадварууд түр болон улирлын чанартай ажлын байртай холбоотой байдаг зэрэг хүчин зүйлстэй холбон үзэж болно. МСҮТ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт эд хүндрэл бэрхшээл байгаа учраас тэд үргэлжлүүлэн суралцах, ялангуяа их, дээд сургуульд бакалавраар суралцах явдал цөөнгүй байгааг судалгааны үр дүн харуулсан.

Ажил хийгээгүй буюу эдийн засгийн идэвхигүй байдлын шалтгаан олон төрөл байгаа хэдий ч төгсөгчид, өргөн хүрээнд залуус нь нөхөн үржихүйн насны онцлогоос хамаарч хүүхэд төрүүлэх, асрах, залуу хүний хувьд сурч мэдэх, өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлийн үүднээс дахин суралцах зэрэг хувийн шалтгааны улмаас эдийн засгийн үйл ажиллагааны оролцоонд тодорхой хязгаарлалтууд үүсдэг болохыг салгаж ойлгох нь зүйтэй юм.

Бусад мэргэжлийн чиглэлүүдтэй харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийн хамралтаар хамгийн бага тоо хэмжээг харуулж байгаа тодорхой мэргэжлүүдийн нийлүүлэлтэд анхаарал хандуулах, бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийг тусгайлсан хөтөлбөр, арга хэмжээгээр дамжуулан хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх зэрэг хөдөлмөрийн болон боловсролын салбарын хамтын ажиллагааны хэлбэрүүдийг хөгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал дээд боловсролын салбарт хүмүүнлэгийн ухаан, биеийн тамир, спорт, байгаль хамгаалал, хууль эрхзүйн мэргэжилтнүүд, мэргэжлийн боловсролын салбарт байгаль хамгаалал, аялал жуулчлал, холбооны салбарын мэргэжилтэй ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт нь бусад мэргэжлийн

чиглэлүүдтэй харьцуулахад бага байгаа юм.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх нааштай үр дүнгүүдийн нэг нь тогтвортой хөдөлмөр эрхлэлт болон ажлын байрны шилжилт хөдөлгөөн бага явдал байлаа. Ялангуяа ИДС төгсөгчид МСҮТ төгсөгчидтэй харьцуулахад илүү тогтвортой ажиллаж байгаа дүр зураг гарсан ба МСҮТ төгсөгчдийн тогтвортой бус хөдөлмөр эрхлэлтэд сургуульд суралцах хугацааны хөдөлмөр хөдөлмөрийн бэлтгэл, ажлын байрны нөхцөл, орчин сайн биш, ажлын байрны нийлүүлэлт хангалттай, хугацааны хүчин зүйлээс хамааралтай ажлын байранд нийцдэг ур чадварууд эзэмшсэн байдаг зэрэг олон нөхцөл байдал нөлөө үзүүлдэг.

Тус судалгаанд төгсөгчдийн одоогийн хөдөлмөр эрхлэлт болон нийт хөдөлмөр эрхлэлт буюу ажлын туршлага гэсэн хоёр түвшинг авч үзсэн. Сургууль төгсөөд удаагүй залуус учраас хөдөлмөрийн баян түүх хуримтлуулж чадаагүй нь тодорхой юм. Гэвч нийт төгсөгчдийн j нь огт ажил хийж үзээгүй байгаа нь анхаарал татсан үр дүн байлаа. Иймд судалгааны энэхүү үр дүнд тулгуурлан ажлын туршлагагүй бүлгийн онцлогийг тодорхойлох, ажилгүйдлийн шалтгааныг тогтоох чанарын судалгаа хийж, судалгааны үр дүнг бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлэх хэрэгцээ байна.

Сургууль төгссөнөөс хойшхи хугацаа уртсах тусам өөрийн мэргэжлийн дагуу, хүсч байсан ажлын байрандаа орох боломж нэмэгдэж байгаа зүй тогтол ажиглагдсан. Тухайлбал төгссөнөөс хойш 13 ба түүнээс олон сарын дараа 34.5 хувь нь тогтвортой ажиллаж чадах ажлын байранд орсон талаар мэдээллэсэн.

Эзэмшсэн мэргэжил, суралцсан сургууль сонголтын тухайд субъектив хандлага давамгайлж байна. Сонирхдог мэргэжлийг нь тухайн сургууль бэлтгэдэг байдал, суурь боловсролын сурлагын голч дүн, элсэлтийн

шалгалтын оноо зэрэг нь сургууль сонголтод хамгийн хүчтэй нөлөөлдөг байхад, мэргэжлээ сонгохдоо өөрийн сонирхол, эцэг эхийн санал зэрэгт илүү их ач холбогдол өгдөг хандлагууд нийтлэг байна. МСҮТ төгсөгчдийн тухайд мэргэжлээ сонгохдоо илүү их субъектив хандлагаар ханддаг болох нь харагдсан.

Суралцан төгссөн сургуулийн сургалтын орчин нөхцөл болон сургалтын үйл явцын талаарх сэтгэл ханамжийг судлан үзсэн. Төгсөгчид сургалтын үйл явцад, ялангуяа багш нарын хичээл заах арга барил, хичээл зүтгэлд сэтгэл ханамж өндөр байгаа ч сургалтын материаллаг бааз, хэрэгслэл, сургалтын орчинд сэтгэл дундуур явдаг болохыг илэрхийлсэн. Иймд сургалтын байгууллагуудын сургалтын орчин нөхцөлд анхаарах, улмаар төгсөгчдийг суралцах хугацаанаас нь эхлэн ажлын байртай холбож өгөх дорвитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Хөдөлмөрт бэлтгэх үйл явцын талаар “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-нд тодорхой авч үзсэн. Сургуульд суралцах хугацаандаа ажил хийж дадал, туршлага хуримтлуулах, тодорхой хүндрэл бэрхшээлүүдийг туулж хөдөлмөрийн харилцааг ойлгох, хамт олонтой байж багаар ажиллаж сурах хэлбэр, сургуулиас болон хөдөлмөрийн байгууллагаас явуулдаг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд оролцох, энэ төрлийн мэдээ, мэдээллийг олж авч ашиглах хэлбэр зэрэг нь бүгд өөрийгөө ажил хөдөлмөрт бэлтгэж буй хэлбэрүүд юм.

Монгол улсын оюутан залуусын хамгийн нийтлэг ажил хөдөлмөрийн бэлтгэлийн хэлбэр нь сургуульд суралцах хугацааны хөдөлмөр эрхлэлт байгаа хэдий ч өргөн хүрээг хамарч чаддаггүй. Энэ нь нэг талаас оюутан залуусын ажил хийх хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагатай холбоотой ч, нөгөө

талаас зах зээлд тэдэнд тохирох ажлын байр хангалттай байдаггүй, ажил хийхэд нь дэмжлэг үзүүлдэг мэргэжлийн байгууллагууд цөөн, үйл ажиллагаа нь хүртээмжтэй биш байдаг зэрэг хувь хүнээс хамаарахгүй хүчин зүйлстэй холбоотой.

Сургуульд суралцах хугацаанд ажил хийсэн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн үндсэн шалтгаан нь өдөр тутмын хэрэглээний мөнгө олохтой холбоотой байдаг учраас суралцаж буй мэргэжилтэй адил, эсвэл ойролцоо ажил хийх нь тийм ч чухал ач холбогдолтой биш байдаг байна. Гэсэн хэдий ч энэхүү эрт хөдөлмөр эрхлэлт нь залуус мэргэжлийн ур чадвар эзэмших, суралцахаас илүүтэйгээр хөдөлмөрийн харилцаанд суралцаж, хөдөлмөрийн хандлагыг төлөвшүүлэх анхны алхам хийж байгаа гэдэг утгаараа цаашдын ажил хөдөлмөрт нь тодорхой хувь нэмэр оруулах сайн талтай.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, онцлогийг тэдний ажилладаг ажлын байрны мэдээллээр дамжуулан судалсан.

Монгол улсын нийт аж ахуйн нэгж байгууллагын ажилтны тооны бүтэцтэй харьцуулахад төгсөгчид харьцангуй олон ажилтантай ААНБ-д ажилладаг ба хувийн өмчийн сургууль төгсөгчдөөс төрийнхөн, МСҮТ төгсөгчдөөс ИДС төгсөгчид илүү олноор томоохон ААНБ-д ажилладаг. Дийлэнх олонх буюу 94.4 хувь нь цалин хөлстэй ажилтны статустайгаар хөдөлмөр эрхэлдэг хэдий ч, тэдний 80.1 хувь нь хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа юм. Үүнээс ажил хийдэг төгсөгчдийн 20 орчим хувь нь албан бусаар хөдөлмөр эрхэлж, цаашлаад хөдөлмөрийн харилцааны хүндрэл бэрхшээлтэй тулгарах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байна гэсэн үг юм.

Төгсөгчдийн ажил, амралтын цаг, өдөр нь хэвийн хэмжээнээс дээгүүр байгаа ч ажилласан жил, ур чадварын нэмэгдэл

гэх мэт нэмэлт цалингийн хэлбэрүүд үйлчилдэггүйтэй холбоотойгоор сарын дундаж орлого, цалин нь албан ёсны статистикаар зарласан улсын дунджаас доогуур байна.

Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг эзэмшсэн боловсрол, мэргэжил, ур чадвартай нь хэр нийцдэг болохыг судалсан ба төгсөгчид ажил үүрэг болон боловсролын түвшингийн талаар илүү өөдрөг бодолтой явдаг байхад мэргэжил, ур чадварын нийцтэй байдалд тийм ч сэтгэл хангалуун байдаггүй нь тодорхойлогдсон. Ялангуяа хамгийн нийтлэг тулгарч буй ур чадварын хомсдолууд нь багаар ажиллах чадвар, мэдээллийн технологийн хэрэглээ, харилцааны ур чадвар, гадаад хэлний мэдлэг гэх мэт байгаа эдгээр ур чадваруудыг нэг талаас олон ажил мэргэжлийн хүрээнд хэрэглэгддэг учраас түгээмэл тохиолддог гэж үзэж болох ч, нөгөө талаас нэн тэргүүнд эзэмших, төлөвшүүлэх шаардлагатай ур чадварууд гэж нэрлэхэд буруудахгүй болов уу. Ялангуяа харилцааны ур чадвар нь ажлын байранд дасан зохицоход их нөлөөлдөг, өөрөөр хэлбэл хамт ажиллагсад, удирдлагатай харилцах харилцаанд энэ ур чадвар хамгийн том бэрхшээл болдог талаар төгсөгчид мэдээллэсэн.

Эзэмшсэн мэргэжил, эрхэлж буй ажлын ажил үүргийн нийцтэй байдлын түвшнээр төгсөгчдийн мэргэжлээрх хөдөлмөр эрхлэлтийг тандан үзэхэд нийт төгсөгчдийн 4/1 нь мэргэжлийн бус ажил хийж байгаа гэсэн тооцоо гарсан. Мэргэжлийн бус ажил хийх байдалд эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах хүсэл сонирхолгүй, мэргэжлийн дагуух ажил олдохгүй, өөр мэргэжлийнх ч гэсэн илүү сайн нөхцөлтэй ажил байсан зэрэг олон хүчин зүйл нөлөөлж болох ч мэргэжлийн боловсролын салбарт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, ойн аж ахуй, мод боловсруулалтын салбарын мэргэжил, дээд боловсролын салбарт нийгмийн халамж-

хангамж, хууль эрхзүй, хүмүүнлэг, байгаль хамгааллын мэргэжлүүдийн нийлүүлэлтэд анхаарал хандуулах шаардлага байгааг судалгааны үр дүн сануулж байна.

Манай улсын нийт эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад хөдөлмөрийн нөөцийн сэлгэлт их зөрүүтэй байгаа ба төгсөгчид цөөн хэдэн тооны салбаруудад тархан ажиллаж байна. Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх салбаруудад төвлөрсөн, ялангуяа уул уурхайн салбарт их хэмжээний нийлүүлэлт хийгдсэн байгаа нь сонирхолтой үр дүнгүүдийн нэг байлаа. Усан хангамж, үл хөдлөх хөрөнгө, олон улсын байгууллагын үйл ажиллагаа гэх мэт ажлын туршлага, нарийн мэргэжлийн ур чадвар илүү шаардлагатай салбаруудад төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт тун бага байгаа юм.

Төгсөгчдийн эдийн засгийн үйл ажиллагааны оролцооны талаарх хэтийн төлөвлөгөөнөөс харахад ажил хийж буй төгсөгчдийн олонх нь ажлаа үргэлжлүүлэн хийх, ажил хийгээгүй төгсөгчдийн олонх нь ажил хийх төлөвлөгөөгүй байгаа нь ажиглагдсан. Ажлаа үргэлжлүүлэн хийх бодолтой төгсөгчид ажилдаа сэтгэл хангалуун учраас тогтвортой ажиллах бодолтой байгаа гэж үзэж болох юм. Харин ажил хийхгүй шалтгаан олон хэдий ч ажил хийгээгүй төгсөгчдийн тухайд ажил олдохгүйн улмаас итгэл суларч, ирээдүйгээ төлөвлөж чадахгүй байх талтай учраас хөдөлмөрт бэлтгэх сургалт, үйл ажиллагаагаар дэмжих замаар идэвхижүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 1. СУРАЛЦАХ ХУГАЦААНЫ АЖЛЫН ТҮРШЛАГА, МЭРГЭЖЛИЙН НИЙЦЭЛ

/мэргэжлийн чиглэл, сургуулийн төрөл тус бүрээр/

Хэмжих нэгж: хувиар

Сургуулийн төрөл	Мэргэжлийн чиглэл	ОГ тохирлог	Тохирлоггүй	Дунд зэрэг	Тохирлог	Маш сайн тохирлог
ИДС	Багш боловсрол судлал	29.2	16.7	16.7	25.0	12.5
	Урлаг	26.5	5.9	14.7	29.4	23.5
	Хүмүүнлэгийн ухаан	56.0	4.0	16.0	20.0	4.0
	Нийгэм, эдийн засаг	61.1	5.6	16.7	11.1	5.6
	Мэдээлэл, сэтгүүл зүй	31.3	6.3	25.0	25.0	12.5
	Бизнес удирдлага	39.1	17.4	8.7	21.7	13.0
	Хууль эрхзүй	42.4	9.1	9.1	15.2	24.2
	Биологи	20.6	17.6	14.7	14.7	32.4
	Физик, хими, геологи, газарзүй	48.4	16.1	12.9	12.9	9.7
	Математик статистик	30.8	23.1	11.5	19.2	15.4
	Компьютер	40.9	15.9	11.4	13.6	18.2
	Бүх төрлийн инженер	30.6	11.1	22.2	22.2	13.9
	Үйлдвэрлэлийн технологи	25.0	27.1	10.4	14.6	22.9
	Барилга, архитектур	31.0	21.4	7.1	16.7	23.8
	ХАА, ой, загасны аж ахуй	54.5	0.0	22.7	9.1	13.6
	Мал эмнэлэг	39.5	13.2	18.4	5.3	23.7
	Анагаах ухаан	29.2	8.3	12.5	25.0	25.0
	Нийгмийн халамж, хангамж	18.8	25.0	25.0	18.8	12.5
	Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ	35.5	19.4	16.1	19.4	9.7
	Тээвэр болон бусад	35.7	14.3	14.3	35.7	0.0
	Байгаль хамгаалал	50.0	8.3	16.7	12.5	12.5
	Цэрэг, цагдаа, аюулгүй байдал	14.0	10.0	6.0	8.0	62.0
	МСҮТ	Барилга, автозам, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар	2.2	3.6	3.1	32.0
ХАА-н үйлдвэрлэлийн салбар		12.5	0.0	16.7	37.5	33.3
Ойн аж ахуй, мод боловсруулалтын салбар		6.7	33.3	40.0	13.3	6.7
Байгаль хамгаалагч, аялал жуулчлалын салбар		0.0	30.0	30.0	20.0	20.0
Тээврийн салбар		30.2	31.5	22.1	12.8	3.4
Холбооны салбар		100.0	0.0	0.0	0.0	0.0
Мэдээллийн технологийн салбар		23.5	35.3	17.6	5.9	17.6
Аж үйлдвэрийн салбар		39.1	18.8	4.3	20.3	17.4
Геологи, уул уурхайн салбар		46.2	11.5	26.9	7.7	7.7
Захиргааны үйлчилгээний ажилтан		21.4	16.7	2.4	16.7	42.9
Соёл урлагын салбар	20.0	10.0	0.0	20.0	50.0	
ДУНДАЖ		33.1	14.7	14.9	17.6	19.7

ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 2. АЖИЛД ОРОХОД АНХААРДАГ ХҮЧИН ЗҮЙЛ

/сургуулийн төрөл, мэргэжлийн чиглэл тус бүрээр/

Сургуулийн төрөл	Мэргэжлийн чиглэл	Цалин	Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал	Байгууллагын нэр	Ажлын чиг үүргийн хүндрэл	Ажлын нягтлаг	Өсөн хөгжих боломж	Ажлын мэргэжлийн нийлвэр	Ажлын цаг	Ажлын гэрээний хөрөнгийн зай	Хувьцаачдын хувийн хэсэг
ИДС	Багш боловсрол судлал	3.4	3.7	3.5	3.2	3.3	3.8	4.0	3.5	3.3	3.2
	Урлаг	3.9	3.0	3.6	2.8	3.6	4.6	4.6	3.2	2.4	3.0
	Хүмүүнлэгийн ухаан	4.0	4.0	3.6	4.0	3.8	4.0	4.0	3.8	3.0	3.5
	Нийгэм, эдийн засаг	4.6	4.4	4.5	4.6	4.1	4.8	4.7	4.5	3.6	3.7
	Мэдээлэл, сэтгүүл зүй	4.8	4.3	4.1	3.8	3.9	4.5	4.5	3.6	3.2	3.5
	Бизнес удирдлага	4.0	4.2	4.0	3.7	3.4	4.1	3.9	3.4	3.0	3.4
	Хууль эрхзүй	3.8	3.9	3.6	3.4	3.6	4.0	4.1	3.6	2.9	3.4
	Биологи	3.7	4.1	4.1	3.9	3.5	3.5	4.0	4.1	4.1	3.6
	Физик, хими, геологи, газарзүй	4.0	4.2	4.1	4.1	3.9	4.6	4.6	4.3	4.2	3.4
	Математик статистик	4.2	3.8	3.9	3.9	4.0	4.7	4.3	4.3	4.0	3.1
	Компьютер	3.7	3.7	3.5	3.4	3.1	3.8	4.0	3.2	3.1	3.4
	Бүх төрлийн инженер	4.1	4.3	4.2	3.7	3.9	4.3	4.4	3.8	3.2	3.5
	Үйлдвэрлэлийн технологи	4.1	3.9	4.1	4.0	3.9	4.3	4.3	3.9	3.6	3.8
	Барилга, архитектур	4.5	4.5	3.8	3.9	3.8	4.3	4.4	3.6	2.3	2.9
	ХАА, ой, загасны аж ахуй	4.1	3.9	3.3	3.6	3.6	3.9	4.0	3.8	3.2	3.1
	Мал эмнэлэг	3.6	3.8	4.0	3.4	3.3	3.8	4.1	3.0	2.5	3.0
	Анагаах ухаан	3.8	3.9	3.8	3.4	3.4	4.2	4.2	3.9	2.9	2.8
	Нийгмийн халамж, хангамж	4.0	4.1	3.7	3.3	3.1	4.2	4.2	3.1	2.7	3.1
	Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ	4.5	4.6	4.6	4.0	3.8	4.8	4.0	3.7	3.5	3.8
	Тээвэр болон бусад	4.3	4.6	4.5	3.9	3.7	4.4	4.6	4.2	3.0	3.3
Байгаль хамгаалал	3.9	4.1	3.9	4.1	3.6	4.2	3.9	3.5	3.8	3.9	
Цэрэг, цагдаа, аюулгүй байдал	4.1	4.0	4.1	3.4	3.6	3.9	4.3	4.1	3.3	3.5	

МСҮТ	Барилга, автозам, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар	3.9	3.9	3.4	3.6	3.7	3.8	4.3	3.6	3.4	3.9
	ХАА-н үйлдвэрлэлийн салбар	4.5	4.8	3.8	3.6	3.0	3.5	3.4	2.8	2.8	3.3
	Ойн аж ахуй, мод боловсруулалтын салбар	4.3	4.0	4.0	3.7	3.5	4.0	4.0	3.4	3.5	3.3
	Тээврийн салбар	4.6	4.3	4.0	4.3	3.4	4.6	3.9	3.3	2.8	3.3
	Холбооны салбар	4.3	3.3	3.5	3.5	3.5	4.5	5.0	3.0	3.0	4.0
	Мэдээллийн технологийн салбар	4.5	5.0	4.0	4.5	3.8	4.0	3.8	3.8	3.3	3.7
	Аж үйлдвэрийн салбар	4.3	4.6	3.7	3.9	3.6	4.5	3.2	4.0	3.0	4.0
	Геологи, уул уурхайн салбар	4.8	4.3	4.0	4.4	3.9	3.9	4.1	4.5	4.2	4.3
	Захиргааны үйлчилгээний ажилтан	3.7	3.3	3.5	3.3	3.6	3.9	3.9	3.7	3.3	3.5
	Соёл урлагын салбар	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	3.3

ХАВСРАЛТЫН ХҮСНЭГТ 3. ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖИЛ, АЖИЛЛАДАГ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН ХАРЬЦУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

/сургуулийн төрлөөр/

Сургуулийн төрөл	Мэргэжлийн чиглэл, салбар	ХАА	Үүн уурхай	Үйлдвэрлэл	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Үснэ хангамж	Барилга	Худалдаа	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	Зочид буудал, зоогийн газар	Мэдээлэл, холбоо	Санхүү, даатгалын үйл ажиллагаа	Үл хөдлөх хөрөнгө	Мэргэжлийн шинжлэх ухаан	Үйлдвэр, тэмдэглэгээ үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн үйлдвэрлэл	Боловсрол	Хүний эрүүл мэнд	Үргэлжлэг үйлдвэр, торлоом	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Хүн хөдөлгөөний ажлын үйлдвэрлэл	ОУ-ын байгууллага, гурвир төлөөлөгчийн газар	Бүтэц	Бүтэц/нийт дүнд эзлэх хувь
ИДС	Балч боловсрол судлал	428	2141	107	0	0	0	107	0	0	0	0	0	0	0	0	1392	0	0	0	0	0	4176	12.3
	Урлаг	0	438	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	26	0	0	13	0	0	0	477	1.4
	Хүмүүнлэгийн ухаан	90	993	0	0	0	0	0	0	0	45	45	0	0	0	90	0	0	0	0	0	0	1263	3.7
	Нийгэм, эдийн засаг	178	2192	118	0	0	0	0	0	0	0	59	0	0	0	59	59	0	0	0	0	0	2666	7.8
	Мэдээлэл, сэтгүүл зүй	25	459	0	0	0	0	12	0	0	12	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	508	1.5
	Бизнес удирдлага	134	4275	134	0	0	0	267	0	134	83	0	267	0	0	42	291	0	0	0	0	0	5344	15.7
	Хууль эрх зүй	0	749	42	0	0	0	0	0	83	0	0	0	0	0	16	32	0	0	0	0	0	1290	3.8
	Биологи	32	475	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	14	9	0	0	0	0	570	1.7
	Физик хими, геолог, газарзүй	9	130	0	0	0	0	14	0	0	0	0	0	0	0	0	5	0	0	0	0	0	176	0.5
	Математик	0	163	0	0	0	0	0	0	0	0	5	0	0	0	15	5	0	0	0	0	0	197	0.6
	Статистик	87	522	17	0	0	0	0	0	0	17	0	0	0	0	17	0	0	0	0	0	0	679	2.0
	Компьютер	358	566	30	0	0	0	30	0	30	0	30	0	0	60	0	30	0	0	30	0	0	1162	3.4
	Бүх төрлийн инженер	206	231	13	0	0	0	26	0	0	0	13	0	0	0	0	13	0	0	0	0	0	501	1.5
	Үйлдвэрлэлийн технологи	23	201	0	0	0	0	23	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	247	0.7
	Барилга, архитектур	37	324	25	0	0	0	25	0	0	0	0	12	0	12	0	25	12	0	0	0	0	474	1.4
	ХАА, ой, загасны аж ахуй	27	73	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	6	0	0	0	0	0	0	118	0.3
	Мал эмнэлэг	74	1405	0	0	0	0	37	0	0	0	0	0	0	0	0	0	0	74	0	0	0	1590	4.7
	Анагаах ухаан	17	186	0	0	0	0	8	0	0	0	8	0	0	0	59	8	0	8	0	0	0	295	0.9
	Нийгмийн халамж, хангамж	14	375	0	0	0	0	14	0	0	0	0	0	0	0	29	29	0	14	0	0	0	476	1.4
	Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ	6	26	1	0	0	1	0	2	0	0	0	1	0	0	3	0	0	0	0	0	0	41	0.1
Тээвэр болон бусад	2	52	0	0	0	0	2	0	0	0	0	2	0	4	6	2	2	0	2	0	0	73	0.2	
Байгаль хамгаалал	0	417	0	0	0	0	17	0	0	0	0	0	0	0	191	35	0	0	0	0	0	660	1.9	
Цэрэг, цагдаа, аюулгүй байдал																								

МСҮТ	Бүгд дүнд эзлэх хувь																						
	10.8	68.4	2.2	0.1	0.0	1.3	3.0	0.3	1.5	0.8	1.2	0.0	0.6	1.0	2.9	5.2	0.3	0.1	0.1	0.2	0.0	100.0	
Берилтэ, автозам, берилтэн материалын үйлдвэрлэлийн салбар	458	2570	141	0	0	282	106	35	70	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	3766	11.1
ХАА-н үйлдвэрлэлийн салбар	75	523	0	0	0	0	0	0	75	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	672	2.0
Ойн аж ахуй, мод боловсруулалтын салбар	109	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	109	0.3
Байгаль хамгаалагч, аялал жуулчлалын салбар	0	82	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	82	0	0	0	0	0	165	0.5
Тээврийн салбар	227	831	0	38	0	0	151	0	76	38	0	0	0	38	38	38	0	0	0	0	0	1472	4.3
Холбооны салбар	0	54	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	54	0.2
Мэдээллийн технологийн салбар	158	475	0	0	0	79	0	0	0	79	0	0	0	79	0	0	0	0	0	0	0	870	2.6
Аж үйлдвэрийн салбар	850	1133	106	0	0	0	35	0	35	0	0	0	0	0	35	0	0	0	0	0	0	2195	6.4
Геолог, уул уурхайн салбар	45	537	0	0	0	22	89	22	0	0	0	0	0	0	45	0	0	0	0	0	0	760	2.2
Захираганы үйлчилгээний ажилтан	26	581	26	0	0	0	106	26	53	26	0	0	0	0	26	26	0	0	0	0	0	898	2.6
Соёл урлагын салбар	0	98	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	98	0.3
Бүгд	3693	23275	760	38	0	449	1005	116	526	261	400	0	214	327	978	1777	85	36	32	70	0	34043	100.0

ХАВСРАЛТЫН ХҮСНЭГТ 4. ТӨГСӨГЧДИЙН АЖИЛ ҮҮРЭГ, ЭЗЭМШСЭН МЭРГЭЖЛИЙН НИЙЦТЭЙ БАЙДАЛ /МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ ТҮС БҮРЭЭР

/ Хэмжих нэгж: Тоо, хувиар

Сурдлуудын төрөл	Мэргэжлийн чиглэл, салбар	Бүгд / тоо/	ОТТ тохирдоггүй		Тохирдоггүй		Дунд зэрэг		Тохирдог		Маш сайн тохирдог	
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
	Багш боловсрол судлал	4176	214	5.1	428	10.3	642	15.4	1499	35.9	1392	33.3
	Урлаг	477	13	2.7	13	2.7	90	18.9	271	56.8	90	18.9
	Хүүмүлнлгийн ухаан	1263	271	21.4	135	10.7	316	25.0	406	32.1	135	10.7
	Нийгэм, эдийн засаг	2666	0	0.0	59	2.2	592	22.2	1244	46.7	770	28.9
	Мэдээлэл, сэтгүүл зүй	508	0	0.0	25	4.9	99	19.5	236	46.3	149	29.3
	Бизнес удирдлага	5344	401	7.5	1069	20.0	1737	32.5	1737	32.5	401	7.5
	Хууль эрхзүй	1290	250	19.4	166	12.9	208	16.1	499	38.7	166	12.9
	Биологи	570	32	5.6	48	8.3	79	13.9	238	41.7	174	30.6
	Физик, хими, геологи, газарзүй	176	19	10.5	33	18.4	9	5.3	74	42.1	42	23.7
	Математик статистик	197	20	10.0	35	17.5	39	20.0	74	37.5	30	15.0
	Компьютер	679	35	5.1	17	2.6	122	17.9	435	64.1	70	10.3
	Бүх төрлийн инженер	1162	60	5.1	149	12.8	268	23.1	477	41.0	209	17.9
	Үйлдвэрлэлийн технологи	501	116	23.1	26	5.1	90	17.9	257	51.3	13	2.6
	Барилга, архитектур	247	6	2.3	17	7.0	46	18.6	120	48.8	57	23.3
	ХАА, ой, загасны аж ахуй	474	75	15.8	62	13.2	175	36.8	162	34.2	0	0.0
	Мал эмнэлэг	118	6	5.1	18	15.4	45	38.5	36	30.8	12	10.3
	Анагаах ухаан	1590	74	4.7	111	7.0	222	14.0	850	53.5	333	20.9
	Нийгмийн халамж, хангамж	295	42	14.3	84	28.6	25	8.6	118	40.0	25	8.6
	Биеийн тамир, спорт, зарим төрлийн үйлчилгээ	476	58	12.1	14	3.0	187	39.4	187	39.4	29	6.1
	Тэвээр болон бусад	41	2	5.6	13	30.6	9	22.2	10	25.0	7	16.7
	Байгаль хамгаалал	73	17	23.7	6	7.9	11	15.8	23	31.6	15	21.1
	Цэрэг, цагдаа, аюулгүй байдал	660	52	7.9	17	2.6	139	21.1	330	50.0	122	18.4

ИДЭ

МСҮТ	Барилга, автозам, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар	3766	880	23.4	282	7.5	739	19.6	1478	39.3	387	10.3
	ХАА-н үйлдвэрлэлийн салбар	672	224	33.3	149	22.2	75	11.1	149	22.2	75	11.1
	Ойн аж ахуй, мод боловсруулалтын салбар	109	73	66.7	0	0.0	36	33.3	0	0.0	0	0.0
	Байгаль хамгаалагч, аялал жуулчлалын салбар	165	82	50.0	0	0.0	0	0.0	82	50.0	0	0.0
	Тээврийн салбар	1472	302	20.5	302	20.5	227	15.4	227	15.4	415	28.2
	Холбооны салбар	54	54	100.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
	Мэдээллийн технологийн салбар	870	316	36.4	79	9.1	237	27.3	237	27.3	0	0.0
	Аж үйлдвэрийн салбар	2195	566	25.8	71	3.2	496	22.6	602	27.4	460	21.0
	Геологи, уул уурхайн салбар	760	201	26.5	89	11.8	224	29.4	157	20.6	89	11.8
	Захираганы үйлчилгээний ажилтан	898	185	20.6	132	14.7	264	29.4	238	26.5	79	8.8
	Соёл урлагын салбар	98	0	0.0	0	0.0	0	0.0	49	50.0	49	50.0
	Бүгд /тоо, дундаж хувь/	34043	4645	18.5	3650	10.1	7450	19.7	12503	36.3	5796	15.4

21	Шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн	0	90	135	0	12	0	42	285	37	25	104	536	167	218	187	3	0	0	14	3	15	35	70	0	0	0	0	0	158	0	45	26	0	2210	6.5	
22	Эрүүл мэндийн мэргэжилтэн	0	0	0	0	0	0	0	16	9	5	0	0	6	0	73	1072	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1181	3.5	
23	Багшлах мэргэжилтэн	3105	26	180	0	0	42	111	42	20	35	60	6	37	15	185	17	72	0	2	35	0	75	82	38	0	0	0	0	0	0	0	0	4183	12.3		
24	Бизнес захиргааны мэргэжилтэн	107	0	2133	62	1069	42	0	5	20	0	13	0	12	0	17	43	1	4	17	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	26	0	3571	10.5		
25	Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн	0	0	45	0	0	0	0	0	0	5	348	89	0	0	74	0	43	0	0	0	0	35	0	0	0	0	0	0	0	0	0	0	640	1.9		
26	Хууль, нийгэм, соёлын мэргэжилтэн	107	219	226	178	335	668	291	48	9	25	0	30	0	12	6	37	110	29	0	4	104	0	0	0	0	0	38	0	79	0	22	26	98	2701	7.9	
31	Шинжлэх ухаан, инженерийн туслах/дад мэргэжилтэн	0	0	45	0	0	0	0	32	0	5	60	26	0	12	3	0	0	1	0	17	0	0	0	0	0	0	0	0	0	35	22	0	0	259	0.8	
32	Эрүүл мэндийн туслах/дад мэргэжилтэн	0	0	0	0	0	134	42	0	5	0	0	0	0	0	3	74	0	0	0	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	53	0	312	0.9		
33	Бизнесийн болон захиргааны туслах/дад мэргэжилтэн	107	0	90	0	0	83	0	5	20	0	13	0	25	0	0	0	2	8	122	35	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	509	1.5		
34	Хууль, нийгэм, соёл, тэдгээрт холбогдох бусад туслах/дад мэргэжилтэн	0	13	0	0	0	0	0	0	5	17	0	51	0	0	0	17	58	0	0	0	35	0	0	0	0	0	0	0	0	35	0	0	232	0.7		
35	Мэдээлэл, холбооны техникч	0	39	0	0	12	0	0	0	5	0	52	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	38	0	79	0	0	226	0.7	
41	Конторын үндсэн болон гүйцэтгэх ажилтан	107	0	0	0	0	208	0	0	10	0	0	0	25	0	37	17	0	1	0	17	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	422	1.2		
42	Хэрэглэгч/дэд үйлчлэх ажилтан	107	13	45	237	12	1069	0	0	5	20	17	0	13	0	12	0	14	5	6	17	0	0	0	0	0	0	0	0	0	0	26	0	1619	4.8		
43	Тооцоолол, материал бүртгэлийн ажилтан	0	0	90	59	0	534	125	0	9	0	0	6	25	0	0	17	14	5	0	17	0	0	0	0	0	0	0	0	0	22	0	0	924	2.7		
44	Конторын бусад туслах ажилтан	107	0	135	0	0	0	42	0	5	0	0	0	0	0	17	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	306	0.9		
51	Хувийн үйлчилгээний ажилтан	0	13	0	0	0	0	42	0	5	5	30	64	0	3	0	8	43	1	8	0	352	149	0	113	0	79	602	45	238	0	1800	5.3				
52	Борлуулалтын ажилтан	107	26	45	0	25	668	0	0	23	15	35	30	51	0	12	6	0	8	43	2	8	0	317	0	0	0	0	227	0	79	248	89	238	0	2302	6.8
53	Хувь хүн асрамжлах үйлчилгээ	0	0	45	0	0	0	0	0	0	17	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	137	0.4		
54	Хамгаалах үйлчилгээний ажилтан	0	0	0	0	0	0	42	16	5	0	0	0	0	0	0	0	29	1	4	226	106	0	113	0	0	106	45	0	0	0	691	2.0				
61	Зах зээлд чиглэсэн хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан	0	0	45	0	0	0	0	0	0	0	0	0	0	12	0	0	8	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	141	0.4			

